THE JOURNALISM FOR DEVELOPMENT

# ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ

Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр дагнан бичиж буй сэтгүүлчдийг өндөр түвшинд мэргэшүүлэх, салбарын тухай хамгийн сүүлийн үеийн мэдээллээр хангах, уул уурхайн үйл ажиллагааг газар дээрээс нь сурвалжлах боломж олгох, олон улсын санхүүгийн байгууллагууд, мэдээллийн нэр хүндтэй редакциудад танилцах аялал зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байна.

Сургалтад үндэсний хэмжээний томоохон мэдээллийн байгууллагын сэтгүүлчид, түүнчлэн орон нутгийн телевиз, сонин, радиогийн удирдах ажилтнууд, сурвалжлагчид өргөнөөр хамрагддаг.

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” төрийн бус байгууллага нь сэтгүүлчдийг мэргэшүүлэх сургалтуудаа үнэ төлбөргүй явуулж байна.

# ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь 2010 онд The Mongolian Mining Journal-ын дэргэд, тус редакцын санаачлагаар байгуулагдсан, ашгийн бус, мэргэжлийн сэтгүүл зүйн үйл ажиллагааг дэмжих зорилготой.

# THE JOURNALISM FOR DEVELOPMENT

Journalism for Development was founded by the Mongolian Mining Journal as a non-profit NGO to support professional journalism.

Сэтгүүл зүйн мэргэжлийн стандартыг өргөх, ажил үүргээ гүйцэтгэж яваа жирийн сурвалжлагчдыг хөгжүүлж, мэргэшүүлэх гэсэн Mongolian Mining Journal-ын сэтгүүлчдийн тэмүүлэл “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй”-г төрүүлсэн юм. Уул уурхай, эдийн засгийн асуудлаар хамгийн их ярьж, бичиж, бас маргаж байгаа өнөө цагт ММJ-ийн сэтгүүлчдэд салбарыг ойлгох, шинэ шинэ мэдлэг, ойлголтыг танин мэдэх, тэр хэрээр олон нийтэд зөв мэдээлэл түгээх шаардлага өдөр бүр тулгардаг.

ММJ-ийнхэн сэтгүүл зүйн өргөн фронтод мөр зэрэгцэн зүтгэж яваа үзэг нэгтнүүдтэйгээ хамтдаа сурах, хөгжихийн тулд “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй”-г 2010 онд байгуулсан билээ.

## ABOUT JOURNALISM FOR DEVELOPMENT

Journalism for Development is a non-Government organization founded at the initiative of the journalists at The Mongolian Mining Journal in 2010. It has been operating since then to provide training courses for local journalists covering developments in mining and the economy on how to collect and use up-to-date information, and to write on-site reports. They have been taken to international financial organisations and news studios to get an idea of how these work.

In the 8 years since its establishment Journalism for Development NGO has arranged more than 20 seminars and trainings within the country and outside. A 2010 study trip to the Hong Kong Stock Exchange was very helpful for Mongolian journalists in gaining an understanding of how a stock exchange works, and they, in turn, could explain this more knowledgably to readers of the print media and TV viewers. That year, when Mongolians were waking up to the concept of stock markets, the seminars successfully organized by this NGO became a valuable and efficient tool in enriching their understanding of how these work.

Along with organizing training courses, since 2010 Journalism for Development has been conducting several discussions and conferences in partnership with stakeholders in the mining, economic and information technology sectors covering topics of the day. Particularly successful among these were the discussion on a copper smelting plant in 2010 and a conference on “20 years of the new era in the Mongolian mineral sector” in 2013.

Another seminar held in Umnugovi aimag in 2010, the hub of mining activity in the country, deserves special mentionas it was the first one of its kind in the history of Mongolian media. It brought together journalists from all kinds of local media organisations to give them a basic understanding of the relation between the national economy and the mining sector.

A few years’ work on these lines led to the launch of the Local News Network project in 2015, which has been successfully conducting specialized training courses for local journalists for the fourth consecutive year now. The network comprises some 80 journalists from more than 40 media organizations in 21 aimags. Altogether 13 workshops have so far been held -- in Selenge, Bayankhongor, Uvurkhangai, Umnugovi and Ulaanbaatar City.

Intensive work by Journalism for Development in 2018 has resulted in the successful launch of two new programmes -- Journalists’ Mentorship and Specialized National Journalism.

Bolormaa Luntan, Founder of the Mongolian Mining Journal and the visionary behind Journalism for Development, dreamt of raising the standard of Mongolian journalism by training young journalists and having skilled and specialist journalists in every corner of the country. We have taken a few firm steps towards realizing her dream and are dedicated to strengthening and expanding the network.

## “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ”
## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь The Mongolian Mining Journal-ын дэргэд, тус редакцийн сэтгүүлч баг хамт олны санаачлагаар 2010 онд байгуулагдсан. Энэхүү ТББ нь сэтгүүлчдэд салбарын тухай хамгийн сүүлийн үеийн мэдлэг, мэдээлэл өгөх сургалт семинар хийх, уул уурхайн үйл ажиллагааг газар дээрээс нь сурвалжлах, олон улсын санхүүгийн байгууллагууд, түүнчлэн мэдээллийн нэр хүндтэй редакциудтай танилцах аялал зохион байгуулах зэргээр уул уурхай, эдийн засгийн чиглэлээр дагнан бичдэг сэтгүүлчдийг өндөр түвшинд мэргэшүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг.

Өнгөрсөн 8 жилийн хугацаанд “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын баг дотоод гадаадад нийт 20 гаруй сургалт, танилцах аялал зохион байгуулсан. Хонконгийн Хөрөнгийн биржийн тухай анхан шатны ойлголтыг Монголын сэтгүүлчдэд, улмаар уншигч, үзэгчдэд ойлгуулах аяллыг 2010 онд хийсэн бөгөөд IPO, хувьцааны арилжаа, санхүүгийн мэдээллийг хэрхэн бэлтгэх тухай шат дараалсан мэдлэг мэдээллийг хүргэх сургалтыг тасралтгүй явуулж ирэв. Эдгээр сургалт нь 2010 он буюу үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн тухай ойлголт Монголын нийгэмд төлөвшиж дөнгөж эхэлж байсан үед сэтгүүлчдэд анхан шатны мэдлэг өгснөөрөө үнэ цэнтэй, өндөр өгөөжтэй ажлууд болсон билээ.

Үүний зэрэгцээ тус байгууллага нь эдийн засаг, уул уурхай, мөн мэдээлэл технологийн салбарт тулгамдсан цаг үеийн асуудлаар оролцогч талуудын хамт төрөл бүрийн хэлэлцүүлэг, онол-практикийн хурал зохион байгуулж ирсэн. Үүнд, 2010 оны “Зэс хайлуулах үйлдвэрийг хаана байгуулах нь үр ашигтай вэ?”, 2013 оны “Эрдэс баялгийн салбарын шинэ үеийн 20 жил” зэрэг хэлэлцүүлэг-хурал багтана.

Уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж буй Өмнөговь аймгийн хэвлэл мэдээллийн бүх байгууллагын сэтгүүлч оролцсон сургалтаа “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” нь 2010 онд зохион байгуулсан бөгөөд орон нутгийн сэтгүүлчдэд эдийн засаг, уул уурхайн салбарын тухай ойлголт өгсөн анхны сургалтын ажил болсон гэдгээрээ Монголын хэвлэлийн түүхэнд үлдсэн үйл явдал юм. Энэ туршлагадаа үндэслэн 2015 онд “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийг эхлүүлж 4 жилийн турш орон нутгийн сэтгүүлчдийг чадавхжуулах сургалтыг тасралтгүй, амжилттай хэрэгжүүлж байна.

Төслийн үр дүнд 21 аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын 80 орчим сэтгүүлчийг хамруулсан идэвхтэй сүлжээ бий болсон юм. “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл хэрэгжсэн 4 жилийн хугацаанд нийт 13 удаагийн цуврал сургалтыг Сэлэнгэ, Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулсан.

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй”-н багийн үйл ажиллагаа улам идэвхжиж 2018 онд Сэтгүүлчдийн менторшип хөтөлбөр болон Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр сэтгүүлчийг чадавхжуулах хөтөлбөрийг тус тус амжилттай хэрэгжүүллээ.

The Mongolian Mining Journal-ыг үүсгэн байгуулагч Лунтангийн Болормаа агсан 2010 оноос хойш энэхүү Төрийн бус байгууллагаараа дамжуулан залуу сэтгүүлчдийг сурган дадлагажуулах, улмаар Монгол орны алслагдсан өнцөг бүрт мэргэшсэн чадварлаг сэтгүүлчдийн төлөөллийг бий болгох хүсэл эрмэлзлээ тээн ирсэн нь эдүгээ ийнхүү биеллээ олон, улам тэлж өргөжсөөр байна.

# ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ

Баруун гараас: сэтгүүлч Г.Идэрхангай, орлогч эрхлэгч Н.Ариунтуяа, ерөнхий эрхлэгч Л.Болормаа, менежер Л.Батбаяр

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ-ын нээлтийн хэвлэлийн хурал.

2010.05.25

Хөгжил дэвшлийнхээ замд орж буй шинэ Монгол орныхоо тухай нийтлэн, нэвтрүүлэх сэтгүүлч бидний хөдөлмөр улам бүр сонирхолтой, басхүү хариуцлагатай, мэдлэг мэдээлэл шаардсан ажил болсоор байна.

Өнөө цагийн өндөр мэдлэг боловсролтой үзэгч, уншигч олон түмний эрэлт хэрэгцээг хангасан бүтээгдэхүүн гаргахын тулд сэтгүүлч бидэнд өөрсдөө суралцах, хөгжиж дэвших хэрэгцээ тулгарсаар байгаа билээ.

Чухам энэхүү зорилгоос үүдэн "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" төрийн бус байгууллагыг хэвлэл мэдээллийн салбарынхан өөрсдийн санаачлагаар байгуулсан болно.

Тус байгууллага нь сэтгүүлчдийг сургах, хэвлэл мэдээллийн шинэ менежментийг дэмжин нэвтрүүлэх, технологийн шинэчлэлийн ажилд төрийн болон төрийн бус бусад байгууллагатай хамтран оролцох, сэтгүүлчдийн уран бүтээлийг хөхиүлэн дэмжих, эдийн засгийн сэдвээр бичих, нэвтрүүлэг бэлтгэхэд нь сэтгүүлчдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх зэрэг олон төрлийн ажлыг хийж эхлээд байна.

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" байгууллагын үйл ажиллагааны талаарх шинэ мэдээ, сургалтын зар болон холбогдох бусад мэдээллийг Та www.journalism.mn сайтаас тогтмол хүлээн авах боломжтой.

# THE JOURNALISM FOR DEVELOPMENT

Mongolian journalists find their work getting more and more interesting and challenging as they write and produce programs for the new Mongolia that is evolving. It now demands more responsibility, knowledge and information.

Realising that the changing needs of the times can be met only if our output has the quality to satisfy the discerning requirement of educated viewers and readers, some of us journalists have decided to improve our own skills. We have set up an NGO and named it Journalism for Development to provide us the tools for this.

The NGO will be offering journalists help in several areas, from training them in basic skills, to introducing new media management practices, and will collaborate with state organisations and other NGOs on matters of technological innovation, promoting journalists' work, and providing professional assistance to better write and produce programs on economic topics.

More information and details of training programs can be accessed from www.journalism.mn.

# МИНИЙ БИЗНЕС

Л. Болормаа, The Mongolian Mining Journal,
“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ

“Энэ давхар тэр чигээрээ танайх уу?” гэж байна. Сүхээ ахын эхний асуулт ийм. Би дотроо “ Иш, Сүхээ ах минь бүхэл бүтэн давхрыг түрээслэхийн тулд сард хэдэн сая төгрөг төлнө гэж Та бодож байна…” хэмээн чимээгүй уулгалж билээ. Unity Center нэртэй таван давхар хөөрхөн байшинд би анх удаа оффисийн өрөө түрээсэлж үзэж байгаа маань тэр ээ. Шинэ байшинд шинэ бизнесээ эхлүүлэх ёстой юм шиг санагдаад, өвлийн хүйтэн өдрүүдэд тэнэсээр яваад олсон газар маань байлаа. Хамт олон жил ажилласан андууд минь намайг эргэж ирж байгаа нь энэ.

Сэлбэ голын эрэг дэх наранд автсан ажлын өрөөндөө би одоо ч хайртай. Бизнесийн анхны өдрүүд тэнд өнгөрч, тааэнаас шал хүртэл цэлийсэн цонхтой саруулхан өрөө минь надад ургэлж илч гэрэл, эрчим дулаан өгч байсан. Хүйтэн зэрвэгэр өвлийн өдрүүдэд өглөөний нарны хүсэмжит туяа өрөөг нэвт бүлээцүүлэн, цонхоороо холыг харан суух сайхан. Арслантай гүүр, Богд уул тэр чигээрээ аквариум шиг цонхоор минь зураглал болно. Олон жил нөхөрлөсөн андууд хааяа нэг хүрэлцэн ирэхэд сандлын тоо дутах үе бий. Түрээсийн төлбөр, хэвлэлтийн зардал хоёр миний бяцхан сэтгүүлийн гол зардал болдог байлаа. Ийм зүйлсийн талаар төсөөлөл ч үгүй явсан өдрүүдийг Сүхээ ахын гэнэн асуулт надад сануулдаг юм. Өдөр тутмын сонины редакциас гаралгүй арваад жил ажиллахдаа бизнес гэж юу вэ гэдгийг огт мэдэхгүй явжээ. Ар гэр амьдралаа ч орхичихсон явж дээ.

Сонины маргаашийн дугаараар хорвоог хэмжсэн тэртээ өдрүүдийн чанадтай өнөөдрийг харьцуулахад өнгөрсөн хоёр жилд өмнөх арван жилээс ч том зүйлийг босгосноо ухаардаг. Эрхлэгчийн ажлын явцуу хүрээн дотор, бичиг цаасны дунд олон жил амьдарсан би ингээд түрээсийн төлбөр, нэхэмжлэх, тамга, ширээ сандал, цалин, татвар, нийгмийн даатгал энээ тэрээ… ээ бурхан минь мэдэхгүй, сонсоо ч үгүй зүйлс энэ дэлхий дээр түм бум юм аа. Гэхдээ тэр бүх сорилтын ард гарч чадсан. Сэтгүүлийн шинэ дугаараа цүнхэнд хийгээд, захиалагчдадаа тараагаад явахтай минь таарсан хүн болгонтой би өнөөдөр эргэн мэндчилмээр санагдаж байна. Хүйтэн, заримдаа бороотой өдрүүдэд Тантай таарсан байж магад. Би норчихсон авч нэг их юм бодолгүй том том алхаад явахаа сийхгүй хүн. Аз жаргалтай алхахын тулд чамд хэлэх үг, хийсэн зүйл байх ёстой. Сэтгүүлийг минь захиалсан хамгийн эхний захиалагч Танд баярлалаа. Хэсэг хугацааны дараа Mining Journal сэтгүүлийг “сайн” гэж тодотгох болсон өөр нэг захиалагч Танд ч бас амжилт хүсье. Эхний жилийн захиалга шувтарч, дараа оны шинэ захиалга явагдах үед анхны андууд бүгд Mining Journal-ийг сонгосон хэвээрээ байсанд хэчнээн баярласан гээч.

“Бизнес хийх хэцүү шүү, Болороо” гэж “Адмон”-ы Р.Энхбат бүүр хамгийн анх хэлснийг ер мартдаггүй. Нээрээ хэцүү байсан. Гэхдээ өөрийн бизнес гэдэг чамайг сэргээн чамбайруулж, санаанд оромгүй эр зориг чадамжийг тэнгэрийн элч үнэхээр илгээдэг. Янз бүрийн зан авирыг арьсаараа мэдэрч, жавар салхинаас хатуу ташуурдуулах үе тохиолдож л байсан. Гэсэн ч ханцуй шамлан зүтгэсэн хөдөлмөрийг минь бусдын жижиг сажиг авирууд мохоогоогүй билээ. Одоо салбартаа орон зайгаа эзэлсэн Mining Journal-ийн өмнө цэлгэр ирээдүй бий. Яг миний хамгийн анхны өрөө шиг нар тоссон өдрүүд байна. Бяцхан өрөөндөө Дээгий бид хоёр сэтгүүлийн макет тавьж, хэзээ биелэх нь үл мэд, том том юм ярьж суусан. “Даашинзтай сурвалжлагууд” номыг минь эх барьсан Р.Эрдэнэдэлгэрийг сониныхон Дээгий нэрээр андахгүй. Mining Journal гэж нэрнээс цаашгүй зүйл байхад бас л надад итгээд ирсэн, сэтгүүлийг эх барьж дэглэн урласан хүн тэр Дээгий юм. “Төлөвлөсөн зүйлүүд овоо бүтээд байна, тээ” гэж саяхан Дээгий хэллээ. Хагас үгэнд нь би түүний санааг ойлгож, бид бяцхан сэтгүүлээ өд сөд ургатал өндийлгөснөө, одоо дахиад хүчит жигүүр дальтай болтол нь дэмнэхээ зүгээр л сэтгэлээрээ ойлголцсон маань тэр ээ.

“Mining Mongolian Journal”-аа хэвлэл түгээх цэгт анх өгч байх үес сонин хэвлэлийн борлуулагч эгчмэд эмэгтэй эршүүд том гартаа сэтгүүлийг минь бариад ийнхүү гарчиглаж билээ. “Миний Монголын журнаал…” хэмээн ихэд хичээнгүйлэн уншсан нь санаанаас ер гардаггүй юм. Уул уурхай хөгжсөн дэлхийн улс орон бүр өөрийн Mining Journal-тай. Монгол орны хөгжлийн тулах цэг, эрч хүчээ авах дэвсгэр болсон уул уурхайн салбарын тухай мэдээллийн хязгааргүй орон зайд тэрхүү мэргэжлийн сэтгүүлийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа юм. “Миний Монголын журнаал” дэлхийн уул уурхайн хөгжлийг эх орны эрдсийн салбартай холбох гүүр, өөдөө тэмүүлэн алхдаг монгол хүн бүрийн сэтгэлийн үг сонсогддог талбар болох учиртай. ■

2010 он

# СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫН ГАЙХАМШИГ

Б.Төгсбилэгт (МУИС-ийн төгсөгч)

Сэтгүүл зүйг барууны орны их сургуулийн энэ салбарын зарим эрдэмтэд тайлбарлахдаа “энэ нь шинжлэх ухаан гэхээсээ илүү урлаг юм” гэдэг. Харин манай профессорууд болохоор “сэтгүүл зүй бол шинжлэх ухаан юм” гэж хэлж ойлгуулдаг. Үүнийг энд ярьдгийн учир нь сэтгүүл зүй бол нэлээд өвөрмөц, хийсвэр шинжтэй нарийн төвөгтэй мэргэжил болохыг тэмдэглэх гэснийх юм. Хэрэв хэн нэг нь сэтгүүлчийн мэргэжлийг их амархан гэж үзэж байвал тэрбээр энэ удаа хэт өнгөцхөнөөр харжээ. Гэхдээ бидний ярилцах гол сэдэв бол аль нэг маргаан бус сэтгүүл зүйн хөгжлийн түлхүүр асуудлын тухай юм. Тэрхүү түлхүүр асуудал нь сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх сургалтын чанар гэвэл Та битгий үгүйсгээрэй.

**Өнөөдөр сэтгүүл зүйн мэргэжлийн сургалтын чанар ямар байна вэ?**

Нэгдүгээр курс, би сэтгүүлч мэргэжлийг сонгосондоо баяртай байна. Хоёрдугаар курс, би маш ихийг сурч байна. Гуравдугаар курс, би илүү ихийг заах байх гэж бодож байлаа. Дөрөвдүгээр курс, би сэтгүүлч болох хэмжээний юм сурсан гэж бодохгүй байна. Иймэрхүү үгийг олон оюутан наанаа биш ч цаагуураа хэлдэг. Үнэндээ дөрвөн жилийн хугацаанд оюутнууд ихийг сурчээ. Гэхдээ тэр нь чадвар гэхээсээ илүү зөвхөн мэдлэг төдий байж мэдэх юм. Үр дүнд нь “болдог юм болдгоороо л болно”.

**Тэгээд асуудал юунд байна вэ?**

Яг тавин жилийн өмнө МУИС-д анх сэтгүүл зүйн тэнхим байгуулагдаж байсныг тооцож үзвэл эдүгээ хүртэл мэргэжил сургалтын нөр их арга туршлага хуримтлуулсан нь мэдээж. Үнэхээр ч сэтгүүл зүйн онол, түүхийн сурах бичиг болон бусад судалгааны материалын хүрээ өнөөдөр чамлахааргүй хэмжээнд хүрчээ. Энэ бол яах аргагүй нэг амжилт мөн.

Гэвч энэхүү бүтээлүүдийг оюутнууд өөрсдөө бие дааж уншиж судлахаас биш профессор нар үг үсэг бүрийг нь “халбагадаж” өгөх нь утгагүй билээ. Тэгж заасныг нь оюутнууд эргээгээд багшдаа яг тэр хэвээр нь бичгээр эсвэл амаар танилцуулаад онц дүн авсан болдог нь өнөөгийн сургалтын тогтолцооны хуучирч, үеэ өнгөрөөснийг тод харуулна. Уг нь лекцийн цагаар илүү нарийн ойлголт, системүүдийг ярих учиртай юм сан.

Профессор нар сэтгүүл зүйн сургалтаа практик давамгайлсан гэж ярьдаг ч үнэн хэрэгтээ зөвхөн мэдлэг олгох хичээлээр оюутнуудыг “бөмбөгдөж” буйгаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Чадваржуулдаг хичээл нь ганц нэг бүтээл, бичвэр бичих даалгавар өгөх төдийхнөөр хязгаарлагдах ёсгүй билээ. Мэдлэг олгох хичээл, чадваржуулах хичээлийн тоо, цагийн харьцаа тэнгэр газар шиг зөрүүтэй байгаа нь маргашгүй үнэн.

Түүнчлэн дадлагын хугацааг уртасгах шаардлага байна. Сэтгүүл зүйн мэргэжлээр суралцаж буй оюутнууд нэгдүгээр курсээ төгсөөд, өөрийн сонирхож, сонгосон хэвлэл мэдээллийн байгууллагад танилцах дадлага хийдэг. Энэ дадлага нь нэг сарын хугацаатай байдаг. Харин хоёр, дөрөвдүгээр курстээ хоёр сарын хугацаанд дадлага хийдэг юм. Судалгаагаар хүн аливаа ажлыг доод тал нь гурван сар хийж байж, тодорхой хэмжээнд туршлагаждагийг тогтоожээ. Тэгэхээр хоёр, гурав дахь дадлагын хугацааг дор хаяж гурван сар болговол оюутнуудын аль нэг чиглэлд чадвар эзэмших нөхцөл нь илүүтэй бүрдэнэ. Европын орны их, дээд сургуульд тухайн оюутныг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бүтэн нэг жилээр дадлага хийлгэдэг практик ч байна.

Ийнхүү урт хугацаанд дадлагажсаных нь дараа тухайн оюутанд харьцангуй чадваржсан тэрхүү чиглэлийнх нь дагуу нарийвчилсан мэдлэг олгох хичээл заавал илүү үр дүнтэй байх болов уу.

Өнөөдөр “сурсан нь үнэн болно” гэсэн чадваргүйтнүүдийг хүлээж авах газар хаана ч байхгүй. Сайн суралцаж төгссөн олон сайн оюутан буйг үгүйсгэхгүй. Бүх бурууг ганцхан зүйлд тохож болохгүй ч, сургалтын системийн явцгүй, үр дүн тааруу байдлыг хүлээн зөвшөөрөхгүй оюутан ховор болов уу. Саяхан сэтгүүл зүйн мэргэжлээр суралцан төгссөн оюутнууд одоо ажилд орно гэхээр ажилд авч буй тал нь ч тэр, өөрөө ч тэр голж байгаа хэдий ч тэд туйлын баяртай байгаа. Яагаад гэвэл тэдэнд мэргэжлээрээ ажиллах нь хамгийн чухал зүйл. Тэдний хэдэн хувь нь чадваржиж, хэдэн хувь нь мэргэжлээ орхихыг цаг хугацаа харуулна. Уг нь их сургуульд суралцах явцдаа тэд чадвар олж төгсөх ёстой байлаа. Эндээс сэтгүүл зүйн сургалтын үр дүнд ихээхэн цаг хугацааг аль аль тал нь алдаж байна гэсэн дүгнэлт хийж болно. Сургалтын техник бааз, орчин зэргийг дурдалгүй өнгөрлөө. Хэрэв эдгээрийг тоочвол энэ бичвэр арай дэндүү хар бараан болчих гээд байгаа юм. Эцэст нь хэлэхэд би бакалаврын түвшний сургалтаас магистрын хэмжээний зүйл шаардаж туйлширсангүй. Харин хэтэрхий олон зүйлийг хамарсан ерөнхий-субъектив шинжтэй сургалт явуулахаа болиод, харин тодорхой зүйлд чиглэсэн, объектив чанартай илүү практик хичээлийн хөтөлбөртэй болох хэрэгтэйг товч дурдлаа. Сэтгүүл зүйн салбарын шинэхэн төгсөгчид бас саналаа хэлэх буй за. ▪

2010 он

THE JOURNALISM FOR DEVELOPMENT

2010-2011

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ

# ТОМИЛОЛТ

Study trips

Дэлхийн сэтгүүл зүйн нэр хүндтэй байгууллага, редакцуудтай танилцах, мэдээлэл бэлтгэх технологи, техникийн дэвшилтэй танилцах, сургах ажлууд цувралаар үргэлжилнэ.

Зургийг Б.Цолмонбаяр

# ӨРНӨ, ДОРНЫГ УУЛЗУУЛАХ САНХҮҮГИЙН ТАЛБАР

Б.Цацрал, The Mongolian Mining Journal, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ

**“**Хонконг амьдрахад үнэтэй газар” хэмээн ноён Лоренс Фок бидэнд танилцуулав. “Гэхдээ бирж дээр хувьцаагаа арилжихыг хүссэн хүнд бол хямдхан шүү” гэж дараа нь бас сануулав. Энэ эрхэм Хонконгийн Хөрөнгийн биржийн Маркетинг хариуцсан захирал. Түүний хэлснээр дэлхийн хэмжээний бусад биржтэй харьцуулбал эдний зах зээлд хувьцаа гаргах үйл явц хамаагүй өртөг багатай аж. Өөрөөр хэлбэл Хонконгийн Хөрөнгийн биржид бүртгүүлж анхны хувьцаагаа арилжих хүртэлх бэлтгэл ажилд компаниуд харьцангуй бага мөнгө зарцуулдаг гэсэн үг. Энэ бол давуу тал.

Хятадад гурван арав, Монголд харин балжинням, дашням давхцан хуримын хөлд дарагдаж, найранд халамцаж хоносон хүмүүсийн хүргэн бэрийн тухай хууч шинэхнээрээ байх аравдугаар сарын 11-ний үдэд Монголын сэтгүүлчдийн баг Хонконгийн хөрөнгийн биржээр зочлон шилэн хаалтны цаанаас арилжаа хэрхэн явж байгааг сонирхож зогслоо. Аврах албаны ажилтнуудынх шиг час улаан хантааз өмссөн брокерууд тус тусынхаа дэлгэцийг ширтэн завгүй суух чив чимээгүй танхимд өдөр тутам тэрбумаар хэмжигдэх мөнгөн урсгал урсаж буй. Ноён Фокийн мэдээлснээр тэр урсгалын мөнгөн дүн дунджаар **7.9 тэрбум**

2010.10.11.Хонконг

**ам.доллар**. Хонконгийн биржийн нэг өдрийн арилжааны эргэлт. Энэ үзүүлэлт **Лондонгийн бирж дээр 8.0**, **Торонтод 5.1 байгаа** гэнэ. "Энэ хүмүүст өдрийн хоол идэх завсарлагааны цаг байдаг уу?" хэмээн хэн нэгэн нь биржийн хэвлэл мэдээллийн ажилтан Мария Лоу хатагтайгаас хэрэгт дурлан шивнэсхийн асууж байх мөчид нам гүмийг эвдэн хонх дуугарлаа. 16 цагтай уралдан чимээгүй орчныг сэрээдэг энэ хонх өдрийн арилжаа дууссаныг зарлана. Брокеруудын өмнөх факсын аппарат шиг жижигхэн төхөөрөмжүүд зүрхний бичлэг хийх мэт өдрийн арилжааны дүнгээ нэгтгэн зайгүй ажиллаж эхлэв. Яг хоёр өдрийн дараа хонх дуугарахад энэ аппаратууд сайн муу мэдээний алийг нь бидэнд дуулгах бол гэж өөрийн эрхгүй бодогдов. Тэр өдөр Монголын үндэсний компани анх удаа Хонконгийн бирж дээр хувьцаагаа зарж эхлэнэ.

Санхүүгийн мэргэжилтнүүд өнөөдөр Хонконгийн биржийг өрнө дорнын уулзах цэг хэмээн томъёолж байна. "Нэг улс, хоёр систем" бодлого энэ чухал орон зайг эзлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэснийг биржийн танилцуулгад дурджээ. Өрнө дорнын өөр өөр соёлтой хүмүүс энд санхүүгийн хэлээр ярилцаж, хамтран түншилж, харилцан ойлголцож, тасралтгүй урсах их хөрөнгийн урсгалыг түүчээлж байна.

Монголын сэтгүүлчдэд өгсөн эхний мэдээллээрээ Лоренс Фок арлын жижигхэн хот-улсын биржийг эдийн засгийн эрх чөлөөгөөрөө дэлхийд тэргүүлдэг гэлээ. Хөрөнгө санхүүгийн урсгалд ямар нэг хориг, шалгуур тавьдаггүй нь өөр нэг онцлог нь. Гадаадын иргэд, компаниуд эндхийн хөрөнгө оруулагчдын 62-оос доош хувийг эзэлж байсан тохиолдол сүүлийн арван жилийн түүхэнд нь лав байхгүй. Тэрхүү гадны хөрөнгө оруулагчдын 40 шахам хувийг америкчууд эзэлнэ. Тэдний араас англичууд жагсана.




Өнгөрсөн зургадугаар сард Хонконгийн бирж уул уурхайн компаниудыг бүртгэх шалгуураа хамаагүй зөөллөн өөрчилсөн ч зөвхөн олборлолт дагнан хийдэг компанийн хувьд хаалттай хэвээр үлджээ. Магадгүй үүнээс нь болоод Торонтогийн бирж арлын орны “анд”-аа өрсөлдөгч хэмээн үздэггүй гэж мэргэжилтнүүд таамаглаж байна. Гэлээ ч Хонконгийн ирээдүй том. “CIBC World Markets” группын дэд ерөнхийлөгч Уоррен Жилманы хэлснээр Хонконг дэлхийн уул уурхайн санхүүгийн гол цөм болох бүрэн боломж, басхүү чадавхтай. Тэрбээр энэ дүгнэлтийг Хонконгийн “Конрад” зочид буудалд болсон Уул уурхайн хөрөнгө оруулалтын чуулганы аравдугаар сарын 13-ны өдрийн хуралдаан дээр хэлсэн юм.

Харин түүний дараагийн илтгэгч, бидний танил ноён Фок Монголын уул уурхайн корпораци Хонконгийн бирж дээр хувьцаагаа арилжиж эхэлсэн тухай мэдээгээр илтгэлээ эхлэв. Энэ жил уул уурхайн ердөө тавхан гадаадын компани Хонконгийн биржид шинээр бүртгүүлжээ. Тэдэн дундаас хамгийн амжилттай цойлох магадлалтай гэж мэргэжилтнүүдийн онцолж буй нь манай үндэсний компани. Үлдсэн дөрвийнх нь үнэ уруудаж, эргээд сэргэснээ дахин буурч, эсвэл арилжаагаа хойшлуулах зэргээр биржийн худалдааны таагүй түүхийг дор дороо бичиж байгааг эх сурвалжууд мэдээлсээр байгаа.

Уул уурхайн компаниудын арилжааны өдрийн дундаж эргэлт энд 674 сая ам.доллар.

Монголын компанийн арилжаа эхэлснийг дэлхийд алдартай Mining Journal сэтгүүлийн эрхлэгч Крис Хинд Хятадын аварга зах зээлийг Монголын арвин баялагтай холбон бат бөх гагналаа хэмээн дүгнэн бичжээ. Олон хүн Хонконгийн биржийг хөгжлийнхөө түүхийг ид бичиж эхэлж байна гэдэгтэй санал нийлж байгаа. Харин Крис Хинд Хонконгийн бирж, түүнтэй тун амжилттайгаар түншилж эхэлсэн Монгол Улс хоёрыг ирэх цөөн жилийн эргэлтэд эрийн цээнд хүрч, хөгжлийнхөө өндрийг авна гэдэгт итгэж буйгаа илэрхийлжээ. ■

2010.10.11

# BLOOMBERG

Л.Болормаа, Хөгжлийн төлөө сэтгүүл зүй, The Mongolian Mining Journal

2011.04.08. Сингапур

Хаслинда эфирт гарахаар бэлтгэж байлаа. 13.05 цагт түүний нэрийг хөтөлбөрт “зоожээ”. Блүүмбергийн Сингапур дахь салбараас өдөр тутам шуурхай мэдээлэл дамжуулдаг Хаслинда Аминыг дэлхийн сая сая үзэгч сайн мэднэ. Харин энэ өдөр цацах шинэ мэдээллийнх нь талаар хэн ч урьдчилан хэлж чадахгүй. Учир нь Блүүмбергийн мэдээлэл 20 секунд тутам шинэ үйл явдлаар баяжиж байна. Өдөртөө 50 мянган мэдээ энэхүү санд нэмэгдэн орох жишээтэй.

“Angkor” гэсэн бичигтэй жижиг өрөөндөө Хаслинда ороод даруухан толины өмнө хэсэг саатна. Блүүмбергийн мэдээний хэсэг туйлын энгийн бүтэцтэй. Сингапурын салбар нь бол бүр хялбар шийдлээр мэдээллээ цацдаг.

Телевизийн хэсэгт нь “үндсэн ажилтан” ердөө гурав бий гэвэл үзэгч Та гайхах нь лавтай. Дэлхийн санхүүгийн нэг томоохон төв болох Сингапураас 24 цагийн шинэ мэдээллийг дамжуулах шийдлийг шилдэг техник ба агуулгын хязгааргүй боломжоор дамжуулан зохион байгуулжээ. Эфирын хэсэгт зураглаач үгүй. Жижигхэн энэ студиэс дэлхийг татсан гайхамшигт мэдээллүүд цацагддаг. Зураглаачид студийн гурван камер. Студид хөтлөгчөөс гадна зочин оролцох зай талбай бий. Нэг буланд нь жижиг дэлгэцнээс зах зээлийн өөрчлөлтийг тайлбарлах хөтлөгчийн ширээ, сандлыг байрлуулсан харагдана.

Зураглаач М.Энх-Амгалан

Сэтгүүлчийн ард Блүүмбергийн том танхим тэр чигтээ үзэгдэнэ. Зүгээр л жижигхэн студийн шилэн хана байгаа нь тэр ээ. Гурван камер дүрсээ татаж, харин түүний эвлүүлэг найруулгыг Блүүмбергийн Лондон дахь төвд шууд хийж байна. Европ, Азийн мэдээллийг хариуцдаг Блүүмбергийн Лондон дахь төвд ч ялгаагүй телевизийн техникийн хэсэг нь нүсэр биш. Ердөө гурван монтажчин найруулагч ажилладаг гэж бидэнд тайлбарлалаа. Тэгэхээр Блүүмберг хэмээх дэлхийн санхүү, зах зээлийн мэдээллийн халууны шилийг атгагч мангасын үндсэн ажлыг шинжээчид гүйцэтгэж байна. Зөвхөн Сингапурын салбарт нь 400 хүн ажилладаг ба эдний 25-26 нь сэтгүүлч, ахлах редакторууд, Үлдэх хэсэг нь зах зээлийн судлаачид, санхүүгийн мэргэжлийн хүмүүс. Тэд өмнөх дэлгэцнээсээ хараа үл салган ажиллана. Хоёр, зарим нь өмнөө 4 дэлгэц “сунгаад” тавьчихсан жирэлзэн урсах тоо цифрүүдийн учрыг олон, хандлагыг илэрхийлэн, өөр зуураа вэбкамераар ярилцах аж. Блүүмбергийн мэдээллийн санд нийт 15 сая нийтлэл, өгүүлэл, сурвалжлага мэдээ хадгалагддаг.

Биднийг үдийн 12 цагтай уралдан Блүүмбергийн Сингапур дахь төвд очих үед дэлхийн уул уурхайн салбарт шинэ шуугиан дэгдсэн байлаа. Дөрөвдүгээр сарын 4-ний өдрийн 11.51 цагт Блүүмбергийн Азийн салбар ээлжит сенсаацыг цацсан юм. Хятад уул уурхайн салбарт рекорд эвдэх шинэ наймаа хийснийг удахгүй Хаслинда тодруулан зарлах гэж байна. Зэсийн үнэ энэ оны турш “сансрын” өндөр ханшид дүүжлэгдсээр байгаа, ийм цаг үед Хятад улс нь стратегийн түүхий эдээ Африкаас арай хямд олж авах алсын хараатай ажилласаар байгаа юм. Тэд Африкийн Замби улсын удирдагчидтай сүүлийн хэдэн жил зүгээр нэг дотносоод, үе үе айлчилсан бус, уул уурхайн томоохон түнш болох алхмаа хийжээ. Хятадын төрийн мэдлийн Minmetals Resources компани Африк тив дэх зэсийн том уурхайн хяналтын багцыг Австралийн Equinox компаниас худалдан авснаа зарлажээ. Энэхүү арилжааны дүн 6.5 тэрбум америк доллар болсон ба Хонконг, Сидней, Торонтогийн биржүүд дээр дөрөвдүгээр сарын 4-ний өдөр дээрх компанийн хувьцаа өндөр өсөлттэй байлаа. Equinoxe-ийн хувьцаа өчигдөр Сиднейн бирж дээр 28 хувийн өсөлттэй гарсан бол Хонконгийн бирж дээр өчигдөр 11. 25 цаг гэхэд 0.5 хувиар өсч, зах зээлийн үнэлгээ нь 2.5 тэрбум америк долларт хүрсэн байна.

Дэлхийн уул уурхайн салбарт сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлт бол компаниуд шинэ ордын лиценз худалдан авах, дэд бүтэц шинээр байгуулах зардал гаргахаас татгалзаж буй явдал юм. Түүхий эдийн нөөц дэлхий дахинаа хомсдох тусам компаниуд цаг хугацаа их шаардсан ордуудаас татгалзан, үйл ажиллагаа явуулж байгаа уурхайг өндөр үнээр худалдан авах жишгийг сонирхох болжээ. Ялангуяа Хятад улс нь ийм чиглэлээр түйлын бодлоготой хөдөлж, уул уурхайн бүхий л ашигтай төслүүдийг мөнгөөр зодож авсаар байна. Хятадын компаниуд зөвхөн өнгөрсөн жил гэхэд 30 тэрбум долларыг уул уурхай ба газрын тосны төсөл худалдан авахад зориулжээ. Энэ оны нэгдүгээр сард мөнөөх Minmetals компанийн Гүйцэтгэх захирал “ Бид одоо зэс, цинкийн уурхайнуудад анхаарал хандуулж эхэлсэн” хэмээн мэдэгдсэн. Хятадын эрэлт металлын зах зээлийн ханшийг тодорхойлж буй үед тус улсын төрийн мэдлийн аварга компаниуд итгэмээргүй өндөр үнээр уурхайнуудыг ийнхүү худалдан авах супер арилжаа хийсээр байна.

Өчигдрийн наймааны талаар Блүүмбергийн шинжээчид “Түүхий эдийн нөөц ховордон, шинээр нээгдэх ордуудын агуулга ядмаг болсон энэ цагт Хятадын бодлого сонирхол татаж байна” хэмээн тэмдэглэжээ.

Сингапурт дөрөвдүгээр сарын 4-8 өдрүүдэд зохион байгуулагдаж буй Asia Mining Congress-ийн үеэр ч асуудлыг хөндөн ярилцах ба өчигдөр Африк дахь уул уурхайн шинэ төслүүдийн танилцуулга болж өнгөрсөн нь уул уурхайн салбар дахь үйл явдал, хандлагын сонирхолтой оглтолцол гэлтэй. Asia Mining Congress-ийн өнөөдрийн хуралдаан төмрийн хүдрийн олборлолт, эрэлт нийлүүлэлт, шинэ төслүүд, үйлдвэрлэлийн сэдвээр өрнөх бол лхагва, пүрэв гаригийн хуралданууд дээр зэсийн ирээдүй, нүүрсний тээвэрлэлт зэрэг сонирхолтой сэдвээр уул уурхайн дэлхийн тэргүүлэгч компанийн Захирлууд танилцуулга илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнөнө. Азийн уул уурхайн салбарын энэхүү томоохон хурлын сүүлийн өдөр Монголд хөрөнгө оруулах нь сэдвээр ярилцах юм.

Asia Mining Congress-оос Mongolian Mining Journal сэтгүүлийн баг дэлгэрэнгүй сурвалжлага бэлтгэн цацах ба телевизийн нэвтрүүлгээ мөн үзэгчдэдээ хүргэхээр ажиллаж байна.

Блүүмбергийн Азийн салбар уул уурхайн чуулга уулзалтын талаарх мэдээллийг өчигдрөөс эхлэн цацжээ.

Тухайлбал Блүүмбергийн Сингапур салбарын студиэс Asia Mining Congress-ийн төлөөлөгчид ярьсан бол өнөөдөр Хонконгийн салбарын сэтгүүлч-хөтлөгч Сюзан Лее уг хурлын тухай мэдээллийг цацахаар төлөвлөгдсөн аж. Эдний Хонконгийн салбарын телевизийн хэсэг 40 хүнтэй. Ер нь Азийн санхүүгийн төв Сингапураас Хонконг руу шилжсээр байгаа хөдөлгөөн идэвхжжээ. Блүүмбергийн 24 цагийн хөтөлбөрийг дэлхийн есөн том хот дахь салбарууд нь бие даан хийдэг ба Европ, Азийн хөтөлбөрийг Лондонгоос шууд удирдаж, зохион байгуулдаг.

Блүүмбергийн өдөр тутмын хөтөлбөрийн хуудас өнгө өнгөөр ялгасан тэмдэглэгээтэй байх ба цаг, сегментүүдийг эхний хоёр баганад зоодог. Lives, Touch, Guest гэхчлэн нэвтрүүлгийг Та бидний үзэж дассан төрлүүдээр нь ангилж тэмдэглэдэг. News болон Lives хэсгүүдэд Хаслинда Амин ажилладаг. Блүүмбергийн мэдээний цагаар дайчин цогтой Хаслинда Сингапурын биржийн мэдээ, бусад үйл явдлыг тайлбарлахад үзэгчид түүний татах ховсонд өөрийн эрхгүй ордог биз ээ. Хонконгийн Сюзан Лее гоёмсог төрхөөрөө илүү танигддаг бол Хаслинда ямагт дайчин, зогсолтгүй урсгах түүний мэдээлэл нь зах зээлийн өөрийнх нь хэмнэлтэй нэн адил.

Хаслинда хэдийгээр завгүй, хэдхэн минутын дараа эфирт гарах байсан ч бидэнтэй зургаа татуулж, хэдэн үг сольсон билээ. Блүүмбергийн нэртэй сэтгүүлч-хөтлөгч түүнтэй Mongolian Mining Journal-ийн сэтгүүлч Б. Халиун тун удахгүй сонирхолтой ярилцлага хийн, Монголын үзэгчдэд хүргэнэ. Эдийн засгийн мэдээллийг хэрхэн мэргэжлийн түвшинд бэлтгэн, шуурхай цацаж байгаатай бид газар дээр нь танилцах зорилго өвөрлөсөн билээ.

Дэлхийн мэдээлэл үйлдвэрлэгчид агуулгаараа өрсөлдөж байна. Энэ бол Монголын мэдээллийн зах зээлээс ялгаатай, чанарын өрсөлдөөн юм. Майкл Блүүмберг 1981 онд мэдээллийн үйлчилгээний бизнесээ эхлүүлсэн бөгөөд эдийн засаг, бизнесийн шилдэг мэдээний сонголтыг хэрэглэгчдэдээ хүргэх түүний зорилго ийнхүү тэлсээр Блүүмбергийн мэргэжлийн сервис болтлоо хүрээгээ тэлжээ.

Өдгөө Блүүмбергийн зах зээл, санхүүгийн мэдээлэл- судалгаа- лавлагаа-архивын хязгааргүй сангийн үйлчилгээг дэлхий авч байна. Монголын банк, санхүүгийн, судалгааны байгууллагууд, ялангуяа бизнесийнхэн Блүүмбергийн терминалыг сүүлийн үед идэвхтэй ашиглах болжээ. Сард 2000 ам.доллар, жилийн 24000 долларын төлбөртэй үйлчилгээ үнэ өндөр мэт сонсогдовч зах зээлийн шинэ мэдээлэл, хандлагыг мөнгө болгон өөртөө ашиглах чадвартай хэнд ч болов хязгааргүй боломж юм.

Монголын сэтгүүлчдэд Блүүмбергийн мэдээллийг хэрхэн ойлгох, унших талаарх цуврал сургалтыг бид давхар хийж эхэлсэн билээ. Өөрсдөө гүнзгийрүүлэн суралцах шаардлага байгаагийн улмаас энд, Сингапурт хурал сурвалжлах үндсэн ажлынхаа хажуугаар Блүүмбергийн салбартай танилцан, мэргэжлийн хүмүүстэй уулзсаар явна. Манай сэтгүүлчдийн баг түүнчлэн Fox News, Dow Jones-ийн салбаруудтай танилцах төлөвлөгөөтэй.

Хаслинда бол бидний ижил сэтгүүлч. Ялгаатай нь тэрбээр өндөр мэргэшсэн шинжээч-сэтгүүлч, бас авьяаслаг хөтлөгч. Хар өнгийн хослолоор гоёсон Хаслинда хэдхэн минутын дараа эфирт гарахаар зэхэж байна. Түүний өмнө ногоон, шар, улбар шар, улаан, цагаан өнгөөр ялгасан товчлуур бүхий кеборд байна. Энэ бол Блүүмбергийн "хамаатан" бүх хүний ашигладаг кеборд. Улаан өнгөтэй нь зогсоох, болгоомжлуулсан товчлуур бол шар нь зах зээлийн гол мэдээллийг авах үндсэн хөтлөгчид. Харин ногоон товчлуурууд Таныг хэвлэх, цэс рүү орох, туслалцаа хүсэх гэхчлэн гол үйл хөдлөлд удирддаг. Ойлгохгүй зүйл мэдээж зөндөө гарна. Тэгвэл ногоон өнгийн Help товч Танд 24 цагийн турш шуурхай үйлчилдэг. Ямар мэдээлэл хүсч байгаагаа бичлээ, илгээлээ, хэдхэн секундын дараа хариу ирнэ, цаг хугацаа шаардсан хайлт хийх хэрэгтэй бол "түр хүлээнэ үү, төдөн минутын дараа хэлээд өгье " гэх мэтээр жинхэнэ найз шиг тусална шүү дээ. Блүүмбергийн арвин сангаас хүссэнээ авч, арилжаанд мэдлэгтэй орохын тулд зайлшгүй суралцах олон зүйл бий. Хамгийн эхнийх нь таних тэмдэглэгээнүүдийг тогтоох хэрэг гарна. Бидний бичдэг шиг "ингээд, тэгээд" хэмээн шал шалхийх шаардлага санхүүгийн ертөнцөд үгүй болохоор энгийн товчлолуудыг өргөн ашигладаг. Тухайлбал, үнэ ханшийн графикуудыг дэлгэц дээр хармаар байгаа бол GP гэсэн хоёр үсгийг сонго. Шинжээчдийн дүгнэлтийг сонсъё гэвэл PEOP хэсэг рүү орно. За бүр сайн ресторанд хоол идмээр санагдвал DINE гээд хайгаарай. Blackberry утасны хэрэглэгчид BERRY хэмээх товчлуураар өөрсдийн замыг олдог.

Блүүмбергийн Сингапурын салбарынхан өдрийн хоолондоо орох цаг болжээ. Олонх нь гадагшаа гарсангүй. Ажилтнуудад зориулсан цайны хэсэгтээ тухалж, ойр зуурын хөнгөн хоол идэх аж. Capital Square-ийн 11 ба 12 дугаар давхруудад "ухаантай" мэдээллүүд ийнхүү бэлтгэгдэж байна. Хаслиндагийн эфирийн цагаар ард нь Сингапурын гудамж талбай, өндөр байшингууд Танд харагдана уу. Хаслинда Амин зүгээр л жижигхэн цонхныхоо наана суучихсан байгаа нь тэр. Жижигхээн өрөөнөөс нэвтрүүлгээ эвтэйхэн цацчихдаг. Энд их ухаантай зүйлсийг энгийн шийдлээр хийж байна. ▪

2011.04.08

THE JOURNALISM FOR DEVELOPMENT

2010-2014

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ

# ХЭЛЭЛЦҮҮЛЭГ-ХУРАЛ

## Discussions and conferences

The Mongolian Mining Journal, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын үйл ажиллагаа өргөжихийн хэрээр төрөл бүрийн хэлэлцүүлэг, онол-практикийн хурал бие даан зохион байгуулдаг болов.

Major events organized by Journalism for Development NGO and activities of note




Зургийг Б.Цолмонбаяр

# 2010.05.12

Sunjin Grand Hotel

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ
Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран тоон системд шилжих явцын бэлтгэл болгож "ТООН ТЕЛЕВИЗИЙН ТУРШЛАГА-ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА" хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

May 12, 2010

A discussion on Trends in Development of Digital Television was held in cooperation with the Communications Regulatory Commission as Mongolia was preparing to enter the digital age.

## ТЕЛЕВИЗ, РАДИОГИЙН ТООН СИСТЕМД ШИЛЖИХ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Телевизийн тоон системийн шилжилтийн талаарх бодлого, үйл явц.

Өнөөдөр дэлхий нийтээрээ радио телевизийн тоон системд шилжиж байгаа. Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас 2015 он гэхэд дэлхийн бүх улсууд аналоги системээс тоон /дижитал/ системд шилжихийг уриалаад байгаа юм. Аналоги системээс тоон системд шилжсэнээр дуу, дүрсний өндөр нягтаршилтай телевизийг хүлээн авч үзэхээс гадна ганц телевиз биш олон талын бүхий л мэдээллийг хүлээн авах боломжтой болно.

Хамгийн сүүлийн мэдээгээр 14 улс тоон системд бүрэн шилжээд байгаа бол 42 улс шилжилт хийж байгаа аж. Манай улсын хувьд аналоги системээс тоон системд шилжих бэлтгэл ажлыг эхэлж байгаа бөгөөд Засгийн газар хөтөлбөр боловсруулжээ.

Монголын үзэгчид дэлхийн түвшний мэдээлэл хүлээн авахыг хүсч байгааг телевизийнхэн мэдэрч, шинэчлэгдэж чадсан нь олзуурхам. Технологийн тоон системийн бэлтгэлийг эртлэн базаахаар хөдөлсөн Зохицуулах хорооныхон, дарга Б.Болдбаатар санаачлагатай ажиллажээ.

Технологийн ухаалаг шийдлийг үндэсний Univision компани Монголын хэрэглэгчдэдээ хүргэж, түүний араас бусад компани мөр даран гурвалсан үйлчилгээг санал болгосон юм. HD формат монгол үзэгчдэд танил боллоо.

Харилцаа, холбооны зохицуулах хорооны дарга Б.Болдбаатар

Технологийн хувьсгал хийгдэж байгаа энэ үед зөвхөн төр засгийн хэмжээнд бус телевиз радиогийн ажилтнуудаас эхлээд нийт иргэд бүгдээрээ тоон системийн талаар тодорхой мэдээлэлтэй байх шаардлагатай юм.

Харилцаа холбооны зохицуулах хороо, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” төрийн бус байгууллага болон БНСУ-ын “ДиЭн Би” байгууллагаас хамтран “Телевизийн тоон системийн туршлага, цаашдын хандлага” хэлэлцүүлгийг зохион байгуулж, телевизийн удирдлага, инженер техникийн ажилтнуудад тоон системд шилжих гэж байгаа талаар танилцуулж, санаа бодлыг нь сонссон юм. Энэхүү хэлэлцүүлэгт тоон системд шилжиж байгаа БНСУ-ын телевизүүдийн төлөөлөгчид ирж, өөрсдийнхөө хийж байгаа ажил, туршлагаас Монголын телевизийнхэнтэй хуваалцав.

Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 100 орчим телевиз, 20 гаруй FM, радиогийн удирдлага, инженер техникийн 160 гаруй ажилтан уг хэлэлцүүлэгт оролцож, телевиз, радиогийн хөгжлийн цаашдын чиг хандлага, шинэ техник технологийн талаар гадны орнуудын мэргэжилтнүүдийн илтгэлийг сонсож, сонирхсон асуултдаа хариулт авсан юм. ▪

# 2010.05.14

MAX Tower

The Mongolian mining journal, Хөгжлийн төлөө сэтгүүл зүй ТББ
Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран
**“БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛИЙН ЖИЛ ДЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ”** сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм.

May 14, 2010

A discussion on Changing the Legal Milieu in the Year of Reforming the Business Environment was held in cooperation with the Justice and Internal Affairs Ministry, and The Mongolian Mining Journal.

“81 ХУУЛИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол Улсын Засгийн газраас зарласан “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хүрээнд нийт 131 зорилт, арга хэмжээг тусгасан. Үүнээс 105 нь бизнесийн орчны макро түвшний тогтвортой байдлыг хангах, 26 нь дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэж байгаа юм. Эдгээрийг хэрэгжүүлэхээр төрийн 22 яам, агентлаг, төрийн бус зургаан байгууллага, мэргэжлийн холбоод ажиллаж байна. Мөн саяхны Засгийн газрын хуралдаанаар зарим сайд, аймгийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарын гаргасан холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын дүгнэлтийг үндэслэн хүчингүй болгох талаар хэлэлцсэн билээ.

# МОНГОЛ УЛС ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ СУУРИА ЗӨВ ТАВЬСАН

Г.Баясгалан

Л.Заяа

Г.Оргилмаа

Б.Энх-Амгалан

Ж.Мөнх-Эрдэнэ

Уулзалтад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны хуулийн мэргэжилтэн Б.Болдбаатар, Монголын ажил олгогч эздийн холбооны Бодлого, ерөнхий зохицуулалтын газрын дарга Ж.Мөнх-Эрдэнэ, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах төслийн удирдагч Л.Заяа, Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах төслийн ажилтан Б.Энх-Амгалан, Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах Ажлын хэсгийн ахлагч Г.Оргилмаа нар оролцов.

**Г.Баясгалан:**

2007 оны сүүлээр Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр гэж бодлогын том баримт бичиг гарсан юм. Хөдөлмөрийн баатар хуульч Б.Чимидээр ахлуулсан Ажлын хэсгийг ХЗДХЯ-наас томилон бид тэр баримт бичигт хяналт шинжилгээ хийсэн. Монгол Улсын хуулиуд ямар байна, зохих ёсны хуулиуд нь гарсан байна уу, хэрэгжилт нь хэр байна гэдгийг харуулсан их том судалгаа болсон. Эндээс Монгол Улсад нийгмийн харилцааг зохицуулах ёстой хуулиуд нь гарчээ гэсэн дүгнэлтэд хүрсэн. Гэхдээ хуулийн хэрэгжилт тааруухан байсан. Хуулиудын заалтууд хоорондоо давхардсан, зөрчилдсөн, хийдэл ихтэй байсан тул шинээр олон хууль гаргахаасаа илүү одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудаа цэгцлэх ёстой гэсэн дүгнэлт гарсан. ▪

# 2010.06.04

MAX Tower

The Mongolian mining journal,  Хөгжлийн төлөө сэтгүүл зүй ТББ
“ЗЭС ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭР” хэлэлцүүлгийг зохион байгуулав

June 4, 2010

A discussion on The Pros and Cons of the proposed Copper Smelting Plant was held in cooperation with The Mongolian Mining Journal.

ЗЭС ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ ХААНА БАЙГУУЛАХ НЬ ҮР АШИГТАЙ ВЭ? ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол улс цаашдаа ашигт малтмалын түүхий эдээ гадагш гаргадаг улс хэвээр байх уу, эсвэл дотооддоо нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг улс болох уу. Цаг үеийн энэ торгон зааг дээр  Зэс хайлуулах үйлдвэр байгуулах тухай тогтоолын төслийг УИХ 2010 оны тавдугаар сард баталсан. Тогтоолын төслийн дагуу УИХ Зэс хайлуулах үйлдвэрийн барилгын ажлыг 2011 оноос эхлүүлэх үүрэг даалгаврыг Засгийн газарт өгсөн ч  уул уурхайн салбарынхны анхаарлыг хамгийн ихээр татсан зүйл нь Зэс хайлуулах үйлдвэрийг хаана барих, ТЭЗҮ-ийг нь хэрхэн боловсруулах тухай асуудал байв.

Уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхийн өмнө судалгаа, шинжилгээний ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, ул суурьтай хийх шаардлага тулгараад байгаа энэ үед “The Mongolian mining journal” яг энэ халуун сэдвийн хүрээнд “Уул уурхайн томоохон төслүүдийн ТЭЗҮ-г боловсруулах тухай” /Зэс хайлуулах үйлдвэрийг хаана байгуулах нь үр ашигтай вэ?/ редакцийн уулзалтыг зохион байгууллаа.

Редакцийн уулзалтыг сэтгүүлч, редактор Г.Идэрхангай хөтлөн явуулсан юм. Хэлэлцүүлэгт Монголын үндэсний уул уурхайн ассоциацийн Гүйцэтгэх захирал Н.Алгаа, ШУТИС-ийн Уул уурхайн инженерийн сургуулийн Уурхайн технологийн багийн профессор, шинжлэх ухааны доктор Я.Гомбосүрэн болон Уул уурхайн хүрээлэн, Ашигт малтмалын газрын төлөөллүүд оролцсон юм.

Зэс хайлуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулахдаа хамгийн түрүүнд үйлдвэрийн байршлыг тодорхойлох ёстой гэдэг дээр эрдэмтэн, судлаачид санал нэгдэж байсан билээ. ■

# 2013.01.18

Blue sky tower

The Mongolian Mining Journal, "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран
"АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ШИНЭ ХУУЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ"-ийг
зохион байгууллаа.

January 18, 2013

A discussion on The New Mineral Law was held in cooperation with The President's Office and The Mongolian Mining Journal.

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2013 оны нэгдүгээр сарын 18-ны өглөө эртлэн Blue sky tower-ийн гурван давхрыг сэрээсэн хөл хөдөлгөөн Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг өрнөх гэж буйтай холбоотой байлаа. 9.30 цагт эхлэх товтой ч хурлын танхим хагас цагийн өмнө хэдийнэ дүүрчээ. Үүнээс харахул ажил хэрэгч эрхмүүд хэлэлцүүлэгт ихээхэн анхаарал тавьсан нь илт.

**Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан:**

"Ашигт малтмалын тухай хуулийг вэб хуудсанд байрлуулж, олон нийтийн санал бодлыг сонсож, ул суурьтай хэлэлцүүлэг хийж байгаа нь хууль тогтоомжийг боловсруулах ардчилсан үйл явц" хэмээн тодотгоод "Хэлэлцүүлэг хийж буйн гол шалтгаан нь улс төр ч юм уу, ямар нэгэн тодорхой эрх ашгийг хөндөх гэсэндээ биш. Хуулийн төслийг хийхэд гар бие оролцож, олон сараар өдөр шөнөгүй ажилласан зургаан хүн яагаад энэ хуулийн төслийг бичих болсон цаад философи, учир шалтгааныг толилуулахын тулд хийж байгаа юм" хэмээн хэлэлцүүлгийн зорилгыг тодорхойлов.

Хууль боловсруулах ажлын хэсгийн зургаан гишүүн тус бүр өөр сэдвээр илтгэл бэлджээ.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга олон нийтэд ил болсноос хойш түүнийг тойрсон маргаан, мэтгэлцээн нийгэмд ид өрнөж байна. Харин хууль боловсруулсан Ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ суугаад хуулийн төслийг задлан тайлбар өгч хараахан амжаагүй байсан юм. Тиймээс ч хууль санаачлагчдаас цөөнгүй удаа зохион байгуулахаар амласан хэлэлцүүлгийн эхнийх нь оролцогч олонтой байх нь зүйн хэрэг. Тэр хэрээр хуулийн төслийг олон өнцгөөс харах төлөөллүүд хүрэлцэн ирсэн нь ч сайн хэрэг юм.

Тайзнаа Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан, Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр нар суудлаа эзэлж, индэрийн урдхан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан хуульч, мэргэжилтнүүд суужээ.

Яам, агентлагийнхан, уул уурхайн компанийн захирлууд, гадаадын хөрөнгө оруулагчид, хуульчид, дээл өмссөн хөдөөх малчин эр, бичил уурхайчдаа төлөөлж орон нутгаас ирлээ хэмээн танилцуулсан хэлэмгий байрын эмэгтэйчүүд гээд 300 дөхсөн танхимын төлөөлөл олон талтай. Бас сонирхолтой. “Болд төмөр ерөө гол”-ын Б.Дэлгэрсайхан зэрэг элдэв арга хэмжээн дээр тэр бүр харагдаад байдаггүй содон хүмүүс ч онцгой харагдана. Түүнчлэн, доктор Д.Дондов, Н.Дашзэвгэ, С.Авирмэд, Х.Владимир нарын эрдэмтэн судлаачид, Чингис хааны удам залгах хунтайж гэж өөрийгөө зарладаг П.Давааням, “иргэний нийгмийн” тодотголтой Ж.Занаа хатагтай нарын сонирхолтой эрхмүүд ч хэлэлцүүлэгт оролцогчдыг бүрдүүлжээ.

Монгол улсын хоёр ч Ерөнхий сайд хэлэлцүүлгийг зорин ирэв. Ерөнхий сайд асан Д.Содном эхнээс нь анхааралтай гэгч нь сууж саатсан бол Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн удийн алдад ирж, эрдэс баялгийн салбарын хууль эрхзүйн орчны талаарх нухацтай үгээ хүргэсэн. Нэг ёсондоо уул уурхайн салбарынхны хувьд ховор цугларалт боллоо. ■

# 2013.06.20

Гадаад харилцааны яамны “Зөвшилцөл” танхим

The Mongolian Mining Journal, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ “COAL TO LIQUID (CTL) БУЮУ НҮҮРС БОЛОВСРУУЛАН ШИНГЭН ТҮЛШ ГАРГАХ ТЕХНОЛОГИЙГ МОНГОЛД ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛ” сэдэвт хэлэлцүүлгийн Мэдээллийн ивээн тэтгэгч байгууллагаар хамтран ажиллалаа.

June 20, 2013

Journalism for Development NGO, together with The Mongolian Mining Journal, was chosen as the media partner at the Issues in Developing Coal-to-Liquid in Mongolia conference.

## “НҮҮРС ШИНГЭРҮҮЛЭХ ТЕХНОЛОГИЙГ МОНГОЛД ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“Coal to liquid (CTL) буюу нүүрс боловсруулан шингэн түлш гаргах технологийг Монголд хөгжүүлэх асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг Монголын химич, химийн инженерүүдийн нэгдсэн холбоо, Шинжлэх ухааны академи хамтран Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулсан юм.

Нүүрс шингэрүүлэх технологи болон дээрх төслүүдийг Монголд хэрэгжүүлэх боломж, саад бэрхшээл, эдийн засгийн үр ашиг, төрийн бодлого, хууль эрх зүйн орчин зэрэг асуудлууд хэлэлцүүлгийн гол сэдэв байлаа.

Мөн энэхүү хэлэлцүүлэгт Монгол улсын Шинжлэх ухааны академи, Уул уурхайн яам, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны мэргэжилтнүүд оролцжээ.

Монгол улсад аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжихэд бэлэн болоод буй. Харин энэ томоохон бүтээн байгуулалтыг түлш, эрчим хүчний хэрэглээ хангамжгүйгээр төсөөлөхийн аргагүй. Цаашлаад түлш шатахуун, эрчим хүчний хангамж нь улс орны аюулгүй байдлын гол асуудал. Монгол улс газрын тосны тодорхой нөөцтэй ч боловсруулах үйлдвэр байхгүй улмаас шатахууны импортын хувьд гадны улсаас бүрэн хамааралтай. Энэ байдлаас гарах боломжийг олон жил эрэлхийлж, судалж басхүү хэлэлцэж ирсэн ч дорвитой, тодорхой шийдсэн зүйл үгүй. "Эрчим хүчний" гэгдэх нүүрсний нөөцөөр дэлхийд тэргүүлэгч орон ч гэлээ өндөр үнээр хилийн чанадаас эрчим хүч авсаар байна.

Эдгээр асуудлыг цогцоор шийдэх, цаашлаад нүүрс-химийн аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх нэг боломж бол арвин нөөцдөө тулгуурлан CTL буюу хүрэн нүүрс боловсруулан шингэн түлш гаргах технологийг эх орондоо нэвтрүүлэх явдал юм.

"Монголын Алт", "Багануур Энержи Корпорэйшн" болон "Цэцэнс майнинг энд Энержи" компаниудын төлөвлөсөн CTL технологид суурилсан төслүүд хэрэгжүүлэхэд бэлэн болоод байгаа билээ. Үндэсний компаниуд маань аль ч үеийн Засгийн газрын өөрчлөлт, тэдгээрийн бодлого чиглэлтэй уялдуулан, өөрсдийн хөрөнгө, бололцоонд тулгуурлан энэхүү технологийн талаар олон жилийн нарийн судалгаа хийж ирснийг онцлох хэрэгтэй.

Өндөр технологийн эдгээр төслийг Монголд хэрэгжүүлэх боломж, саад бэрхшээл, эдийн засгийн үр ашиг, төрийн бодлого, хууль эрх зүйн орчин зэрэг асуудлаар төр засгийн бодлого тодорхойлогчид, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид бүтэн өдрийн турш чуулан хэлэлцүүлэг өрнүүлэв. ▪

# 2013.11.15

Төрийн ордон. “А” танхим

The Mongolian Mining Journal, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын санаачилсан “МОНГОЛЫН ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ШИНЭ ҮЕИЙН 20 ЖИЛ” хэлэлцүүлэг хурлыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар дэмжин хүлээн авч, хамтарч ажилласан билээ.

November 15, 2013

A discussion on 20 Years of the New Era of Mongolia’s Mineral Sector was held in cooperation with The President’s Office, the Mining Ministry, the Mineral Resources Authority and The Mongolian Mining Journal.

## “ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ШИНЭ ҮЕИЙН 20 ЖИЛ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ-ХУРАЛ

“Монголын эрдэс баялгийн салбарын шинэ үеийн 20 жил”-ийн амжилт ба алдаа, эрсдэл, сургамжаа ярилцъя гэсэн MMJ-ийн санаачилгыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар дэмжин хүлээн авч, хамтарч ажилласан билээ. Түүнчлэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Трансвест Монголиа” ХХК, Монголын алт үйлдвэрлэгчдийн үндэсний ассоциаци хурлыг ивээн тэтгэж, томоохон дэмжлэг үзүүлсэн юм.

"Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өндөр өсөлтийн арван жил зугуухан урсуудлаа. Одоо оргилоос ёроол руу гулсах мөчлөгт нисч яваагаа монголчууд мэднэ. Гэхдээ дэлхийн зах зээлийн хандлагаас үл хамааран улс төрийн үйл явц, хөрөнгө оруулагчийн шууд нөлөөгөөр манай улсын эдийн засаг савласаар байна. Монголын улс төр ээлж дараалан эдийн засагтаа хохиролтой шийдвэрүүд гаргаж, түүнээ залруулахаар араас нь цаг алдаж байх зуурт дэлхий ертөнц өөрчлөгдөн хувирсаар байна." гэж Mongolian Mining Journal бичсэн.

Яг энэ сэдвээр нээлттэй ярилцъя. Зөвхөн салбарынхан дотроо биш шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч агентлаг, мэргэжлийн холбоод болон компаниуд, оролцогч бүх талыг хамарч ний нуугүй ярилцъя, алдаа оноогоо дүгнэе, алдаанаас сургамж авъя. Хэлэлцүүлэг хийхийн учир шалтгаан ийм.

Жилийн өмнө эрдэс баялгийн салбар 90 жилийн түүхэн ойгоо тэмдэглэсэн. Түүхэн энэ мөчлөгт сүүлийн 20 жил онцгой байр суурьтай. Тиймээс өнгөрсөн хоёр арванд геологи уул уурхайн салбарт ачааны хүндийг үүрч, бүтээн байгуулж, эрсдэлийг даван туулагсдаар хурлын танхимыг бүрдүүлэхийг хичээсэн. Энэ хүмүүст туулсан туршлага, ярих зүйл бий. Ирээдүйгээ эрсдэлгүй болгохын тулд ямар үйл ажиллагаа явуулах, ямар арга хэмжээ авах ёстой вэ? Өнгөрсөн жилүүдийн алдаа сургамж, ирэх жилүүдийн эрсдэлгүй үйл ажиллагаа гэж юу вэ? Хэлэлцүүлэг яг энэ хүрээнд өрнөсөн.

Хэлэлцүүлэгт эрдэс баялгийн салбарын мэргэжлийн холбоодын тэргүүнүүд, тэргүүлэх компанийн захирлууд, УИХ-ын гишүүд, төр, засгийн төлөөлөл, нийтдээ 120 гаруй төлөөлөгч хүрэлцэн ирэв. ■

# 2014.03.27

Гадаад харилцааны яамны “Зөвшилцөл” хурлын танхим

The Mongolian Mining Journal, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас “МЕГА ТӨСӨЛ” хэлэлцүүлгийг “Тавантолгой цахилгаан станц” төслийн нэгжийн захирал М.Энхсайхантай хамтран зохион байгууллаа.

March 27, 2014

A discussion on Mega Projects was held in cooperation with The Mongolian Mining Journal, with M.Enkhsaikhan, Director of the Tavantolgoi power plant project, among the participants.

Монголын эдийн засагт үлэмж нөлөө үзүүлэх том төслүүд яригдаж байна. Ийм үе цагт уул уурхайн том төслүүдийн тухай хэвшсэн түгээмэл ойлголтоос эрс өөр, “Мега төсөл” хэмээх ухагдахууныг гүнзгийрүүлж ойлгох нь нэн чухал юм. Ялангуяа Мега төслийн тодорхойлолт, зүй тогтол, эмзэг байдал, эрсдэл, анхаарах асуудлуудыг Монголын том төслүүд дээр буулган харж, бодитоор үнэлж цэгнэх нь эрсдэлийг урьдчилан харж, төслөө үр дүнд хүргэхэд туйлаас үнэ цэнтэй гэж Mongolian Mining Journal, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас үзэж байна.

Иймээс бид “Тавантолгой цахилгаан станц” төслийн нэгжийн захирал М.Энхсайханыг урьж, “Мега төсөл” сэдвээр илтгэл тавихыг хүссэн юм. 3 дугаар сарын 27-ны өдөр Гадаад харилцааны яамны “Зөвшилцөл” хурлын танхимд болсон ажил хэрэгч хуралд томоохон төсөл ТЭЗҮ дээр ажиллаж буй компаниудын баг, хараат бус судлаач, шинжээчдийн 100 гаруй төлөөлөл оролцсон юм.

“Тавантолгой цахилгаан станц” төслийн нэгжийн захирал М.Энхсайхан

## М.ЭНХСАЙХАН:

### МЕГА ТӨСӨЛ УЛС ОРНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ЭМЗЭГ БОЛГОДОГ

Бүх юм судалгаан дээр төвлөрөх шаардлагатай тийм эрин цагт бид амьдарч байна. Хаана хөгжил байна, тэнд судалгаанд түшиглэдэг. Хятадад 74 think-tank буюу судалгааны байгууллага бий. Энэ 74 байгууллагын судалгаа шинжилгээн дээр тэрбум хүний амьдралыг авч явах төрийн бодлого нь гардаг. Манайх 10-аад судалгааны байгууллагатай гэж тэмдэглэгджээ. Үнэн хэрэгтээ сайн судалгаа хийдэг байгууллага байхгүй. Судалгааны чадавх маш муу байгаа. Судалгаа муу байгаа цагт бид ухаалаг төртэй байж чадахгүй. ▪

THE JOURNALISM FOR DEVELOPMENT

2010-2018

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ

# СУРГАЛТ

## Trainings

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" 2010 оны дөрөвдүгээр сарын 19-нд байгуулагдсанаасаа хойш сэтгүүлчдийн дунд мэргэжил дээшлүүлэх сургалтыг нийслэл хотод, мөн орон нутгийн сэтгүүлчдэд зориулсан сургалт, хөрөнгийн зах зээлтэй танилцах аяллыг хилийн чанадад тус тус зохион байгууллаа.

To introduce global standards of responsible and independent journalism in Mongolia, and to organise trainings to enable local journalists to collect information, assess and analyse it, and then to write with understanding and skill.

# Сэтгүүлч ТАНАА,

www.journalism.mn сайт сурвалжлагч Таны том цүнхэнд, дэвтэр үзэгтэй тань хамт сэгсчүүлж явсаар хагас сарыг үдлээ. Үзэгч, уншигч олноо хэрэгтэй мэдээ материал бэлтгэх гэж яаруу сандруу алхах сурвалжлагч Таны амьдралын шаргуу хэмнэл, ажил хөдөлмөрч чанар бахархалтай.

Харин сэтгэлдээ ямархан бодол тээж, ар гэртээ ахуй боломж ямар байгааг Танаас өөр тоож сонирхох хүн үгүй ч байж мэднэ. Тиймээс Та манай сайтын эхний санал асуулгад "Сэтгүүлчийн цалин амьдралд хүрэлцдэггүй ээ" хэмээн хариулсан биз ээ. Санал асуулгад оролцсон сэтгүүлчдийн 91 хувь нь "цалин хүрэлцдэггүй" гэсэн хариулт өгчээ. Нийт 160 сэтгүүлч асуулгад оролцсон байна. www.journalism.mn сайтын санал асуулга нэг компьютерээс нэг санал авах горимоор хийгдсэн тул бодитой үр дүнг өгүүлдэг юм. Сурвалжлагчийн сэтгэлд явдаг, магадгүй Эрхлэгчдээ ил гарган ярихаас эмээдэг тэр асуултын хариултыг Эрхэм ээзэд, Эрхлэгч нар аа анхааран үзнэ үү. Энэ бол "нийгмийн халамжийн чанартай" асуулт, хариулт биш агаад олон нийтийн оюун санааны охь болж тэргүүлэн явах учиртай сэтгүүлчид маань өөрсдөө гундуу гандуу амьдарч байгаагийн тусгал юм. Анхаарах цаг нь болсон асуудал мөн билээ.

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" байгууллага үйл ажиллагаагаа эхлүүлсэн сар хагасын хугацаанд телевиз ба сонины сэтгүүлчдэд зориулсан хоёр сургалт зохион байгуулаад байна. Манай дараагийн сургалт орон нутагт зохион байгуулагдахаараа онцлог. Уул уурхай дагасан эдийн засаг эрчимжих шатандаа дэвшиж буй энэ цагт хязгаар нутгуудад хүртэл аварга бүтээн байгуулалт өрнөх нь. Энэ тухай болон бүтээн байгуулалт, их хөрөнгийн урсгал, хотжилтыг даган хөдөлгөөнд орох сайн, муу бүхий л үр дагаврын талаар газар дээрээс нь мэдээлэх учиртай орон нутгийн хэвлэлийнхэн маань хэрхэн ажиллаж байгаа билээ? Тэдэнд ямар бэрхшээл тулгардаг, ямар сургалт шаардлагатай байгаа юм бол? Өнөөдөр бид орон нутгийн тухай газар дээрээс нь сурвалжилсан мэдээллийг зөвхөн Инфо сүлжээний сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээнээс үзэж, сонсож байгаа. Энэ бол их сайн эхлэл юм. Эх орныхоо өнцөг булан бүрээс Инфо сүлжээгээр мэдээлэл татан авч, төв сууриндаа мэдээ цацаж байгаа TV9 телевизийн бүтээлч хамт олонд талархал илэрхийлье.

Говийн бүсийн сэтгүүлчдэд зориулсан манай шинэ сургалтын талаарх сонирхолтой мэдээ, орон нутгийн сурвалжлагчийн санаа бодлыг Та бүхэн www.journalism.mn сайтаас мөдхөн олж уншина. Эх орны хөгжлийн шинэ мөчлөг дор Монгол оронд шинэ сэтгүүл зүйн сэргэг давлагаа түрэн орж ирэг ээ. Тэрхүү давлагаа нь мэргэжлийн түвшин хэмжээх гагц шалгуурт захирагдан, өнөөгийн өнгө мөнгө, зусар болон зуудаг сэтгүүл зүйн үхширсэн арга барилыг арчин гарч ирэг.

Хэрэв сэтгүүлч Танд эдийн засаг болоод уул уурхайн сэдвээр бичих нэвтрүүлэх явцад мэдэхгүй чадахгүйн бэрхшээл гарвал бидэнд хандаарай. Мэргэжлийн хүмүүс, бие даасан судлаач шинжээчдийн эрүүл саруул байр суурийг Танд бид хүргэж, холбоё. Мэргэжлийн хүмүүсийн үг үнэлэгдэх учиртай цаг ирсэн байна. ▪

2010.06.11

# 2010.05.21

MAX Tower

The Mongolian Mining Journal, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас Монголын олон улсын хөрөнгийн корпораци (MICC), МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Санхүүгийн тэнхимтэй хамтран “ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ СУРВАЛЖЛАН БИЧИХ НЬ: АНХАН ШАТНЫ ОЙЛГОЛТУУД” сургалтыг зохион байгууллаа.

May 21, 2010

A training programme on Reporting on Capital Markets was held in cooperation with Mongolia International Capital Corporation (MICC), the School of Economics at The National University of Mongolia, and The Mongolian Mining Journal.

## ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР БИЧДЭГ СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Сэтгүүлчдийн түгээсэн мэдээлэл хурдтай, хүчтэй, шинэлэг байхын зэрэгцээ ул суурьтай баримт, ухаалаг дүн шинжилгээтэй байгаасай гэж “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” үргэлж хүсдэг билээ.

Эдийн засгийн чиглэлээр сурвалжлан бичигч хэн бүхний өмнө санхүүгийн мэдээлэл, үзүүлэлт, шинжээчдийн анализыг ухаж ойлгон, дүгнэлт хийх чадвар шаардагддаг. Тиймээс бид ийм төрлийн мэдээллийг бэлтгэхэд тулгардаг асуудалд хариулт өгөх зорилгоор “Блүүмбергийн мэдээллийг унших нь” сэдвээр мэргэжилтнүүдийн зөвлөгөөг сэтгүүлчдэдээ хүргэхийг хүслээ.

Эдийн засгийн чиглэлээр мэргэшин ажиллаж байгаа сэтгүүлчдэд судлаач, шинжээчид хамгийн үнэ цэнтэй эх сурвалж байх нь гарцаагүй. Үндэсний судлаачдаа түшиглэн сайн судалгаа гаргадаг бүтэц Монголд бий болоод байна. Монголдоо анхдагч гэж хэлэх үндэсний судлаачдын хийж буй бодлогын шинжилгээ, тэдний эхний судалгааны үр дүн, шинжээчдийн санал бодлыг бүхнээс түрүүлж сэтгүүлчдэдээ танилцуулах болсондоо “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” баяртай байна.

“Хөрөнгийн зах зээлийн ойлголт” сэдвээр МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн багш **Д.Одбилэг,** MICC-ийн Ерөнхийлөгч **Д. Ачит-Эрдэнэ,** “Эдийн засгийн ухаан, Бизнесийн мөчлөг ба санхүү, Эдийн засгийн үзүүлэлтүүд, Үзүүлэлтүүдийн уялдаа холбоо, төрийн бодлого” сэдвээр Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Захирал, доктор **Б.Түвшинтөгс** сургалтыг удирдан зохион байгуулжээ.

Энэхүү сургалт нь 2010 он буюу хөрөнгийн зах зээлийн тухай ойлголт Монголын нийгэмд төлөвшиж дөнгөж эхэлж байсан үед сэтгүүлчдэд анхан шатны мэдлэг өгснөөрөө үнэ цэнтэй, өндөр өгөөжтэй ажлууд байв. ■



# 2010.07.02

MAX Tower

The Mongolian Mining Journal, "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ-аас Монголын олон улсын хөрөнгийн корпораци (MICC), МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Санхүүгийн тэнхимтэй хамтран "НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛ" сургалтыг зохион байгууллаа.

July 02.2010

A training programme on Reporting on Coal Market was held in cooperation with Mongolia International Capital Corporation (MICC), the School of Economics at The National University of Mongolia, and The Mongolian Mining Journal.

Хөрөнгийн биржийн мэргэжилтэн Э.Одбаяр

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ-аас хөрөнгийн зах зээл, санхүүгийн мэдлэг мэдээлэл олгох ээлжит сургалтаа хийж байна.

Энэ удаагийн сургалтаар **Хөрөнгийн биржийн мэргэжилтэн Э.Одбаяр** "Үнэт цаасны арилжаа" сэдвээр үнэт цаасны арилжаа, үнэт цаасны индекс, хөгжлийн хандлагын талаар системтэй ойлголт өгсөн бол **судлаач Ц.Тамир** нүүрсний зах зээлийн талаар үндсэний өдөр тутмын сонин, сэтгүүл, сайтын эдийн засаг бизнесийн чиглэлээр мэргэшин ажилладаг залуу сэтгүүлчдэд танин мэдэхүйн сургалтыг хөтлөн явууллаа.



**Нүүрсний үүсэл**

Нүүрс нь органик ба органик бус бодисын маш нарийн нийлмэл хольц юм. 1758 онд М.В.Ломоносов нүүрсийг ургамлаас гаралтай гэсэн онолыг дэвшүүлсэн. Балар эртний ургамал нүүрсжихэд химийн, геологийн, микробиологийн, физикийн зэрэг янз бүрийн хүчин зүйл нөлөөлсөн. Дэлхийд найрлага шинж чанараараа яг ижил нүүрсний 2 орд байдаггүй. Тухайн орд газрын нүүрсийг үүсгэсэн эх материал болон нүүрсжилт явагдсан геологи, цаг уурын нөхцөл нь өөр өөр байгаа юм. Нүүрс нь хамгийн ихээр Кайнозойн эриний гуравдагч (55%) болон Палеозойн эриний пермийн (40%) галавт үүссэн.

Судлаач Ц.Тамир

# 2011.03.30

MAX Tower

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ Монголын олон улсын хөрөнгийн корпораци (MICC) -тай хамтран ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ, ШИНЭЭР ЛИСТИНГ ХИЙХ ҮЙЛ ЯВЦЫГ СУРВАЛЖЛАХДАА ЮУГ АНХААРАХ ТУХАЙ мэргэжилтнүүдийн зөвлөгөө-сургалт зохион байгууллаа.

March 30, 2011

MICC professionals helped conduct a training-and-workshop on Reporting on Stock Markets and New Listing Operations.

Эдийн засгийн чиглэлээр бичдэг сэтгүүлчдэд зориулсан сургалт

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

“Хөгжлийн төлөө сэтгүүлзүй” ээлжит сургалтаа зохион байгууллаа. Сургалтад өдөр тутмын сонин, сэтгүүл, телевизүүдийн сэтгүүлчид хамрагдсан юм. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор Б.Түвшинтөгс тус хүрээлэнгийн судлаачдын бодлогын шинжилгээ хийж буй судалгаануудын талаар сэтгүүлчдэд эхлэн танилцуулав.

Дараа нь судлаач Баярмаа Төсөв, сангийн бодлогод хийсэн дүн шинжилгээг танилцуулсны дараа тэд сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгсөн юм. Судлаачид судалгаа шинжилгээ хийж, дүгнэлтээ гаргаад асуудлаас шийдэх гарц, арга замыг тодорхойлдог боловч түүнийг бодлого боловсруулагчдад хүргэх, олон нийтэд мэдээлэх боломж бага байдаг. Тиймээс мэдээллийг нийгэмд хүргэх гүүр болдог сэтгүүлчид эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж, олон нийтэд зөв тодорхой ойлголт өгөх нь ямар чухал болохыг судлаачид сэтгүүлчдийн аль аль нь хүлээн зөвшөөрч байлаа.

Сургалтын дараагийн сэдэв нь Монголын Олон улсын хөрөнгийн корпораци /MICC/-ийн шинжээчдийн бэлтгэсэн “Хувьцааны арилжаанд хэрхэн оролцох вэ?”, “Эдийн засгийн ухаан, бизнесийн мөчлөг ба санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд, тэдгээрийн уялдаа холбоо, төрийн бодлого” гэсэн үндсэн хоёр сэдэв байсан юм. MICC-ийн брокер Б.Цэцэгийн “Хувьцааны арилжаанд хэрхэн оролцох” талаарх мэдээлэл сэтгүүлчдийн анхаарлыг нэлээд татсан.

Судлаачид сэтгүүлчдэд мэдээлэл өгөөд зогссонгүй харилцан ярилцаж, дотно яриа өрнөсөн ажил хэрэгч сургалт болж өндөрлөлөө. Мэргэжлийн үг хэллэгийг олон нийтэд ойлгогдохуйц энгийнээр бичиж чадвал жинхэнэ сайн сэтгүүлч гэж үздэгээ ч судлаачид сэтгүүлчдэд сануулахаа мартсангүй.

Монголын уул уурхайн компаниуд олон улсын хөрөнгийн бирж дээр IPO хийх замаар хөрөнгө босгох сонирхол нэмэгдсэн, иргэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 10 хувийг үнэгүй эзэмшихээр болсон энэ үед хувьцаа гэж юу болох, уул уурхайн компанийн хувьцааны үнэ хэрхэн тогтдог, уул уурхайн төслийг яаж санхүүжүүлдэг, IPO хийхэд ямар шаардлага тавьдаг зэрэг сэдвээр сэтгүүлчдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор MICC хөрөнгө оруулалтын банкны Ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ сургалтыг удирдан явуулав.

“Эрдэнэс Тавантолгой” ХК хэзээ олон улсын бирж дээр IPO хийвэл тохиромжтой, иргэд 536 ширхэг хувьцаанаасаа ямар өгөөж авах боломжтой талаар мэргэжлийн хүмүүсийн санал зөвлөгөө сэтгүүлчдийн сонирхлыг ихэд татсан юм. Мөн дэлхийн мэдээллийн тэргүүлэгч агентлаг Bloomberg-ийн мэдээллийг хэрхэн ойлгох, мэдээлэл, нийтлэлдээ ашиглах талаар зөвлөгөө өглөө. ■

# ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ХЭМЭЭХ ХАЛУУН АМ БҮЛ ӨНӨРЖСӨӨР...

Г.Идэрхангай, Хөгжлийн төлөө сэтгүүл зүй, The Mongolian Mining Journal

## ТАЛАРХАЛ ХҮЛЭЭСЭН "ХУУЛИЙН ТӨСӨЛ"

Цагаан ордны тэргүүн Барак Обамад сенатч Б.Кардины санаачилсан хуулийн төсөл ихэд таалагджээ. Яг энэ "сэдвээр" Сенатын танхим халуухан хэлэлцүүлэг өрнүүлэх гэж буй хэвлэлүүд мэдээлжээ."Сониныг сэргээх тухай" буюу "Newspaper Revitalization act" хуулийн төсөл боловсруулснаа зарласнаас хойш Мэриленд мужийн эрхэм сенатчид хэвлэлийнхэн "хайр зарлах" нь холгүй байгаа юм. Өнөө маргаашгүй дампуурлын ирмэгт байгаа сонины эрхлэгч нар хүртэл түүн рүү талархлын үгтэй цахим захидлаа илгээсээр. Ямар сайндаа Барак Обама хуулийн төслийг яаралтай баталж өгөхийг хууль тогтоогчдод уриалж байх вэ. Интернэтийн хурдад ялагдан, санхүүгийн асар их хохирол амсч, уншигчдын арми нь өдөр өдрөөр суларсаар байгаа хүчирхэг сонинуудыг аврах талаар Америкийн хэвлэлийн магнатууд ойр ойрхон хэлэлцүүлэг өрнүүлэх болов.

Ноднин өдийд санагдана, АНУ-ын орон нутгийн шилдгийн шилдэг сонин "The Tuscon Citizen"-ний удирдлага гэнэтийн гэмээр мэдэгдэл хийхдээ "Энэ сонин интернэт хувилбарт үүрд шилжлээ" хэмээн нулимс унагаж билээ. Холын Америкийн жишээг Монголд наалдуулах гээд үзье. Яг өнөөдөр Монголын нийт хүн амын 30 хувь нь шуурхай мэдээллийг илүүд үзэж, онлайн мэдээллийн байнгын хэрэглэгч болжээ. "Та сонин хэвлэл хэр их уншиж байна" гэсэн хоргүй асуултыг гудамжинд яваа хэн нэгэнд тавихад "За, бараг зав гарахгүй юм даа. Ихэнх мэдээллээ хэдэн сайтаас авч байгаа" гэж хариулах вий.

Гэхдээ Улаанбаатарын сонин борлуулах цэгүүдийг "чимдэг" элдэв хэвлэлийн тухай энд өгүүлэхээ азная. Орон нутгийн хэвлэл мэдээлэл гэх бүхэл бүтэн цогц ойлголтыг Монголын сэтгүүл зүйгээс салгаж ойлгохын аргагүй учир энэ сэдвийг хөндье. Тэд бол шинэ цагийн дуу хоолой юм.



## “СОНИН МААНЬ ХЭЗЭЭ ИРЭХ БОЛ”…

Ингэж хүлээхээ болиод, интернэт рүү хэдхэн минут ороод л хорвоогийн олон өнгөт мэдээллийг авчих чадвартай болжээ, орон нутгийнхан. Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаанаас үзвэл, интернэт хэрэглэгч гурван хүний нэг нь Улаанбаатарт, 10 хүн тутмын нэг нь хөдөө орон нутагт байна. Ерөөс орон нутгийн мэдээллээ авдаг хоёр гол суваг нь телевиз, интернэт хоёр аж. Эндээс сонин хэвлэл үүргээ яагаад сайн гүйцэтгэж чадахгүй байна вэ гэсэн асуулт гарна биз. Хариулт маш энгийн буюу аймгийн төвөөс сум, сумаас баг, багаас малчны гар дээр захиалсан хэвлэлийг нь хүргэж өгдөг албан ёсны дэд бүтэц одоо хэр хөгжөөгүй.

Тиймдээ ч хөдөөгийн иргэд “Нийгмийн хөгжлийн хурд минут, секундээр хэмжигдэж буй энэ глобал эрин үед хөдөө нутагт сонин хэвлэл найдвартай хүргэдэг түгээлтийн системийг боловсронгуй болгох ёстой” гэж ярьж байна. Жаахан онолдож хэлбэл, орон нутгийн хэвлэлийн ертөнцөд “зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зарчим” алдагдаад байх шиг.

Иргэдийн мэдээлэл авах хамгийн хүртээмжтэй хэлбэр нь сайтууд. Хөдөө, орон нутагт хамгийн хүртээмжтэй 15 вэб сайтыг “www.olloo.mn”, www.gogo.mn тэргүүлж буйг судалгаа харуулж байна.

## БАЯНХОНГОР, ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ХАМГИЙН ОЛОН ХЭВЛЭЛТЭЙ НЬ

Сонгууль дөхөөд ирэхээр хаанахын харъяалалтай нь мэдэгдэхгүй сонин, сэтгүүл борооны дараах мөөг шиг гараад ирдэг гэж найз маань учирлаж байв. Хамгийн хачирхалтай нь сонгууль дуусмагц тэдгээрийн нэлээд нь усанд хаясан чулуу шиг алга болчихдог гэнэ. Иймэрхүү байдлаас болоод хөдөөгийн зарим уншигч сонин хэвлэлд нэг л элэггүй болчихож. Захиалж уншиж байсан сонин нь гэнэт “дампуурчихаар” яалтай ч билээ. Гэхдээ өнөөдөр хэвлэл мэдээллийн хүчирхэг баг зөвхөн орон нутагт л бий. Хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээлэл судалгааны албанаас эрхлэн гаргасан “Монголын хэвлэл мэдээлэл-өнөөдөр” товхимолд “2009 онд манай улсын нийт мэдээллийн хэрэгслийн 34 хувь буюу 116 нь орон нутгийн мэдээллийн хэрэгсэл байдгаагаас 48 нь радио, 40 нь телевиз, 28 нь сонин” гэжээ.

Сонины тоогоороо Баянхонгор, Өвөрхангай аймаг тэргүүлдэг аж. Уншигчдын талархлыг хүлээсэн, байнгын захиалагчтай, идэвхтэй гардаг “Монгол говь”, “Архангайн амьдрал”, "Өнөөгийн Баянхонгор", “Баянхонгор таймс”, ”Сэлэнгийн мэдээ”, “Шинэ мэдээ” зэрэг чөлөөт хэвлэл цөөнгүй. Нийтлэлийн бодлого нь мэдээж бүс нутгийн хөгжил, орон нутгийн иргэдийн ахуй амьдралыг сурвалжлан бичихэд чиглэж байгаа.

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн шилдэг сониноор хоёр ч удаа шалгарсан, “Дорнод” сонины эрхлэгч Б.Туяа нэгэн ярилцлагадаа “Орон нутгийн сонин бол олон түмэнд зөвхөн орон нутгийн мэдээллийг л хүргэх үүрэгтэй. Тэртээ тэргүй олон тооны өдөр тутмын сонин хүрээд ирж байхад бид адилхан мэдээлэл гаргаад яахав дээ. Орон нутгийн сонины үүрэг нь нутагтаа ажиллаж амьдарч буй хүмүүс хаана, юу болж вэ гэдгийг мэдэхийг илүүд үздэг” хэмээн онцолжээ. Энэ бол орон нутгийн хэвлэлийн үүргийг цөөн үгэнд маш тодорхой базаад хэлчихсэн үг. Өмнөговь аймгийн “Монгол говь” сонин “Говь нутгаа хөгжүүлье” гэсэн уриатай ажиллаж байна. Оюутолгой, Тавантолгой зэрэг дэлхийн хэмжээнд яригдаж байгаа баялаг ордуудыг түшиглэн бүс нутгаа хөгжүүлэх талаар тус сонин олон жинтэй өгүүллийг нийтэлж буй.

Орон нутгийн сонинууд голдуу 10-14 хоногийн давтамжтайгаар нэг удаагийн гаралтаар 400-1500 хувь хэвлэгддэг. Тэгэхээр нэг аймаг 70.000-80.000 хүн амтай гээд бодохоор 1500 ширхэг гэдэг хаана ч хүрэхгүй, зөвхөн хэдхэн байгууллагаар тараагдаад дуусах тоо. Гэхдээ орон нутаг оюун сэтгэлгээгээ цэнэглэх хэвлэлтэй байна гэдэг сайхан хэрэг ээ.

Хотод өдөр тутмын сонин хамгийн хүртээмжтэй байхад хөдөө, орон нутагт 7-10 хоног тутмын буюу шар сонинууд илүү хүртээмжтэйг судлаачид тогтоож. Тэгвэл хот, хөдөөг хамарсан хамгийн хүртээмжтэй сониноор “Өдрийн сонин” тодорчээ. “Өдрийн сонин” нэг өдрийн 10000 дугаар хот, хөдөө ялгаагүй уншигчдын гар дээр очдог аж.

## СУВАГ СОЛИГЧ

Миний бие нэгэн удаа Төв аймгийн Жаргалант сумд амьдардаг танилындаа зочилсон юм. Үндэсний телевизээ үзээд сууж байтал гэнэт суваг өөрчлөгдөн TV5-ийн мэдээний хөтөлбөр гараад ирэх нь тэр. “Энэ юу болж байна аа. Хэн сольчихов” гээд гэрийн эзнээс гайхан асуутал мань эр “Сумын зурагтын антенн дээр суудаг ах л сольчихгүй юу. Тэр хүссэн үедээ суваг солино. Түүнийг нь бид хүссэн хүсээгүй үздэг юм” хэмээн хээвнэг хариулж билээ. Хөдөө, орон нутгийн зарим иргэд телевизийн мэдээллээ иймэрхүү “сонголтгүй” хэлбэрээр хүлээн авч байна.

Өнөөдөр телевиз, радиогүй аймаг гэж үгүй. Хөвсгөл 14, Дорнод 11, Дархан-Уул, Орхон аймаг тус бүр 9 телевизтэй болсон нь одоогоор хамгийн өндөр үзүүлэлт. Харин үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацаж байгаа томоохон телевизүүд гэвэл МҮОНТ, МN-25-р суваг, UBS, ТВ5, ТВ9, Боловсрол суваг гэсэн цөөн хэдэн телевиз л бий. Ерөнхийдөө бол Улаанбаатар хотод 24, хөдөө орон нутагт 44 телевиз нэвтрүүлгээ хүргэдэг гэж Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаанд дурджээ.

Эндээс харахад орон нутагт нэлээд олон телевиз үйл ажиллагаа явуулж байгаа мэт. Гэтэл яг газар дээрээ хамрах хүрээ нь хязгаарлагдмал, зөвхөн аймгийн төвийн хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг гээд чамгүй бэрхшээл учирдаг байна. Орон нутгийн телевизүүдийн нэвтрүүлэг цацалтын цаг гэж үнэхээр чамламаар. Улаанбаатарт 24 телевиз долоо хоногт 2644 цагаар нэвтрүүлэг цацаж байхад хөдөө орон нутагт 281 цаг л ногддог. Үнэхээр хангалтгүй.

Нэг үеэ бодвол хөдөөгийн малчин айлууд гаднаа салхин сэнс бүхий бага оврын антенн суурилуулчихаад зурагтын мэдээгээ үзчихдэг болсон. Зарим нь бүр утасгүй интернэтэд холбогдоод алс холын Солонгост байгаа хүүхэдтэйгээ мэйлдэж суудаг малчид ч бий. Телевизүүд сүүлийн үед хөдөө нутагт анхаарлаа хандуулдаг болжээ. Орон нутгийн амьдралыг орхигдуулдаггүй хамгийн мэдрэмжтэй телевиз нь ТВ9 гэж хөдөөгийн иргэдийн ярихыг би олон удаа сонсч байв. ТВ9 хөдөө орон нутгийн сурвалжлагчдын "Инфо" сүлжээг Монголын телевизийн ертөнцөд анх удаа байгуулсан. Маш хүчирхэг сүлжээг тогтоож чадсан. Тэр ч утгаараа хөдөөгийн иргэдийн үзэх дуртай телевиз болжээ.

"Боловсрол суваг" ч гэсэн малчдад зориулсан цуврал нэвтрүүлгүүд бэлтгэж, цаг агаарын мэдээг маш дэлгэрэнгүй, сонирхолтой хүргэж байгаад хөдөөгийнхөн ам сайтай байдаг юм билээ.

МҮОНТ бол том айл. Хөдөө орон нутгийн иргэдэд тус телевиз хамгийн чанартай, бодитой мэдээлэл өгч байгаа. Гэхдээ хамгийн гол дутагдал нь орон нутагт өөрийн гэсэн сурвалжлагчгүй. Энэ нь төсөв санхүүтэй холбоотой байдаг биз ээ.

Хөдөө, орон нутагт кабелийн телевизүүд нэлээд олноор байгуулагджээ. "Болор утас", "Миний Монгол", "Алтанговь" гээд нэрлээд байвал цөөнгүй. Бүгд л өөр өөрийн гэсэн өнгө дуу хоолойтой. Энэ мэтээр орон нутгийн "мэдээлэлжих" орчин бэхэжсээр байгаа юм.

## РАДИО ШИГ БАГА ЗАРДАЛТАЙ ХЭРЭГСЭЛ БАЙХГҮЙ

Тийм ээ, хамгийн бага зардалтай хэрнээ хамгийн их мэдээлэл агуулдаг хэрэгсэл нь радио. Улсын хэмжээнд өдгөө нийт 74 радио үйл ажиллагаа явуулдаг хэмээн Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаанд онцолжээ. Улаанбаатар хотод 23, орон нутагт 50 радио одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа аж. "Боржигон нутаг", "Бурхантын цуурай", "Эрдэнэсийн гайхамшиг", "Говийн долгион" гээд нэр нь хүртэл чихэнд сонсголонтой FM-үүд олноор байгуулагдсаар байгаа юм. Эдгээр радио зөвхөн аймгийн төвд нэвтрүүлгээ цацдаг гэвэл хэтэрхий өрөөсгөл болно. Ялангуяа Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн FM радио хэд хэдэн сумдыг мэдээллээр хангаж байна. Өнгөрсөн өвлийн зуднаар хотоо харлуулчихалгүй авч үлдсэн малчдын дийлэнх нь радиогийн байнгын сонсогчид байсан тухай яриа байдаг. Хашир малчид өөрт ашигтай мэдээ, мэдээллийг бусдаас түрүүлж авч, түүнийгээ амьдрал дээрээ ашиглаж чадаж буйн давуу тал энэ.

Одоогоор улсын хэмжээнд хамгийн идэвхтэй нэвтрүүлгээ цацаж байгаа нь Монголын радио. Монголын радио хөдөө орон нутагт өөрийн гэсэн сурвалжлагчтай, хөдөөгийн иргэдэд зориулсан мэдээ, мэдээллийн тогтмол цагтай, цацалтын хүрээ өргөн зэргээрээ бусад радиогоос эрс ялгардаг.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн ам бүл ийнхүү өнөржихийн хэрээр бас залуужиж байна. Сэтгүүл зүйн сургуулиа дөнгөж дүүргээд өсч төрсөн нутагтаа очиж ажиллахаар явж байгаа залуусыг хараад талархах сэтгэл төрдөг юм. Тэд орон нутгийн хэвлэл мэдээллийн салбарт шинэлэг өнгө аяс оруулах нь дамжиггүй ээ. Энд нэгэн зүйлийг онцлох нь зүйтэй болов уу. "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ алс хязгаар нутгийн хахир өвлийн хүйтэнд ч нар төөнөсөн зуны шатам халуунд ч дэвтэр, үзэг хоёроосоо үл салан сэтгүүл зүйдээ үнэнч зүтгэж яваа зуу зуун сэтгүүлчдээ дэмжиж ажиллана. Шинэ цагийн сэтгүүл зүйн дуу хоолой "www.journalism.mn" сайт чухамдаа хөдөөгийн сэтгүүлч таны үгээ чөлөөтэй илэрхийлэх талбар юм. Орон нутгийн хэвлэл мэдээллийнхэнд зориулсан манай сургалт эхлэх гэж байна. ▪

Өмнөговь, 2010.06.14

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСӨЛ

Төслийг санаачлагч “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” нь 2010 онд The Mongolian Mining Journal-ийн дэргэд, тус редакцын санаачлагаар байгуулагдсан, ашгийн бус, мэргэжлийн сэтгүүл зүйн үйл ажиллагааг дэмжих зорилготой Төрийн бус байгууллага болно.

Өмнөговь аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд зориулсан “УУЛ УУРХАЙН МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ АРГА ЗҮЙ” сургалт

## 2010

Өмнөговь аймаг.
Даланзадгад хот. 2010.06.20

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төсөл нь сэтгүүлчдийн санаачлагаар хэрэгжиж, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөр дэмжлэг үзүүлж буй төсөл юм.

“ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСӨЛ **БҮСИЙН СУРГАЛТ**

## 2015

**ХОЙД БҮСИЙН СУРГАЛТ**

Сэлэнгэ аймаг. Сүхбаатар хот
2015.05.26-27-ны өдрүүд

“ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСӨЛ **НЭГДСЭН СУРГАЛТ**

## 2016

**НЭГДСЭН СУРГАЛТ, ТАНИЛЦАХ АЯЛАЛ**

Улаанбаатар хот. Хууль зүйн хүрээлэнгийн “Хуульчид” танхим 2016.04.02
Сэлэнгэ. Баянгол сум. Бороогийн алтны уурхайн нөхөн сэргээлттэй танилцах аялал 2016.04.03

“ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСӨЛ **21 АЙМГИЙН НЭГДСЭН СУРГАЛТ**

## 2017

**ТАНИЛЦАХ АЯЛАЛ**

Өмнөговь аймаг.

| | |
|---|---|
| Ханбогд | 2017.06.28-29 |
| Цогтцэций | 2017.06.30 |
| Даланзадгад | 2017.07.1-2 |

“ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСӨЛ **21 АЙМГИЙН НЭГДСЭН СУРГАЛТ**

## 2018

**НЭГДСЭН СУРГАЛТ**

Төв аймаг. Монгол-Кувейтын Байгаль хамгаалах төв
2018.05.28-29



“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн үндсэн зарчим нь аль нэг компани, орон нутгийн удирдлага, гадаадын аль нэг байгууллагын ашиг сонирхлоос ангид байж; бодит мэдээллийг орон нутаг төдийгүй нийслэл Улаанбаатар, манай орны бусад аймаг сумын хэмжээнд хүртээмжтэй түгээн дэлгэрүүлэх; орон нутгийн сэтгүүлчдэд уул уурхай, эдийн засгийн мэргэшсэн сэтгүүл зүйн арга барилыг эзэмшүүлэхэд чиглэнэ.

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төсөл нь ганц удаагийн сургалтын арга хэмжээ биш бөгөөд мэдээллийн олон талт урсгалыг тогтмолжуулан, сэтгүүл зүйн мэргэжлийн арга зүйгээр байнга дэмжих, цаашид урт хугацаанд тогтвортой үргэлжлэх ажил болно.

Өмнөговь аймгийн сэтгүүлчдийг хамарсан “Уул уурхайн мэдээллийг түгээх арга зүй” сургалтыг 2010 онд орон нутагт хийсэн нь хөдөө орон нутгийн сэтгүүлчдэд зориулан зохион байгуулсан анхны мэргэших сургалт юм.

**БАРУУН БҮСИЙН СУРГАЛТ**

Баянхонгор аймаг. Шаргалжуут.
“Өгөөж Булган” жуулчны бааз
2015.06.25

**НЭГДСЭН УУЛЗАЛТ**

Улаанбаатар хот. Blue Sky Tower
2015.11.10

**НЭГДСЭН СУРГАЛТ**

Өвөрхангай аймаг. Хархорин сум
2016.08.14-15-ны өдрүүд

**НЭГДСЭН СУРГАЛТ**

Улаанбаатар хот. Blue Sky Tower
2016.11.14-15-ны өдрүүд

**ХААЛТЫН СУРГАЛТ**

Улаанбаатар хот.
“Туушин” зочид буудал “Сүлд” танхим 2017.10.09-10

**ТАНИЛЦАХ АЯЛАЛ**

Өмнөговь аймаг.
Ханбогд, Цогтцэций сум
2018.10.13-14

**НЭГДСЭН УУЛЗАЛТ**

Улаанбаатар хот.
2018.11.15-16

# LOCAL NEWS NETWORK

The main objective of the Local News Network project is to make possible and ensure dissemination of information to not just local communities but also to Ulaanbaatar and other provinces. To be reliable, this information has to be independent of any corporate or political interests, domestic or foreign, and has to be obtained and presented according to the highest standards of journalism.

Methodology to distribute mining information training for journalists in the media in Umnugovi province

## 2010

Dalanzadgad city. Umnugovi province.
2010.06.20

MMJ journalists have run the project with support from GIZ IMRI (Integrated Mineral Resources Initiative).

**REGIONAL TRAINING**

## 2015

NORTHERNREGIONALTRAINING

Sukhbaatar city. Selenge province.
2015.05.26-27

**COMBINED TRAINING**

## 2016

Study trip to Ulaanbaatar city, 2016.04.02

Field trip to see reclamation work at Boroo gold mine in Bayangol soum in Selenge aimag. 2016.04.03

**COMBINED TRAINING FOR PARTICIPANTS FROM 21 PROVINCES**

## 2017

Field trips to Umnugovi province, Khanbogd soum
2017.06.28-29, to Tsogttsetsii soum
2017.06.30, and to
Dalanzadgad soum 2017.07.01-02

**COMBINED TRAINING FOR PARTICIPANTS FROM 21 PROVINCES**

## 2018

Tuv aimag, 2018.05.28-29



Local News Network project is not affiliated to and does not represent the interests of any business, local administration and international organization. The basic goal is to ensure distribution of accessible and accurate information to the local regions and Ulaanbaatar and to help local journalists specialising in mining and economic issues improve their professional skills.

Local News Network project is not intended to be a single-time training workshop. It will be a long-term and sustainable programme that stabilises multi-sided information flow and provides regular support to professional journalism with a carefully designed methodology and approach.

The 2010 training for journalists in Umnugovi aimag on methodology of mining news distribution was the first ever specialized training in Mongolia for local journalists.

WESTERN REGIONAL TRAINING

Shargaljuut. Bayankhongor aimag,
2015.06.25

Combined training
Ulaanbaatar city
2015.11.10

Combined training for participants from 21 provinces

Uvurkhangai aimag, Kharkhorin soum
2016.08.14-15

Combined training
Ulaanbaatar city
2016.11.14-15

Combined training for participants from 21 provinces

CONCLUDING TRAINING
Ulaanbaatar city.
2017.10.09-10

Study trip for all participants

Umnugovi province.
Khanbogd, Tsogttsetsii soum
2018.10.13-14

Combined training
Ulaanbaatar city
2018.11.15-16

# 2010.06.20

Өмнөговь аймаг, Даланзадгад сум

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь Уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж буй Өмнөговь аймгийн хэвлэл мэдээллийн бүх байгууллагын сэтгүүлчид оролцсон “УУЛ УУРХАЙН МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ АРГА ЗҮЙ” сургалтыг 2010 онд зохион байгууллаа.

June 20, 2010

A training on Methodology of Disseminating Mining Information, held in cooperation with The Mongolian Mining Journal, was attended by journalists from all media organizations in Umnugovi province, which had started to become the mining hub of Mongolia.

Орон нутгийн сэтгүүлчдэд эдийн засаг, уул уурхайн салбарын тухай ойлголт өгсөн анхны мэргэжих сургалтын ажил болсон гэдгээрээ Монголын хэвлэлийн түүхэнд үлдэх үйл явдал юм.

MMJ-ийн сэтгүүлчид заах аргын онолын ямар ч мэдлэггүй ч өөрсдийн сурвалжлан бичих ажилд тохиолддог зүйлс, туулсан туршлагын хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулан эхний жилийн сургалтыг явуулсан билээ.

Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр нийтлэл бичиж, нэвтрүүлэг хийдэг бидэнд сургах гэхээсээ илүү сэтгүүлч андуудтайгаа хуваалцах туршлага байсан юм. Орон нутгийн сэтгүүлчид үзэг нэгтнүүдийнхээ хөдөлмөрийг үнэлж, ийм практик сургалтын үнэ цэн зайлшгүй байгааг хэлж, цаашид үргэлжлүүлэх том урам өгсөн юм. ■

## www.metalprices.com ба ӨМНИЙН ГОВИЙН СЭТГҮҮЛЧИД

Э.Сайхантуяа, The Mongolian Mining Journal, "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй"

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" орон нутгийн сэтгүүлчдийг зориод ирлээ. Монгол орны өнцөг булан бүрт ажиллаж, хөдөлмөрлөн байгаа үзэг нэгт олон арван нөхдөдөө зориулах бидний анхны сургалт Өмнөговь аймгаас эхэлсэн нь энэ юм. Залуу сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмээ хөтөлж манлайлахад нь дэм үзүүлэх зорилгынхоо жимээр өмнийн цэнхэр говийг сонгосон нь ч учиртай.

Улсын эдийн засгийг өөд татаж амархан дөнгөх хэмжээний ашигт малтмал, эрдэс баялгийг хэвлийдээ хадгалсан энэ нутгийн сэтгүүлчдэд мэдлэгтэй, чадвартай, мэргэжилдээ үнэнч, туушгай зүтгэх өндөр хариуцлага хэзээ хэзээнээс илүүтэй ногдож байгаа юм. Тийм ч учраас говийн сэтгүүлчдэд уул уурхайн үйлдвэрлэлийн талаар өргөн мэдлэг хэрэгтэй байна.

Хоёр өдөр үргэлжилсэн сургалтын үеэр тэдэнд уул уурхайн үйлдвэрлэлийн үр өгөөж, үүсэх эрсдэл болоод түүнээс хэрхэн сэргийлэх, хөрөнгийн зах зээлийг сурвалжлан бичих, энэ захаас мөнгө босгох боломж хийгээд сэтгүүлчдийн өөрсдийнх нь хүсэлтээр эрэн сурвалжлах, теле сэтгүүл зүйн талаар баримтад суурилсан сургалт зохион байгуулсан. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийнхээ менежментээс эхлээд бүхий л хариуцлагыг хамтдаа үүрдэг тэдэнд сонин сэтгүүлийн гэрэл зургийн стандарт, түүний хэм хэмжээнд тохируулан авахад юуг анхаарах, нөгөө талаас сонин, сэтгүүлийнхээ борлуулалт маркетингийг хэрхэн оновчтой зөв төлөвлөж, удирдан явуулах талаар зөвлөгөө мэдээлэл өрнөсөн.

Монгол орны хамгийн том газар нутгийг эзлэн оршдог Өмнөговь аймагт өдгөө хэвлэл мэдээллийн дөрвөн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. Арав гаруйхан жилийн өмнө аймгийн удирдлагын дэргэдэх Хэвлэлийн албанаас өөр мэдээлэл түгээх хэрэгсэл өмнөд говьд байгаагүй байна. Хүнээр бол ухаан сууж ч амжаагүй энэ хугацаанд говийн сэтгүүлчид 50 гаруй мянган хүн амд зориулан мэдээллийг нэгэн зэрэг түгээдэг гурван ч төрлийн суваг үүсгэн байгуулж, өсгөж дэвжээн ажиллаж байна. Сонин, телевиз, богино долгионы радиогийн алинд ч сэтгүүлчид үндсэн үүргийнхээ хажуугаар өөрсдийнхөө хүчээр захиалга, борлуулалтыг нь явуулж, менежмент, санхүү тооцоогоо давхар хариуцдаг болохоор жинхэнэ "универсиал" гэж орон нутгийн сэтгүүлчдийг нэрлэхээр болжээ, дээрх хугацаанд. Тийм ч учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн маркетинг, борлуулалт явуулах хотын туршлага тэдэнд нэлээд өгөөжөө өгсөн нь лавтай.

Нийслэлд бол сонин, сэтгүүл, телевиз, FM-ийн зөвхөн удирдлагуудад л хамаатай байж мэдэх дээрх сэдвийг говийн сэтгүүлчид харин нийтээрээ анхаарал хандуулсан, хэрэгцээтэй сургалт байлаа. Сониныхонд бол гэрэл зураг, аппарат, техник хэрэгслийн орчин үеийн мэдээлэл, арга туршлага илүүтэй таалагдсан. Үзэг дэвтэрнээс гадна тэдэнд зургийн аппарат хамгийн чухал. Сонины өнгө төрхийн амин сүнс болсон гэрэл зургаа өөрсдөө авдаг учир мэргэжлийн хүнээс үг сонсох сайхан боломж сургалтын үеэр олдсон юм.

Сургалтад өмнөд говийн төвийн мэдээллийн хэрэгслийн сэтгүүлчид 100 хувь хамрагдлаа. Өөрсдийг нь гээд зориод очсон мэргэжлийн байгууллагынхан бидэнд ч мөн сурч мэдье, мэдлэгээ тэлье гэсэн тэдний идэвх зорилго орон нутгийн сэтгүүлчдийн төлөө ихийг хийх эрмэлзлийг маань улам ч бадраасныг тэмдэглэе.

Ямартай ч хоёр өдрийн сургалтын эцэст говийн сэтгүүлчид маань www.bloomberg.com, www.lme.com, www.metalprices.com сайт руу хандаж алт, зэс, газрын тос, нүүрс гээд монголчуудтай холбоотой гол гол түүхий эд, металлын өдөр тутмын ханшийг сонирхох, Монгол орны газар нутагт орд эзэмшиж байгаа гадны хөрөнгө оруулалттай томоохон компаниудын симбол болоод түүнийг ашиглаж хувьцааны үнийг нь тандах, ханшийн хэлбэлзэлд анализ хийх мэдлэгийг олж авсан төдийгүй уул уурхайн үйлдвэрлэлийг сэтгүүлч бид яагаад дэмжих ёстой болон хэрхэн хяналт тавьж ажиллах, үйлдвэрлэлийн явцад өртөж буй байгаль орчин, соёлын ховор нандин өвийг хамгаалах талаар нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, сэтгүүл зүйд эрэн сурвалжлага явуулахад хэрэгтэй зориг, арга, үүргээ улам ч ухамсарласан юм.

Мөн хөрөнгийн зах зээлийн суурь ойлголт хийгээд хэвлэл мэдээллийн хэрэгслийн маркетинг төлөвлөлтийг удирдан явуулах, сонин, сэтгүүлийн гэрэл зургийг оновчтой авах талаар туршлагад суурилсан мэдлэг олж авсан. ▪

# ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ БАЙГУУЛЖ БАЙНА

Уул уурхай, эдийн засгийн салбарын олон сэдвээр бодитой бичих, нэвтрүүлэхийн тулд сэтгүүлчдэд суурь мэдлэг, мэдээлэл чухал.Тэр тусмаа өргөн уудам Монгол орны аймаг, сум хязгаарт алслан суурьшсан ард иргэдэд уул уурхайн салбарын бодит мэдээлэл хүргэх үйлс онцгой. Тиймээс “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” төрийн бус байгууллага орон нутгийн мэргэжил нэгт сэтгүүлчдийнхээ мэдлэгт нэмэр тус болохыг илүүтэй чухалчилж ирэв.

The Mongolian Mining Journal-ийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ Орон нутгийн мэдээллийн сүлжээ байгуулах зорилтыг 2015 онд тавьсан юм. Ингэхдээ өмнөх сургалтын туршлага дээрээ суурилан, Бүсийн хэмжээнд орон нутгийн сэтгүүлчдийн бүх төлөөллийг хамарсан томоохон сургалтын ажил зохион байгуулахаар зориг шулуудсан болно. Илүү олон сэтгүүлчийг хамрах, улмаар шатлан өргөжүүлэх, цуврал сургалтуудын дүнд уул уурхайн анхан шатны ойлголттой бичдэг, нэвтрүүлэг бэлтгэдэг мэргэшсэн сэтгүүлчдийн төлөөллийг орон нутагт төлөвшүүлэх нь чухал байгаа билээ.

Ирээдүйн өгөөж өндөр, бодит мэдээллийн байнгын урсгал бий болгох энэхүү төслийн эрэг зорилгыг маань ойлгож дэмжсэн Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн (GIZ) Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга (ЭТИС) хөтөлбөр, мөн Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын албанд талархал илэрхийлье. Түүнчлэн сургалтад идэвхтэй оролцсон орон нутгийн амаргүй нөхцөлд ажиллаж, сэтгүүл зүйн шилдэг бүтээл туурвиж яваа дайчин сэтгүүлчдэдээ талархал илэрхийлье.

Манай сургалтын хөтөлбөрт: эрдэс баялгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн онцлог, сурвалжлах арга зүй, эрдсийн үнэ ханшийн хандлага, технологи, хэрэглээний талаарх шинэ мэдээлэл, ялангуяа тухайн аймаг, суманд үйлдвэрлэл явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагааны онцлог, улс орон нутгийн төсөвт өгч буй татварын хэмжээ, нөхөн сэргээлт, нийгмийн чанартай арга хэмжээний өгөөж, иргэд ба компанийн ойлголцлын асуудал зэрэг өргөн хүрээтэй сэдвийг хамардаг. Сургалтад тараах төрөл бүрийн гарын авлагыг MMJ-ийн Редакци бэлтгэх төдийгүй телевизийн уран бүтээлчдэд зориулсан видео хичээл, нэвтрүүлгийн жишээ, бусад материалыг сургалтдаа өргөнөөр ашиглаж байна.

Сэтгүүлчийн сургалтаас олж авсан шинэ мэдлэг мэдээллийн цаана сум орон нутгийн мянга мянган иргэд бодит мэдээлэл хүлээн авах ач холбогдолтой юм.

“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн сургалтанд хамрагдсан сэтгүүлчийнхээ дунд сурвалжлага, нийтлэл, телевизийн баримтат нэвтрүүлгийн уралдаан зохион байгуулж, сайн бүтээлүүдийг урамшуулдаг онцлогтой. Аймаг, сумандаа өрнөж буй уул уурхайн үйлдвэрлэлийн талаар сурвалжлан бичсэн, асуудал дэвшүүлсэн, эрэн сурвалжилсан, нутгийн иргэд, засаг захиргааны олон талт байр суурийг нээлттэй илэрхийлсэн материалуудыг Улаанбаатарт өргөнөөр цацах зэрэг ажлыг хийхээр The Mongolian Mining Journal төлөвлөж байна.

Орон нутгийн мэдээллийн сүлжээгээ The Mongolian Mining Journal ганц төслөөр, цөөн удаагийн сургалтаар хязгаарлахгүй ба цаашид цөөнгүй жил хамтран ажиллаж, Редакциудыг мэргэжлийн арга зүйгээр дэмжин, орон нутгийн мэдээллийг Улаанбаатарын хэрэглэгчдэд ойртуулсаар байх болно. ▪

# ESTABLISHING LOCAL NEWS NETWORK

Journalism for Development NGO believes that it is very important for journalists covering mining and the economy to have a clear understanding of their subjects and to be well-informed about them at all times. Only this would enable them to provide accurate information and sensible analyses to readers and the TV audience. The need is stronger in the distant aimags and soums, where the mining sector is active. Thus our emphasis has always been on improving the skills of local journalists.

In a bid to meet that need, we created a local news network in 2015. Since then, we have gone on arranging bigger training courses to accommodate more local journalists. Our final goal is to create a nationwide pool of professionally competent journalists who can write articles and produce TV programmes on mining based on their in-depth knowledge and understanding of the sector.

We express our thanks to GIZ IMRI (GIZ Integrated Mineral Resources Initiative), and MEITI (Mongolia Extractive Industries Transparency Initiative) for supporting our project which, for the record, is not meant to make money for MMJ, but will benefit followers of media by ensuring reliable information flow. Our sincere gratitude goes to the journalists who participated in the training courses and who make special efforts to produce excellent work in difficult conditions.

The contents of the programme include discussions on the following: main features of mining production, methods of reporting, outlook of mineral commodities price, technology, new information about consumption, special features of operations of mining companies active in local aimags and soums, their tax contribution to the local and the state budgets, reclamation, corporate social responsibility, relations between citizens and companies, etc. MMJ will prepare diverse material to be distributed among attendees, including material from TV programmes and video tutorials.

The trainings are vitally important as what journalists pick up in them will be reflected in the information they present to thousands of local citizens.

To make learning fun, and also to assess the efficacy of the training, all participants of the local news network project will take part in contests to choose the best reportage, the best background articles, and the best TV programme. The winners will receive awards, and the best reports will be published in the Mongolian Mining Journal. The entries will certainly include descriptive and analytical pieces on mining in the aimags and soums as also investigative reports and representation of the views of multiple stakeholders -- local citizens, the local government, etc.

This local news network project is planned to go beyond these trainings, as we hope to work together with the journalists for many years to come, continuing to offer them updated professional help, bringing local news nearer to Ulaanbaatar readers. ■

# О.БАТБОЛД: ЭНЭ УДААГИЙН СУРГАЛТ ЗӨВХӨН НЭГ АЙМАГ ГЭЛТГҮЙ БҮСЭЭР НЬ ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙГААРАА ОНЦЛОГ

Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн Дэд захирал О.Батболдоос зарим зүйлийг тодрууллаа.

**Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа юунд чиглэж байна вэ?**

Манай хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа аймаг орон нутагт талуудын хамтын ажиллагааг дэмжиж, уул уурхайн талаарх зөв ойлголт, мэдээллийг хүргэх, ингэснээр уул уурхайн давуу талыг ашиглаж аймаг, орон нутгаа хөгжүүлэх ямар боломж байгааг талууд хамтран тодруулж, хэрэгжүүлэхэд нь туслах юм.

Ийм үйл ажиллагааг бид Сэлэнгэ, Баянхонгор, Увс аймагт хэрэгжүүлж байна. Орон нутгийн сэтгүүлчид маань бидэнд зориулсан сургалт зохион байгуулаач гэсэн санал гаргадаг байсан. “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын тавьсан санал ч сэтгүүлчдийн тавьж байсан хүсэлтэй нийцсэн болохоор бид уг сургалтыг зохион байгуулж байгаа юм. Энэ сургалтаа зөвхөн нэг аймаг гэлтгүй бүсээр нь зохион байгуулж буйгаараа онцлог.

**Сургалтыг цаашид өргөжүүлэх тал дээр хэрхэн ажиллах вэ?**

Сургалт нэг удаагийнх биш. Нэг удаагийн сургалт хүмүүст мэдлэг мэдээлэл өгдөг ч цаашид хөгжих, цогц мэдээлэл олгоход хангалтгүй байдаг. Тиймээс бид орон нутгийн сэтгүүлчдийн сургалтыг үргэлжлүүлж хийхээр төлөвлөсөн. “Хөгжлийн төлөө сэтгүүлзүй” ТББ-тай хамтран ажиллаж буй гол зорилго маань ч энэ. Бид орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ бий болгохыг зорьж байна. Энэ удаад хойд бүсийн 5 аймгийн сэтгүүлчдэд сургалт зохион байгууллаа. Удахгүй Баянхонгор аймагт баруун бүсийн аймгуудын сэтгүүлчдэд сургалт зохион байгуулах болно. Үүний дараа 11 дүгээр сард Улаанбаатар хотод баруун, төвийн бүсийн сургалтад хамрагдсан сэтгүүлчдээ оролцуулан нэгдсэн арга хэмжээ зохион байгуулна.

Орон нутгийн сэтгүүлчид хоорондоо туршлага солилцох, уул уурхайн талаарх мэдээллээ солилцох нь чухал. Мөн сэтгүүлзүйн бүтээлээрээ өрсөлдөх, шилдэг бүтээлийг урамшуулах, сайн бүтээлийг товхимол байдлаар хэвлүүлэхээр төлөвлөсөн. Энэ нь сургалтад оролцож чадаагүй бусад сэтгүүлчдэд үр өгөөжөө өгөх болов уу хэмээн найдаж байна.

Энэ бүх үйл ажиллагааг “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” төрийн бус байгууллага хамтран зохион байгуулах болно.

**Сургалтаас ямар үр дүн хүлээж байна вэ?**

Хүлээлт бий. Орон нутгийн сэтгүүлчид уул уурхайн талаар тодорхой хэмжээгээр бодит зөв мэдээлэлтэй болох, тодорхой баримттай бүтээлүүд гаргах байх гэж найдаж байна. Тэр бүтээлүүд орон нутгийн иргэдэд уул уурхайн талаар үнэн зөв, бодитой мэдээллийг хүргээсэй. Сэтгүүлчид маань бидний энэ зорилгод нэгдэж ажиллах байх.

Нөгөө талаар энэ удаагийн сургалтаар сэтгүүлчид компаниудтай харьцах, төрийн байгууллагатай харьцах талаар тодорхой арга зүй, тактик сурсан байх. Ядаж л танай компанид нийгмийн хариуцлага байхгүй байна, орон нутгийн иргэдийн дуу хоолойг сонсох, тэдэнд үйл ажиллагаагаа танилцуулах ёстой гэж хэлж чадах байх гэж бодож байна. Энэ нь нэг удаагийн арга хэмжээ биш болохоор сэтгүүлчид цаашид энэ чиглэлээр хоорондоо туршлага солилцож, улам чадавхжих боломжтой болно гэж итгэж байна.

**Танай хөтөлбөр өөр ямар төслүүд хэрэгжүүлж байна вэ?**

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг бол Герман, Монголын Засгийн газрын хооронд байгуулсан Хөгжлийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Манай хөтөлбөр эрдэс баялгийн тогтвортой менежмент хэсгийн цөм төсөл. Манай хөтөлбөрөөс гадна Мэргэжлийн боловсролын төсөл амжилттай хэрэгжиж байна. Олон аймагт чадвартай ажиллах хүчнийг бэлтгэж байгаа. Герман-Монголын ашигт малтмал, технологийн их сургуулийг байгуулсан нь хэрэгжсэн бас нэг төсөл юм.

Манай “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөр 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. Нэгдүгээрт, уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа орон нутгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх, хоёрдугаарт, макро эдийн засгийн тодорхой бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт судалгаан дээр суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, гуравдугаарт, Герман, Монголын хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр ажилладаг. Герман улсын Канцлер Ангела Меркель Монгол улсад айлчлах үеэр ашигт малтмал, технологи, үйлдвэрийн салбарт хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээг хэрэгжүүлэхэд манай хөтөлбөр дэмжлэг үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яамтай хамтраад байгаль орчинд учруулсан хохирлыг амьдрах орчны үнэлгээгээр хийдэг болох төсөл амжилттай хэрэгжиж байна. Мөн Хөдөлмөрийн яамтай хамтраад хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хууль эрхзүйн орчин, стандартыг шинэчлэх ажлууд хийж байна. Энэ чиглэлээр Уул уурхайн яам, Ашигт малтмалын газартай ч хамтран ажиллаж байгаа.

**Хувийн хэвшлийг дэмжих, Германы хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр Герман-Монголын бизнес эрхлэгчдийн холбоотой нягт хамтран ажилладаг байх аа?**

Сүүлийн 3 жил Герман-Монголын бизнесийн өдрийг зохион байгуулж, Германы компаниудыг Монголд үйл ажиллагааг нь танилцуулах, Монголын компаниудтай холбох ажлыг зохион байгууллаа. Энэ арга хэмжээ цаашид ч үргэлжилнэ.

Энэ мэтээр хувийн хэвшил, төрийн байгууллага, орон нутагтай тус тусын чиглэлээр хамтран ажилладаг. Үүн дээр нэмээд сэтгүүлчидтэй хамтран ажиллаж байна. Сэтгүүлчидтэй хамтран ажиллах бас нэг ажил төлөвлөж байгаа нь үндэсний хэмжээнд 15 сэтгүүлчийг чадавхижуулах 1.5 жилийн хугацаатай сургалтыг Германы хэвлэлийн байгууллагатай хамтран зохион байгуулах гэж байна. Манайд чадварлаг сэтгүүлч олон бий. Монголынхоо сэтгүүлчдийг олон улсын сэтгүүлзүйн шинэ хөгжилтэй уялдуулах зорилготой. Монголд тодорхой хугацаанд тодорхой чиглэлээр сургалтуудад хамрагдахаас гадна Европт болж байгаа арга хэмжээнд оролцож, тэндээсээ сэтгүүлзүйн бүтээл туурвих зэргээр 1.5 жилийн хугацаанд хэрэгжих төслийг зохион байгуулахаар бэлтгэж байна.

Монгол улс ашигт малтмалын арвин нөөцтэй. Энэ нөөцөө ашиглан хөгжихөд үндэсний болон орон нутгийн оролцогч талуудыг чадавхижуулах, тогтвортой хөгжлийг бий болгох, газар доорх баялаг бүх ард иргэдэд хүртээлтэй байх боломжийг бий болгох үндсэн зорилгын дор бид үйл ажиллагаагаа явуулж байна. ■

# 2015.05.26-27

Сэлэнгэ аймаг. Сүхбаатар хот

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын баг Сэлэнгэ аймагт “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн ХОЙД БҮСИЙН СУРГАЛТЫГ амжилттай зохион байгууллаа.

May 26-27, 2015

The northern regional training under the Local News Network project was held in Selenge province in cooperation with The Mongolian Mining Journal.

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **ХОЙД БҮСИЙН СУРГАЛТ** 2015 ОН

Уул уурхай, эдийн засгийн мэдээллийг мэргэжлийн түвшинд бэлтгэдэг сэтгүүлчдийг улам олон болгох зорилгоо тэлсээр 2015 онд “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” байгуулсан билээ.

Орон нутгийн иргэдэд уул уурхайн мөн чанарыг ойлгуулах, бодит мэдээллээр хангахын тулд орон нутгийн редакци, сэтгүүлчдийг мэргэжлийн арга зүйгээр дэмжих гэсэн бидний тэмүүллийг Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөр дэмжсэнээр 2015 оны тавдугаар сард төсөл эхэлсэн юм.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан тус сургалтад Орхон, Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул аймгийн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 20 сэтгүүлч хамрагдав.

Сургалтын нээлтийн үйл ажиллагаанд **Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа** оролцож хэлсэн үгэндээ *"Орон нутгийн мэдээллийн сүлжээ төслийн Хойд бүсийн сэтгүүлчдийн сургалтыг манай аймагт зохион байгуулж байгаа нь ихээхэн онцлог үйл явдал болж байна. Энэхүү сүлжээг бий болгох нь цаг үеэ олсон сайхан арга хэмжээ юм"* хэмээн тодотголоо.

**Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэд захирал О.Батболд** "Орон нутгийн мэдээллийн сүлжээ" байгуулах ажлыг яагаад дэмжиж оролцох болсноо танилцуулсан юм.

*"Мэдээллийн сүлжээ байгуулах ажил нэг удаагийнх биш. Орон нутгийн сэтгүүлчдийн харилцаа холбоог бий болгох, тогтмолжуулах, нийтлэл, нэвтрүүлгийн уралдаан зохион байгуулах гээд олон ажлыг зохион байгуулна. Зургадугаар сарын сүүлээр Баруун бүсийн долоон аймгийн сэтгүүлчдийг хамруулсан сургалтыг Баянхонгор аймагт зохион байгуулна. Энэ бүхний эцэст 15 аймгийн сэтгүүлчдийн Мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болох юм"* хэмээн тэрбээр ярилаа.

**Хойд бүсийн сэтгүүлчдийн сургалтын багийн ахлагч Г.Идэрхангай** "Орон нутгийн мэдээллийн сүлжээ" байгуулахын ач холбогдол, зорилгыг орон нутгийн сэтгүүлчдэд танилцуулаад "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ-ын хийж, хэрэгжүүлж ирсэн ажлуудын талаар мэдээлэл хийлээ.

Мэдээллийн сүлжээг байгуулснаар орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан нутгийн иргэдийн мэдлэг, ойлголт, идэвх оролцоог дээшлүүлэх, олон талт мэдээллээр хангах давхар ач холбогдолтой гэдгийг тэрбээр мөн онцолсон юм.

Сургалтын хөтөлбөрийн дагуу **"Хойд бүст үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн үйлдвэрлэлийн бүтэц, онцлог"** сэдэвт сургалтыг Г.Идэрхангай хөтлөн явуулав.

Түүний сургалтын гол агуулга Хойд бүсийн төмөрлөгийн үйлдвэрүүд, өнөөгийн нөхцөл байдал, дэд бүтэц, экспортод тулгарч буй бэрхшээл, зах зээлийн төлөв хандлага, уул уурхайн үйлдвэрлэлийн сурвалжлага бэлтгэхэд анхаарах зүйлс, арга зүйн зөвлөгөө гэсэн сэдэвт төвлөрсөн юм. Сургалтын үдээс хойших хэсэг **"Хойд ба төвийн бүст үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлага, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа"** хэлэлцүүлэг сэдвийн хүрээнд өрнөсөн юм.

Орон нутгийн сэтгүүлчдэд илүү тодорхой мэдээлэл хүргэх үүднээс Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн Эрдэс баялаг, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхбатыг хэлэлцүүлэгт урьж оролцууллаа. Тэрбээр Сэлэнгэ аймаг бусад аймгаас анх удаа Эрдэс баялгийн талаар баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлж байгаагаа дуулгасан нь сонирхол татав.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Б.Мөнхбат

Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэд захирал О.Батболд **"Компанийн нийгмийн хариуцлага: Ойлголт, стандарт, тайлагнал"** сэдвээр илтгэлээ.

Түүний илтгэлтэй холбоотойгоор сургалт-семинарын агуулгад нийцүүлэн сэтгүүлч Г.Идэрхангай **“Тогтвортой хөгжлийг сурвалжлах нь”** гэсэн сэдвийг хөндөж ярилаа.

Ойрын хэдэн арван жилдээ Монгол улсын нийгэм, эдийн засаг уул уурхайн тогтвортой хөгжлөөс хамааралтай байна гэдгийг тэрбээр онцлоод “Тогтвортой хөгжлийн тулгын гурван чулуу бол Эдийн засаг, Нийгэм, Байгаль орчин. Уул уурхайн салбарыг энэ гурваас салгаж ойлгох аргагүй. Тиймээс орон нутгийн сэтгүүлчид Хариуцлагатай уул уурхайн 8 зарчмын Олон талын оролцоог хангаж ажиллах тал дээр идэвхтэй ажиллах ёстой” сануулсан юм.

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” сургалтын үдээс хойш хэсгийн нэгэн сонирхолтой илтгэл нь сэтгүүлч Э.Оджаргал **“Алтны салбар: өнөөгийн байдал**” сэдэвт танилцуулга байв.

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн сургалтын хоёр дахь өдрийн үдээс өмнөх хэлэлцүүлэг С.Болд-Эрдэнэ сэтгүүлчийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан” сэдвээр үргэлжиллээ. Тэрбээр “Уул уурхай танай аймаг, суманд юу өгсөн бэ” гэсэн асуултаар илтгэлээ эхлэв.

Сургалтын төгсгөлд “Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийг цаашид хэрхэн өргөтгөх, орон нутгийн сэтгүүлчдийн зүгээс ямар үүрэг оролцоотой байх вэ зэрэг олон асуудлаар орон нутгийн сэтгүүлчид харилцан санал солилцож, “Хөгжлийн төлөө сэтгүүлзүй” төрийн бус байгууллагаас зохион байгуулах арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцохоо илэрхийлэв. ■

*Орон нутгийн сэтгүүлчид уул уурхайг сурвалжлах явцад өөрт нь түгээмэл тохиолддог бэрхшээл, туршлагынхаа талаар харилцан нээлттэй санал солилцлоо.*

**Сэлэнгэ аймгийн “Миний Монгол“ телевизийн сэтгүүлч Д.Туул:**

Сэлэнгэ аймагт уул уурхайн салбарын томоохон компаниуд үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс уул уурхайн чиглэлээр сэтгүүлчдэд зориулсан сургалт манай аймагт анх удаа зохион байгуулагдаж байгаа нь талархууштай ажил болж байна.

**Дархан-Уул аймгийн “Найрамдлын Дархан” сонины сэтгүүлч А.Батзаяа:**

Уул уурхайн компаниуд Дархан-Уул аймагтаа хэр үр өгөөжтэй, нийгмийн хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлдэг болон нөхөн сэргээлт хэрхэн хийдэг талаар сэтгүүлч бид нар өөрсдөө сайн сурвалжилж мэдэж байж орон нутгийн ард иргэддээ энэ талаар үнэн бодит мэдээллийг хүргэснээр уул уурхай жинхэнэ утгаараа хөгжих юм байна.

**Төв аймгийн TBS телевизийн сэтгүүлч, редактор Ж.Хонгорбаатар:**

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” сургалт маань оролцогч сэтгүүлчидтэйгээ уялдаа, харилцаа холбоотой, хамтран ажиллах, нэг зорилгын төлөө зүтгэх гэсэн маш олон зорилго, зорилтоороо бусад сургалтуудаас ялгаатай, басхүү давуу талтай боллоо.

**Дархан-Уул аймгийн “Шинэ мэдээ” сонины эрхлэгч Г.Нарантуяа:**

Сэтгүүлчид өөрсдөө орон нутгийн мэргэжил нэг сэтгүүлчидтэй уулзаж туршлага, чадвараасаа хуваалцаж байгаа нь энэхүү сургалтын гол ач холбогдол оршиж байгаа болов уу.

Сэлэнгэ аймаг.  Сайханы хөндий

# 2015.06.25

Баянхонгор аймаг. Шаргалжуутын гол. “Өгөөж Булган” жуулчны бааз

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын баг Баянхонгор аймагт “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн БАРУУН БҮСИЙН СУРГАЛТЫГ амжилттай зохион байгууллаа.

June 25,2015

The western regional training under the Local News Network project was held in Bayankhongor province in cooperation with The Mongolian Mining Journal.

## “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **БАРУУН БҮСИЙН СУРГАЛТ** 2015 ОН

Алс Баян-Өлгий, Ховдын цэнхэр хязгаар, өмнийн шаргал Говь-Алтай, өврийн сайхан Өвөрхангай, говь хангай хосолсон Баянхонгор 5 аймгаас 27 сэтгүүлч зорин иржээ.

Сургалтын арын албаны нүсэр ажлыг менежер Г.Энхсайхан амжуулж, зураглаач М.Энх-Амгалан сэтгүүлчдийн мэдлэг туршлага солилцох үйл явцыг зураг, дүрсэнд хадгалан авч үлдэв.

Сургалтын цагт ОҮИТБС-ын тайланг хэрхэн зөв “унших”, яаж ойлгомжтой мэдээлэх, Сэлэнгэ, Баянхонгор аймгийн тайланг энгийн болгож мэдээлсэн туршлага, Баруун бүсэд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн үйлдвэрлэлийн онцлог, өнөөгийн нөхцөл, зах зээлийн төлөв, дэд бүтцийн асуудал, уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлага, түүний өгөөж, нөхөн сэргээлт, улс, орон нутгийн төсөвт өгч буй татварын хэмжээ, иргэд ба компанийн ойлголцол, Баруун бүсийн алтны салбарын онцлог, өнөөгийн нөхцөл байдал, зах зээлийн хандлага, төлөв, технологи, хэрэглээний талаарх мэдээлэл, Бичил уурхай тойрсон асуудлууд зэрэг өргөн хүрээтэй сэдвээр ММЈ-ийн сэтгүүлч Н.Ариунтуяа, Г.Идэрхангай, Э.Оджаргал, Б.Төгсбилэгт нар илтгэсэн. Мөн Хөгжлийн сэтгүүл зүйн хандлагыг сонирхуулж, уул уурхайг сурвалжлах ММЈ-ийн арга зүй, туршлагаас хуваалцан анхаарах зүйлс, арга зүйн зөвлөгөөг ч багтаахыг хичээсэн юм.

“Баруун бүсийн орон нутгийн мэдээллийн сүлжээ” сургалтын нээлтэд Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Жаргалсайхан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч Б.Төмөрбаатар нар оролцсон юм. Тэд аймаг, орон нутагт хийгдэж буй гол ажлууд, цаашдын зорилго чиглэл, уул уурхайн салбарын өнөөгийн байдлын талаар сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулсан билээ.

*Сэдэв бүрийн дараах хэлэлцүүлгээр орон нутгийн сэтгүүлчид орон нутаг дахь уул уурхайн салбарын бодит байдал, иргэд олон нийтийн ойлголт, хандлага хийгээд, уул уурхайг газар дээр нь сурвалжлах явцад тохиолддог асуудал бэрхшээлээ харилцан ярилцсан юм.*

**Баян-Өлгий аймаг дахь Олон нийтийн радио телевизийн сэтгүүлч Н.Совет:**
Лицензийн хаалттай мэдээллүүд ОҮИТБС-ын тайлангаар нээлттэй болно гэдэг их чухал хэрэгтэй мэдээлэл юм. Учир нь орон нутагт өнөөдрийн байдлаар уул уурхайтай холбоотой тодорхой мэдээлэл байхгүй байна. Үнэн бодит мэдээллийг хаанаас, хэнээс авахаа ч сайн мэддэггүй.



**Өвөрхангай аймгийн “Хас” телевизийн сэтгүүлч Д.Алтанчимэг:**
Бат-Өлзий сумын иргэдийн хувьд гэрийн модны үйлдвэрлэл дээр амьдрал ахуй нь тогтдог. Гэрийн модны үнэ ханш нэмэгдээд, иргэдийн мод огтлохыг хуулиар хориглоод ирэхээр амьжиргааны эх үүсвэргүй болсон иргэд нинжа болж, цагдаад ч хүчрэгдэхээ болиод байгаа.

**“Ховдын толь” сонин, Ховд аймгийн Олон ястны телевизийн сэтгүүлч Ж.Саруул:**
“МоЭнКо” компани Хөшөөтийн уурхайг хагас дутуу зэрэмдэглэж хаяад одоо дахиад Олон булагийн уурхайг ашиглах асуудал яригдаж байна. Орон нутгийн хэвлэл мэдээллийнхэн аймаг, орон нутгийн удирдлагуудад хандаж, энэ асуудлыг тодруулах гэхэд компанийг хайцаалаад тэр үү мэдээлэл өгдөггүй. Татварын байгууллага ч мэдээлэл өгөхөөс цааргалдаг. Ер нь орон нутагт мэдээлэл их хаалттай байдаг.

**Ховд аймгийн “Жаргалант” телевизийн сэтгүүлч С.Жавзандулам:**
Ховдчуудын хувьд Хөшөөтийн уурхайн асуудал олон жил бүрхэг, мэдээлэл муутай явсаар ирсэн. Аймаг, орон нутгийн удирдлагууд уурхайн удирдлагуудтай гэрээ хэлэлцээр байгуулж, тэр талаар орон нутгийн хэвлэл мэдээллийнхнийг дуудаж мэдээлэл өгсөн. Гэвч дараа дараагийн удаад мэдээлэл авах гэхээр нэг нэг рүүгээ “чихээд” тодорхой юм хэлдэггүй.

**Говь-Алтай аймгийн “Алтай” радиогийн сэтгүүлч Г.Мөнгөнчимэг:**
Манай аймагт “Алтайн хүдэр” компани Таяннуурын уурхайд үйл ажиллагаа явуулдаг. Энэ уурхай 1000 гаруй ажилчинтай. Нийт ажилчдын 70% нь орон нутгийн иргэдээс бүрддэг. Уурхайн нэг дутагдал нь ажилчдынхаа эрүүл мэндэд огт анхаардаггүй.

Баянхонгор аймаг. ШАРГАЛЖУУТЫН ГОЛ

Хонгор нутгийн мэргэжил нэгт андууд маань сургалтын дараа газар нутгаа танилцуулж, алдарт Шаргалжуутын рашааныг нүдээр үзэж, байгалийн сайханд нүд, сэтгэлээ баясгах завшааныг сэтгүүлчдэд олгосонд талархъя.

## ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ БА ЗАВГҮЙ СЭТГҮҮЛЧ

“Намайг Янжмаа гэдэг. “Баянхонгор таймс” сонинд ажилладаг. Сэтгүүлч, редактор, эх бэлтгэгч, менежерийн ажилтай”. Сургалтын эхэнд сэтгүүлчид өөрсдийгөө танилцуулах үеэр шавилхан биетэй сэргэлэн бүсгүй ийн танилцуулав.

Төвийн сонинд магадгүй таваас зургаан хүний хийх ажлыг ганц сурвалжлагч нуруундаа үүрэх нь орон нутгийн онцлог. Цаашлаад байгууллагаа удирдах, санхүүгээ хариуцах гээд хэчнээн ч ажил, үүрэг нэмэгдэж мэднэ.

“Орлоод ажиллах хүнгүй болохоор амарч үзээгүй явна. Орон нутгийн сэтгүүлч хүсэл сонирхолдоо автаж ажилласаар ар гэрийнхээ амьдралыг хаячихдаг. Би гэхэд эмэгтэй хүн мөртлөө дэлгүүрээр орж, нэг удаа хүнсний зүйлээ цуглуулж үзээгүй. Баяр ёслолоор гэртээ байж үзсэнгүй” хэмээн 2012 онд Хэнтий аймгийн “Санбүрд” телевизийн сурвалжлагч Б.Батцэцэг ярьж билээ. Гэвч гурван жилийн дараа орон нутагт хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо нэмэгдсэн ч сэтгүүлчийн ажил үүрэгт өөрчлөлт орсонгүй.

Түүн шиг орон нутгийн телевизийн сэтгүүлч камераа үүрэн мэдээнд явж, ирээд эвлүүлэгч, найруулагч болж, үзэгчдэд хүргэхдээ нэвтрүүлэгч, хөтлөгчийн дүрд хувирна. Хүн хүч, хөрөнгө санхүүгийн боломжоос шалтгаалан сэтгүүлч тал бүрийн чадвар эзэмшиж, олон давхар ажил үүрэг гүйцэтгэх болдог.

Орон нутгийн сэтгүүлч дандаа завгүй. Сургалтад оролцох сэтгүүлчдээ бүртгэхдээ манай багийнхан үүнийг нэвт ойлгосон билээ. Сарын өмнө хойд бүсэд сургалт зохион байгуулсан туршлага бидэнд бий. Гэвч Эрдэнэт, Дархан хот, Сэлэнгэ, Төв аймгийн хэвлэл мэдээллийнхэн харьцангуй хүн хүчний боломжоотой аж. Наадмын натур, шууд дамжуулах үйл ажиллагаанд хүч хүрэлцэхгүйн улмаас Завхан, Увс аймгийн сэтгүүлчид Баруун бүсийн сургалтад ирж чадаагүй.

Баруун бүсийн мэдээллийн орон зайд ажиллаж буй сэтгүүлчдэдээ шинэ мэдлэг, мэдээлэл дуулгахын ялдамд Баянхонгор аймаг дахь хэвлэлийн редакциудтай танилцаж, онцлогийг мэдэрсэн нь бидэнд сайн туршлага болсон. Орон нутгийнхан мэргэжлийн сургалтад хамрагдах, туршлага солилцох сонирхол ихтэй. Гэвч мөнөөх л хүн хүчний боломж нөхцөлөөс эхлээд зардал мөнгөний асуудал, хол замд зарцуулах цаг хугацаа гээд багагүй бэрхшээл тосно. 1100 км-ийн тэртээх Баян-Өлгийгөөс Н.Совет, У.Хуат, О.Жанерке нар хоёр өдөр, хоёр шөнийг замд туулан сургалтыг зорьж ирсэн.

Баянхонгор аймгийн хэмжээнд 3 телевиз, 2 сонин, 2 сэтгүүл, нийтдээ 7 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулдаг. Сургалтын дараа бид дөрвийнх нь үйл ажиллагаатай танилцсан. Хотоос очсон бидэнд орон нутгийн телевиз, хэвлэлийн редакцийн дүр төрх ямар онцлогтой байх нь сонирхолтой байсан бол орон нутгаас ирсэн сэтгүүлчдэд хөтөлбөр, үнэ тарифаас эхлээд техник хэрэгсэл гээд харьцуулж харах, санаа оноо авах зүйл цөөнгүй. ■

# 2015.11.10

Улаанбаатар хот. Blue Sky Tower

Mongolian Mining Journal-ийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ сэтгүүлчдийг чадавхижуулах сургалтын хүрээг тэлж, “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслөөр өргөтгөснийхөө НЭГДСЭН УУЛЗАЛТЫГ зохион байгуулж буй нь энэ.

November 10, 2015

A combined meeting of participants of all the areas covered by the Local News Network project was held in cooperation with The Mongolian Mining Journal.

Mining Journal

германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Хэрэгжүүлэгч: giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

## “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **НЭГДСЭН УУЛЗАЛТ** 2015 ОН

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн Нэгдсэн уулзалтад Хойд, Өмнөд, Баруун бүсийн сэтгүүлчид идэвхтэй оролцсон юм.

Сургалтад оролцсон нийт сэтгүүлчдийн дунд уралдаан зарлах, нийслэл хотноо нэгдсэн уулзалт хийх, гадаадын уул уурхайн сургуулиудын мэргэжлийн профессоруудыг урьж хичээл заалгах, танилцах аялал зохион байгуулах зэргээр уг төслөө далайцтай болгон өргөжүүлэх шаардлага гарсан юм.

# “ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦЛЭЭ

2015 оны арваннэгдүгээр сарын 10. Чингисийн талбайн чанх өмнөх “Блю Скай”-гийн Даймонд танхим энэ өглөө Хойд, Өмнөд, Баруун бүсийн сэтгүүлчдийн уулзалтаар “амьсгалж, шинэ содон яриа хөөрөөнд умбалаа. Сэтгүүлчдийн бүртгэл... Өглөөний кофе... Богинохон ч энэ зайд тэд өөр хоорондоо танилцан, мэнд усаа солилцож, өнгөрсөн зун, намар амжуулсан их ажлынхаа сониноос хуваалцаж амжив.

Бүсийн хэмжээний мэдээллийн сүлжээг байгуулах төсөл хоёр үе шаттай явагдсан ба Хойд бүсийн таван аймаг, Баруун бүсийн долоон аймгийн нийт 47 сэтгүүлч сургалтад хамрагдсан юм.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй аймгийн сэтгүүлчдэд эрдэс баялгийн салбарын тухай танин мэдэхүйн ойлголт өгч, сурвалжлага, нийтлэл бэлтгэх явцад гардаг хүндрэл бэрхшээлүүдийн талаар харилцан санал солилцох, туршлагаа хуваалцахад сургалтын зорилго чиглэж байлаа. Мөн сургалтын дараа оролцогч сэтгүүлчдийн дунд сэтгүүл зүйн шилдэг бүтээлийн уралдаан зарлаж, мэргэжлийн Комисс шалгаруулалтыг хийсэн.

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн Нэгдсэн уулзалтыг Mongolian Mining Journal сэтгүүлийн Эрхлэгч Л.Болормаа нээж үг хэллээ. *“Сэтгүүлчдийг мэргэшүүлэх, ялангуяа орон нутагт ажиллаж байгаа хэвлэл мэдээллийнхэнд бодит мэдээлэл, танин мэдэхүйн ойлголт өгөх, нийслэл хотод байгаа гол эх сурвалжуудтай тэдний холбох зорилгоор “Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийг эхлүүлсэн”*-ийг тэрээр дурдаад, төслийн ач холбогдол, үр дүнг танилцуулав.

Орон нутгийн сэтгүүлчдийн хувьд нийслэл хотод байгаа эх сурвалжуудаас бодит мэдээлэл авах боломж хомс байдаг. Харин Нэгдсэн уулзалтын үеэр тэднийг уул уурхайн салбарын гол төлөөллүүдтэй холбож, ярилцлага, мэдээлэл авах бололцоог MMJ сэтгүүлийн зүгээс олгосон юм.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хуваарилалтын талаар Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүү, Хайгуулын тусгай зөвшөөрөл олголттой холбоотой асуудлаар Геологийн бодлогын хэлтсийн дарга Б.Баатарцогт, Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатар нар цаг үеийн мэдээлэл хийж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариуллаа.

“Мега төсөл” сэдвээр өмнө нь MMJ сэтгүүлийн зохион байгуулсан “Монголын эрдэс баялгийн салбарын шинэ үеийн 20 жил” хэлэлцүүлэгт сонирхолтой илтгэл тавьж байсан Монгол улсын Сайд М.Энхсайхан энэ удаад “Мэдээлэл бүхий иргэд ба Уул уурхайн засаглал” лекц уншив.

Манайх шиг гадаад өр ихтэй орнуудад Тасын сан орж ирэх эрсдэл өндөр байдаг ба улс орнуудын өрийг худалдаж авдаг тусгай сангуудыг ингэж нэрлэдэг ажээ. Тэр утгаар нь дэлхийд ийм нэршил гарсан байна. Тасын сангуудыг оруулж ирэхгүйн тулд мөнгө олж өрөө төлөх боломжтой цорын ганц салбарынхаа засаглалыг сайжруулах хэрэгтэй гэсэн санааг М.Энхсайхан сайд хэлсэн юм. Засаглал сайжруулах олон аргын нэг нь иргэд, шийдвэр гаргагчдыг зөв мэдээллээр хангах бөгөөд энэ утгаараа сэтгүүлчид уул уурхайн засаглалд гол үүрэгтэй аж.

Нэгдсэн уулзалтын үдээс өмнөх хэлэлцүүлэг “Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төсөл хэрэгжсэн байдлын талаар өрнөв. МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн дэд профессор, доктор Л.Наранбаатар нийтлэл, нэвтрүүлгийн уралдаанд ирүүлсэн орон нутгийн сэтгүүлчдийн бүтээлийг сэтгүүлзүйн онол, арга зүй талаас нь дүгнэснийг танилцуулав.

Уул уурхайн бүтээн байгуулалт, олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай шууд харилцах, сурвалжлах, ажиглах замаар шинэлэг, ач холбогдол бүхий сэдвүүдийг сэтгүүлчид хөнджээ. Туршлагатай, орон нутагтаа хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлчид бүтээлээ ирүүлсэн тул мэдээллийн бодит байдал, хөндөж буй сэдвийн хүрээний мэдлэгт эргэлзэх шаардлага гарсангүй хэмээн доктор Л.Наранбаатар тодотгов.

Тэрээр мөн өнөөгийн орон нутгийн сэтгүүлчдэд тулгарч байгаа цаг зав, санхүүжилт, Орон нутгийн засаг захиргааны шахалт, хамаарал, редакцийн дэмжлэг дутмаг гэх мэт бэрхшээлүүдийг ойлгож байна. Гэхдээ зөвхөн сэтгүүлчийн жаахан санаачилга, хичээл зүтгэлээр шийдвэрлэж болох, сайжруулж, чанаржуулж болох олон дутагдал байгааг дурдах ёстой гэлээ.

Л.Наранбаатар докторын дүгнэлтийн дараа Mongolian Mining Journal-ийн Орлогч эрхлэгч Н.Ариунтуяа уралдаанд ирсэн орон нутгийн сэтгүүлчдийн нийтлэлүүдэд, “Хөгжил” ТВ студийн сэтгүүлч С.Болд-Эрдэнэ телевизийн нэвтрүүлгүүдийн ололт, дутагдал, анхаарах зүйлсийн талаар сэтгүүл зүйн арга зүй, ур чадварын зөвлөгөө өгсөн юм.

Нэгдсэн уулзалтын үдээс хойшхи хэлэлцүүлэг МУИС-ийн Сэтгүүлзүйн тэнхимийн дэд профессор, доктор Л.Наранбаатарын **“Орчин үеийн сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага: Шинэ сорилт ба шийдэл”** илтгэлээр үргэлжилсэн юм.

“Сэтгүүл зүй мэдээллийн орон зай дахь бие даасан шинж чанараа алдаж, олон нийтийн мэдээллийн харилцааны хэлбэр, салбар болон хувьсаж байна. Медиа зах зээл эрс өөрчлөгдөж бизнес, хөрөнгө оруулалтын салбар, медиа эдийн засаг, медиа улс төр, медиа маркетинг зэрэг ойлголтууд хүч түрэх болов” гэж тэрээр орчин үеийн сэтгүүл зүйн мөн чанарыг тодотгон ярилаа.

Б.Дэлгэрмаа

О.Батболд

Г.Мөнхжин

Медиа зах зээлд цэвэр сэтгүүл зүйн бүтээл шахагджээ. Ялангуяа зорилтот инфотайнмент давамгайлах болж, глобаль мэдээллийн эх сурвалжуудын давамгайллын үр дүнд мэдээлэл, шуурхай, нөлөөлөл нь хурдан, ач холбогдлын дэс дараалал нь даяаршсан шинжтэй болж байгаа аж. Энэ бүхнээс гарах шийдэл нь сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакциуд дээрх зүйлсийг тооцон мэргэжлийн сэтгүүл зүйн орон зайг сэргээх, баталгаажуулах шаардлагатай болжээ.

Түүний илтгэлийн "Боломжит гарц" гэсэн хэсэгт "Хөгжлийн сэтгүүл зүй" гэсэн ойлголт онцгойлон дурдагдсан нь сонирхол татсан юм. 1960-аад оны дунд үеэс Филиппин улсад үндэс суурь тавьсан хөгжлийн сэтгүүл зүй гэх ойлголт Зүүн Өмнөд Ази, Төв Африк, Латин Америкийн орнуудад дэлгэрсэн сэтгүүлзүйн чиг баримжаа аж. Хэдийгээр аливаа улс орны болон салбарын хөгжлийн асуудал хэвлэл мэдээллийн хэрэгслийн байнгын сэдэв, нийтлэлийн бодлого байдаг боловч Development journalism хэмээн томьёолсон энэхүү ойлголтын хүрээнд өөрийн гэсэн өвөрмөц зарчим, чиг шугам бий болжээ.

Нэгдсэн уулзалтад "Бороо гоулд" ХХК-ийн Байгаль орчны инженер Г.Мөнхжин "Бороогийн уурхай нөхөн сэргээлт" сэдвээр, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын /ОҮИТБС/ Ажлын албаны менежер Б.Дэлгэрмаа "Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-ын явц, хэрэгжилтийн талаар танилцуулга хийсэн юм.

Мөн "Орон нутгийн мэдээллийн сүлжээ" төслийн үйл ажиллагааг эхнээс нь дэмжин хамтарч оролцсон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн Дэд захирал О.Батболд "Орон нутгийн цогц хөгжил-Түншлэл" сэдвээр сэтгүүлчдэд тодорхой ойлголт өглөө. ▪

# УРАЛДААНЫ ДҮН ГАРАВ

Нэгдсэн уулзалтын үдээс хойшхи арга хэмжээ “Блю Скай”-гийн “Даймонд” танхимд Шилдэг нийтлэл, нэвтрүүлгийн шагнал гардуулах Ёслолоор үргэлжиллээ. Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) -ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн Дэд захирал О.Батболд Тэргүүн байрын шагналын эзнийг тодруулах хүндтэй үүргийг хүлээж, дугтуйг задлав.

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас орон нутгийн сэтгүүлчдийн дунд зарласан Шилдэг, нийтлэл, нэвтрүүлгийн уралдааны шалгаруулалтын дүнгээр “Ховдын толь” сонин, “Олон ястны телевиз”-ийн сэтгүүлч Ж.Саруулын “Хөшөөтийн асуудлыг хөдөө тийш залсан хөшүүн гэрээний хэрэгжилт” асуудал дэвшүүлсэн нийтлэл, “Нөхөн сэргээлтийг олборлолт хийх замаар зардлыг нь гаргуулж хийлгэх нь хэр үр дүнтэй вэ” нэвтрүүлгүүд шалгарч, Тэргүүн байр хүртлээ.

Мөн шалгаруулалтад идэвхтэй оролцож, бүтээлээ ирүүлсэн “Өнөөгийн Баянхонгор” сонины эрхлэгч П.Санаадагва, “Сэлэнгийн мэдээ” сонины эрхлэгч Н.Оюунмаа, Мандал сумын “Мандал ТВ”-ийн сэтгүүлч Ц.Ундармаа, Орхон аймгийн Эрдэнэт хотын www.erdenet-times.mn сайтын сэтгүүлч Л.Ганцолмон, Орхон аймгийн УЭС телевизийн сэтгүүлч Б.Гантуяа, Төв аймгийн TBS телевизийн сэтгүүлч Ж.Хонгорбаатар, Ц.Ууганбаатар нарт “Mongolian Mining Journal”-ийн Ерөнхий эрхлэгч Л.Болормаа сэтгүүлийн багийн зүгээс талархаж буйгаа илэрхийлэн бүтээл бүрт урамшуулал хүртээсэн юм.

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн Хойд, Баруун бүсийн сургалтыг идэвхтэй дэмжиж ажилласан Редакци болон сэтгүүлчээр “Өнөөгийн Баянхонгор” сонины эрхлэгч П.Санаадагва, Сэлэнгэ аймгийн “Миний Монгол” телевиз, радиогийн сэтгүүлч Д.Туул нарыг тодруулж шагнасан юм.

Уралдааны шүүгчдийн бүрэлдэхүүнд “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Болормаа, GIZ-ын Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэд захирал О.Батболд, МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимын доктор, дэд профессор Б.Наранбаатар, The Mongolian Mining Journal сэтгүүл хариуцсан орлогч эрхлэгч Н.Ариунтуяа болон сургалтын багш, сэтгүүлч Г.Идэрхангай, С.Болд-Эрдэнэ нар багтсан юм.

The Mongolian Mining Journal-ийн дэргэдэх Хөгжлийн төлөө сэтгүүл зүй ТББ орон нутгийн сэтгүүлчдэд 2010 оноос сургалт зохион байгуулсан. Энэ жилээс орон нутгийн сургалтаа бүсчлэн зохион байгуулав. Илүү олон сэтгүүлчийг хамрах, улмаар шатлан өргөжүүлэх, цуврал сургалтуудын дүнд уул уурхайн анхан шатны ойлголттой бичдэг, нэвтрүүлэг бэлтгэдэг мэргэшсэн сэтгүүлчдийн төлөөллийг орон нутагт төлөвшүүлэх нь чухал байгаа билээ.

Төрийн бодлогын зөв шинэчлэл орон нутгийн удирдлагын тасалгаанд хүрээд хаалттай хаалганы цаана орчихож байгаа энэ явдал улам даамжирвал уул уурхайн үйлдвэрлэлээсээ ашиг тус хүртэнэ гэсэн нутгийн иргэдийн хүлээлт талаар болно. Хөрөнгө хүчээ зарцуулсан компаниудын бүтээн байгуулалт ч үнэгүйдэх юм.

Эрдэс баялгийн шийдвэр гаргалтад гол үүрэгтэй оролцох учиртай орон нутгийн иргэдэд мэдээллийг нээлттэй, бодитой хүргэх ажлыг гардан хийж яваа сэтгүүлчдэд анхан шатны ойлголт өгөх, улам бүр мэргэшүүлэх явдал туйлаас чухал болов. Засгийн газрын шийдвэр-Орон нутгийн удирдлагын ажил-Уул уурхайн компанийн үйл ажиллагаа-Иргэдийн хүсэл сонирхлыг холбогч Сэтгүүлчийн үүрэг улам бүр нэмэгдсэн гэсэн үг.

The Mongolian Mining Journal-ийн зохион байгуулж буй “Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн гол зорилго үүнд чиглэж байна. ▪

# 2016.04.02

Улаанбаатар хот. Хууль зүйн хүрээлэнгийн “Хуульчид” танхим

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга /ЭТИС/ хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийг хоёр дахь жилдээ үргэлжлүүлэн зохион байгууллаа.

April 2, 2016

Journalism for Development NGO begins work for the second year of the Local News Network project with support from the GIZ IMRI *(GIZ Integrated Mineral Resources Initiative).*

Mining Journal · германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT · Хэрэгжүүлэгч: giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **НЭГДСЭН СУРГАЛТ** 2016 ОН

Амжилттай хэрэгжсэн төслийг үргэлжлүүлэх, орон нутгийн сэтгүүлчдийн эргэх холбоо, ур чадварыг дахин шат ахиулах зорилгоор 2016 оны “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл ажлаа эрчтэйгээр эхэллээ. Энэ удаад ЭТИС хөтөлбөр Германы туршлагатай, нэр хүндтэй сэтгүүлчийг урьсан юм. 2016 оны сургалтад өмнөх сургалтад хамрагдсан орон нутгийн хэвлэлийнхнээс 35 сэтгүүлч шигшигдэн оролцов.

Орон нутгийн мэдээллийн сүлжээг ганц төслөөр, цөөн удаагийн сургалтаар хязгаарлахгүйг анхнаасаа зорьсон юм. Сургалтын бодит үр дүн, далайцыг үнэлсэн GIZ-ийн дэмжлэгээр “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл агуулгаа улам баяжуулан, шинэ оны сургалтдаа сэтгүүлчдээ урилаа. Энэ удаа сэтгүүлзүйн илүү олон жилийн туршлагатай орны туршлагатай мэргэжилтнээс сонсох, суралцах боломж нээгдэв. Германы сэтгүүл зүйн салбарт цөөнгүй жилийн хөдөлмөрөө зориулахдаа уул уурхай, байгаль орчны чиглэлээр дагнан бичсэн туршлагатай сэтгүүлч Асендорпфийг GIZ урьж авчирсан юм.

Өмнөх жилийн сургалтаас гарсан саналыг үндэслэн орон нутгийн сэтгүүлчдийг уул уурхайн үйлдвэрлэлтэй танилцуулах, практик мэдлэг мэдээлэл олгоход энэ удаагийн сургалт чиглэж байгааг О.Батболд захирал нээлтийн үгэндээ тодотгов.

Сэтгүүлчдийг мэргэшүүлэх, ур чадварыг ахиулах сургалт жилийн турш үргэлжлэх бөгөөд наймдугаар сард Өвөрхангай аймагт, арваннэгдүгээр сард Улаанбаатар хотноо зохиогдоно. Сургалтыг Германы сэтгүүлзүйн салбарын туршлагатай мэргэжилтнүүд хөтлөн явуулах бөгөөд сэтгүүл зүйн шинэ орчинд хамгийн сонирхолтой байх сэдвүүд сонгогдож байгаа. Сургалт бүрийн дараа сэтгүүлчдэд сертификат олгох юм.

Манай багийн зорьж тэмүүлсэн сургалт илүү ахьсан түвшинд хүрч, сурвалжлагч ямагт суралцах ёстой гэсэн Болороо эрхлэгчийн мөрөөдөл бодит ажил хэрэг болон урагшилж буйд редакцийн хамт олон баяртай байна. Бас энэ тэмүүллийг минь бүтээлч үйл хэрэг болоход хамгийн том тусламжаа үзүүлж, эхнээс нь дэмжсэн GIZ-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн хамт олон, Захирал Др.Штефан Хансельманн, Дэд захирал О.Батболд нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

“Та нар яагаад юм асуухгүй байна. Мэдэхийг хүсч байгаа зүйлээ асуулгүй өнгөрөх нь алдаа болдог шүү” хэмээн хэлээд Асендорпф багш хөнгөхөн инээмсэглэн, сэтгүүлчид рүү нүд гүйлгэн харав. Орон нутгийн сэтгүүлчидтэй эхнээсээ энгийн чөлөөтэй харилцаж, сургалтаа аль болох асуулт хариултын хэлбэрээр явуулахыг тэрээр хүсчээ. Ихэнх сургалт “уйтгартай” урт илтгэл, танилцуулга бүхий хэв загвараар үргэлжилдэг бол Асендорпф багшийн хичээл чөлөөт уур амьсгал дунд сонирхолтойгоор өрнөсөн.

Өдгөө Дойчэ Вэллэ академи болон Брэмений хэрэглээний Шинжлэх ухааны Их сургуульд сургагч багшаар ажиллаж байгаа юм. Жилдээ сэтгүүл зүйн хэд хэдэн сургалт зохион байгуулдаг бөгөөд Монголд анхны сургалтаа хийж буй нь энэ. Орон нутгийн сэтгүүлчдээс гадна нийслэлийн томоохон хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид ч түүний сургалтад хамрагдаж Германы сэтгүүл зүйн онцлог, чиг хандлагатай танилцсан.

Өнөөдөр Монголын байгаль орчинд тулгараад байгаа асуудлууд 1950-1960-аад оны Германы нийгэмд гол бэрхшээл болж байж. Тухайн үед Германд агаарын бохирдлын улмаас нялх хүүхдүүд эрсдэх явдал нэлээд гарч байсан ба Асендорпф багшийн амьдарч байсан хотод агаар дахь хорт бодисын хэмжээ хэт өндөр түвшинд хүрч байжээ. Ийнхүү байгаль орчны асуудал хурцаар тавигдаж, сэтгүүлчид ч үүнд чухал үүрэг гүйцэтгэжээ.

Илтгэлийн дараа орон нутгийн сэтгүүлчид “Бороо гоулд” уурхайн нөхөн сэргээлт, нийгмийн хөрөнгө оруулалт зэрэг хэд хэдэн сэдвээр Virtual хэвлэлийн бага хурал хийсэн юм. Өөрөөр хэлбэл, сэдвээ сонгож, төрөл жанраа тодорхойлон, боломжит гарчиг, зурагт жишээн дээр ажиллаж, мэдээний эх дээр хэлэлцүүлэг хийн, нэмэлт ямар ямар судалгаа, хайгуул хийх шаардлагатайг тодорхойлсон юм. Сэтгүүлчид сэдвээ өөр хоорондоо чөлөөтэй харилцан ярилцаж, Асендорпф багш ч тухай бүрт нь санал зөвлөмж өгсөн нь сургалтыг улам өгөөжтэй болгож байв.

“Таны бичиж буй нийтлэл, сурвалжлага дор хаяж гурван эх сурвалжтай байснаар баталгаажих учиртай. Сэтгүүлч хүн аливаад сэжиглэж ханддаг байх ёстой. Бид уншигчдын нүд чих болохоос тархи биш юм. Тиймээс өөрийн санаагаа хэзээ ч уншигчдад тулгаж болохгүй” хэмээн тэрээр зөвлөлөө.

Өнөө цагт сэтгүүлчдийн мэдээллийн гол сурвалжийн нэг нь интернэт. Тэгвэл Асендорпф багш “Google”-ийг ухаалаг байдлаар, өдөр тутам ашиглаж сурах зааварчилгаа өгсөн. “Залуу сэтгүүлчид шууд л google, интернэтийг судалгаагаа болгох гэж оролддог. Энэ нь буруу биш ч ихэнхдээ ул суурьтай, болгоомжтой хандах хэрэгтэй” гээд интернэтийн зөв зохистой ашиглалтын талаар хичээлээ үргэлжлүүлэв.

Асендорпф багш сургалтынхаа үеэр “Internet Arhive” гэсэн хайлтын сонирхолтой системийн талаар мөн танилцуулж, веб хуудаснаас устсан мэдээллүүдийг тус архиваас хайхад гарч ирдэгийг тодорхой жишээн дээр тайлбарлаж үзүүлсэн. ■

# БОРООГИЙН АЛТНЫ УУРХАЙТАЙ ТАНИЛЦСАН СЭТГҮҮЛЧДИЙН АЯЛАЛ

Байгаль орчны асуудал сургалтын үндсэн сэдэвт багтаж буй болохоор уурхайн үйл ажиллагаа хэдийгээр дууссан ч нөхөн сэргээлтийн ажил явагдаж буй уурхайтай танилцахаар сонгожээ. Орон нутгийн болоод төвийн сэтгүүлчид багтсан нийт 40 хүнтэй баг бүрэлдэхүүн Улаанбаатар хотоос 110 км-т орших Бороогийн алтны уурхайг зорив.

Энэ жилийн эхний сургалтад Герман улсаас доктор Дирк Асендорпф уригдан багшилсан. Тэрээр уул уурхай, байгаль орчны сэдвээр дагнан бичсэн туршлагатай сэтгүүлч учир Монголд анх удаа томилогдон ажиллахдаа алтны уурхайн нөхөн сэргээлттэй газар дээр нь танилцах болсондоо ихэд олзуурхаж байлаа.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Их Даширын хөндий дэх алтны үндсэн ордыг түшиглэн хэрэгжсэн төслийн талбай дээр очсон бид уурхайн аюулгүй байдлын журмын дагуу согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ шалгуулснаар хамгаалалтын малгай, гэрэл гялбагчтай хантааз өмсөн нэвтрэх “бүрэн эрх”-тэй болов. “Бороо гоулд” компанийн Үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирал Т.Оргодол сэтгүүлчдийг хүлээн авч, уурхайнхаа талаар танилцуулсан.

Одоо Бороогийн алтны уурхайг хаалтад бэлтгэн, уусмалаа саармагжуулах болоод нөхөн сэргээлтийн ажлууд хийж байна. Хамгийн анх 2003 оны 11 дүгээр сард уурхайн үйл ажиллагаа эхэлсэнтэй мөр зэрэгцэн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн бөгөөд “Бороо гоулд” компанийн зүгээс 1990-ээд онд Их Даширын хөндийд шороон ордын олборлолт явагдаад орхигдсон талбайг мөн давхар нөхөн сэргээж иржээ. Уурхайн үйл ажиллагаанд нийт 900 га орчим талбайг хөндөгдсөн гэж үздэг байна.

Үүнээс 2015 оны байдлаар 436 га газрын нөхөн сэргээлтийг бүх стандарт горимын дагуу хийж дуусаад улсын комисст хүлээлгэн өгсөн аж. Цаашид төлөвлөгөөний дагуу явбал 2020 он гэхэд бүх талбайгаа нөхөн сэргээж дуусна хэмээн Байгаль орчны инженер Г.Мөнхжин танилцуулсан.

Байгаль дээрээ 60 зүйлийн ургамал байсан бол одоогоор нөхөн сэргээж буй талбайд 40-өөд зүйлийн ургамал ургажээ. Энэ нь нөхөн сэргээсэн талбай байгалийн унаган төрхөндөө эргэн очиж байна гэсэн үг юм. Ургамал тарихаас гадна ойжуулалтын ажил ч хийгджээ.

2007 оноос ойжуулах ажлыг эрчимтэй хийж эхэлснээр өнөөгийн байдлаар 40 га талбайд 10 гаруй төрлийн 50 мянга орчим мод тарьсан байна. Сэтгэл гаргаад арчлах юм бол мод үнэхээр ургадгийг Г.Мөнхжин онцлон ярьж байлаа.

Нөхөн сэргээлтийн талбайтай танилцсаны дараа Боловсруулах үйлдвэрийн байгууламж болоод нуруулдан уусгах технологитой газар дээр нь очиж танилцсан нь сэтгүүлч бидний аяллын хамгийн сонирхолтой хэсэг байлаа.

Герман улсын сэтгүүлч, доктор Асендорпф нуруулдан уусгах технологийн боловсруулалтаар одоо алт гарган авч байгаа эсэх талаар уурхайн мэргэжилтнүүдээс сонирхон асуусан юм. Тус технологиор ялган авсан тодорхой хэмжээний алтыг 7 хоног тутам Улаанбаатар руу хүргэж, Монголбанкинд тушааж буй ажээ. Уурхай болоод компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээ нуухгүй нээлттэй хэлж, тайлбарлаж өгч байсан нь ихэд таалагдсан тухай сэтгэгдлээ доктор Асендорпф Улаанбаатар хот руу буцах замдаа бидэнтэй хуваалцсан юм. Сэтгүүлч бидний хувьд ч санхүү, татвар, байгаль орчин, орон нутаг дахь хөрөнгө оруулалттай холбоотой олон асуулт тавьж, хариултаа авсан юм. ■



Орон нутгийн сэтгүүлчдийн идэвх оролцоо сайн байгаад Асендорпф багш сэтгэл өндөр байв. “Зөвхөн үнэнийг өгүүлэх нь сэтгүүлчийн мэргэжлийн зарчим юм. Үргэлж энэ зарчмаа баримталж явна гэдэгт итгэлтэй байна. Та бүхэнтэй өнгөрүүлсэн өдрүүд үнэхээр сайхан байлаа” хэмээн тэрээр ярилаа.

Гурван өдрийн сургалтын дараа сэтгүүлчдэд сертификат гардуулах хүндтэй мөчид GIZ-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захирал Др.Штефан Ханселманн “Манай хөтөлбөр дөрвөн аймагт “Орон нутгийн цогц хөгжил-4 талын түншлэл” төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа.

Сэтгүүлч та бүхэн энэ үйлсэд тусална гэдэгт найдаж байна. Талуудад үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх, хамтын ажиллагааг амжилтад хүргэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо их” гэдгийг онцлон тэмдэглэсэн. GIZ-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захирал Др.Ханселманн, Дэд захирал О.Батболд, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын захирал Б.Алигэрмаа, багш Асендорпф нар орон нутгийн сэтгүүлчдэд сертификат гардууллаа.

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн 2016 оны эхний сургалтыг удирдсан ХБНГУ-ын Дойчэ Вэллэ академи болон Брэмений хэрэглээний Шинжлэх ухааны их сургуулийн сургагч багш сэтгүүлч, доктор Дирк Асендорпф Mongolian Mining Journal сэтгүүлийн редакцид зочиллоо.

**Өмнөговь аймгийн “Говийн наран” телевизийн сэтгүүлч А.Жамъяндэлгэр:**

Уул уурхайн талаар бичихдээ өнцгөө яаж зөв тодорхойлох гээд олон зүйлийг сурч авлаа. Монголд дөнгөж хөгжих гэж байгаа сэтгүүл зүйн нэг төрөл бол байгаль экологийн сэтгүүл зүй.

Байгаль экологийн сэтгүүл зүй бол маш том агуулгатай юм байна. Үүнийг хөгжүүлэх ёстой. Багш маань сэтгүүлч хүн учраас хичээл заах арга барил нь бидэнд ойр, ойлгомжтой байлаа.



**Ховд аймгийн “Ховдын телевиз”-ийн сэтгүүлч С.Жавзандулам:**

Орон нутгийн сэтгүүлчид бид нийгмийн хүчтэй дуу хоолой болж, сэтгүүл зүйн төгс бүтээл гаргах ёстой болж байна. Уул уурхайн сэдэв манай аймгийн хувьд төдий л хөндөгдөж байгаагүй. Энэ сургалтаар заавал бичих ёстой, анхаарах сэдэв юм байна гэдгийг ойлголоо.

**Сэлэнгэ аймгийн “Миний Монгол” телевизийн сэтгүүлч Ц.Бүжин:**

Орон нутгийн сэтгүүлч бид нутаг орондоо явагдаж буй уул уурхайн үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээлэл дутмаг байдгаас газар дээрээс нь бодит мэдээлэл хүргэж чаддаггүй юм байна гэдгээ ойлгож авлаа.

**Дархан-Уул аймгийн DBS телевизийн сэтгүүлч П.Майцэцэг:**

Энэ жил Бороогийн алтны уурхайтай очиж танилцсанаар танхим, дадлага хосолсон сургалт явагдлаа. Мөн Герман улсаас уригдан ирсэн, байгаль орчны чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч багшилсан нь олон улсад уул уурхайн мэдээ мэдээллийг хэрхэн түгээдэг, сурвалжилдаг талаар тун сонирхолтой мэдээллүүдийг өглөө. 30 жил уул уурхай, байгаль орчны сэдвээр бичсэн болохоор жинхэнэ мэргэшсэн сэтгүүлч юм.

Орон нутгийн сэтгүүлчдэд салбарын яамтай холбогдон статистик, тоо баримт авах сонирхол байдаг. Гэвч орон нутгаас ихэвчлэн утсаар харилцах боломжтой. Гэтэл “орон нутгаас ярьж байна” гэдэг үг нь албан тушаалтнууд хойрго хандах, хүнд суртал гаргах шалтгаан болдог.

**Завхан аймгийн “Шинэ Завхан” телевизийн захирал, “Улиастайн тойм” сонины эрхлэгч Г.Алтангэрэл**

Уул уурхайн талаар мэдээлэл уншиж байснаас яг уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж байсангүй. Алтны олборлолт дээр байгаль орчинд хортой технологи ашигладаг гэж ярьдаг. Бороогийн алтны уурхайн үйл ажиллагаатай танилцсанаар олон улсын стандартын дагуу технологийг зөв ашиглаж чадвал байгаль орчинд аюулгүй байдгийг олж мэдлээ.

**Говьсүмбэр аймгийн “Боржигон нутаг FM102.5” радиогийн сэтгүүлч Т.Болдбаатар:**

Сэтгүүлч бид уул уурхай орон нутгийн хөгжилд ямар үр өгөөж үзүүлдэг, нөхөн сэргээлтийн чиглэлээр хэрхэн ажиллах ёстой, цаашлаад татвар, лиценз гээд олон чухал мэдлэгийг олж авлаа.

Тодорхой сэдвээр мэргэшүүлэх нь Монголын сэтгүүл зүйд зайлшгүй байх шаардлагатай. ■

# 2016.08.14-15

Өвөрхангай аймаг. Хархорин сум

Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар, олон улсын музейн өндөр стандарт, шийдэлтэй баригдсан Хархорум музейн хурлын танхимд орон нутгийн сэтгүүлчдийн ээлжит сургалт эхлэв.

August 14-15, 2016

A training for local journalists was held in Kharkhorum museum, built recently with a grant from the Japanese government.

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **НЭГДСЭН СУРГАЛТ** 2016 ОН

Төслөөс хэрэгжүүлж байгаа сургалт бүр өөрийн онцлогтой, шинэ санаа сэдвээр баяжигдсан, өмнөх сургалтуудынхаа үр дүнд суурилсан байдгаараа орон нутгийн сэтгүүлчдийн анхаарлыг татдаг. Энэ удаагийн сургалт дан сэтгүүл зүйн сэдвүүдээр дагнасан нь онцлог байв.

Хархорин сумын төвөөс таван километрийн зайд, Орхон голыг хаялан байрших жуулчны кэмпүүд хол, ойрын зочдын хөлд дарагджээ. Тэдний нэг “Хаан тайж” жуулчны баазад орон нутгийн сэтгүүлчид буудалласан юм. “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас хоёр дахь жилдээ зохион байгуулж буй “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн ээлжит сургалтад хамрагдахаар алс холоос зорин ирцгээсэн хэвлэлийн багууд ээлж дараалан буусан нь энэ юм.

“Энэ төсөл богино хэмжээнийх биш. Олон жил үргэлжлэх энэхүү төслийн гол хүмүүс нь та бүхэн юм шүү. Тиймээс орон нутгийн сэтгүүлчдээс олон сайхан санал санаачилга гарна гэдэгт итгэдэг” хэмээн GIZ-ийн ЭТИС хөтөлбөрийн дэд захирал О.Батболд сургалт-семинарын нээлтийн үгэндээ тодотголоо.

Н.Батжаргал багш “Сэтгүүл зүйг шинээр харах нь” сэдэвт илтгэлээрээ сэтгүүлчдийн семинарын эхний өдрийн “салхийг хагалсан” юм.

“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ”-г сэтгүүлчдийн мэргэжлийн эрх ашгаараа нэгдэх төсөл гэж би ойлгож байна. Мэргэжлийн эрх ашиг гэдэг бол ёс зүй дээр нийгмийн харилцааг удирдах явдал юм” гэж Н.Батжаргал багш онцоллоо.

Тэрээр “Сошиал медиа ба сэтгүүл зүй”, “Орон нутгийн редакцийг чадавхижуулах нь” сэдвээр илтгэлээ үргэлжлүүлж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулсан юм.

Сэтгүүл зүйн ухааны доктор /Ph.D/ С.Энхцэцэгийн “Телевизийн сэтгүүл зүй” сэдэвт илтгэл ч орон нутгийн сэтгүүлчдийн анхаарлыг татаж байлаа. Телевизийн сэтгүүлчийн зайлшгүй эзэмших ёстой ур чадваруудыг тэрээр тодорхой жишээн дээр тайлбарлаж, онол-практикийг хослуулсан мэдээллүүд нь үр өгөөжтэй байв.

Сургалтад хамрагдаж байгаа орон нутгийн сэтгүүлчдийн цөөнгүй нь телевиз, радио удирдаж яваа залуухан сэтгүүлчид. Энэ утгаараа С.Энхцэцэг багшийн хичээл тэдэнд хүсэн хүлээсэн мэдээллүүдийг өгч чадсаныг сургалтын үеэр илэрхийлж байсан.

Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөрийн захирал Др.Штефан Ханселманн

Тэрээр "Сэтгүүл зүй ба олон нийтийн харилцаа" илтгэлдээ "Олон нийтийн харилцааны үндсэн зарчим нь байгууллага зөвхөн хаашаа явж буй, юунд хүрэх гэж байгаа тухай биш. Харин тавьсан зорилгодоо яаж хүрсэн, ямар зарчим баримталсанд оршино" гээд PR, хэвлэл мэдээллийн хоёрын ялгаа заагийн талаар ч дурьдлаа.

Семинарын хоёр дахь хэсэг үндсэндээ телевизийн салбарын асуудлуудыг хөндсөн гэж хэлж болно.

"The Mongolian Mining Journal" сэтгүүлийн дэргэдэх "Хөгжил" студийн найруулагч Х.Ганбаатар "Телевизийн ажлын практик зөвлөгөө" сэдвээр илтгэлээ.

Энэхүү сургалт-семинарын үеэр 2016 оны 7 дугаар сарын 9-нд The Diplomat сэтгүүлд нийтлэгдсэн "Эрдэнэт уурхайн нууц наймаа" хэмээх нийтлэлд сэтгүүлчид задлан шинжилгээ хийж, үзэл бодлоо хуваалцсан юм. The Mongolian Mining Journal-ийн сэтгүүлч С.Болд-Эрдэнийн хөтлөн явуулсан семинарын энэхүү хэсэг орон нутгийн сэтгүүлчдийн идэвх, оролцоонд тулгуурласан юм.

Ийнхүү хоёр өдөр амжилттай үргэлжилсэн "Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ" төслийн сургалтын үйл ажиллагааг хааж Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөрийн захирал Др.Штефан Ханселманн, дэд захирал О.Батболд, Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ-ын Орлогч эрхлэгч Н.Ариунтуяа нар үг хэллээ.

"Mongolian Mining Journal-д нэг онцлог байгаа нь улс орныхоо хөгжилд анхаарал хандуулж байгаа явдал. Үүнийгээ "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ-аар дамжуулан харуулж буйд талархал илэрхийлье.

Эргэн тойронд хөгжлийн маш их өөрчлөлт явагдаж байна. Сэтгүүлч та бүхэн энэ хөгжилд чухал үүрэгтэй юм шүү. Монголын өнөөдрийн нөхцөл байдлыг авч үзвэл, санаанд байгаа төслүүдийг шууд хэрэгжүүлчих эдийн засгийн хүч бололцоо дутмаг байна. Гэхдээ сэтгүүлч та бүхэнд хөгжлийг авчирч чадах хүч, эрх мэдэл байгаа" хэмээн Др. Штефан Ханселманн ярилаа.

Орон нутгийн сэтгүүлчдийн хувьд мэргэжлийн сургалтад хамрагдахаас гадна өөр өөрсдийн сонин хэвлэл, телевиз радиодоо нийтлэл, сурвалжлага бэлтгэх үүрэгтэй. Тиймдээ ч тэд сургалтын дараах чөлөөт цагаараа эртний түүхт Эрдэнэзуу хийд, Хархорум музей болон Орхоны хөндийн түүх дурсгалуудтай танилцсан юм. ■

Эртний түүхт Хархорум, эдүгээгийн Өвөрхангай аймгийн Хархорин сум бол Их Монголын хаант төрийн сүр хүч, хөгжлийн гайхамшигт өв соёлыг хадгалан үлдсэн гал голомт билээ.
Тиймдээ ч аянчин гийчид эндхийн байгалийн гоо үзэмж, Орхоны хөндийн түүх дурсгал, Бурханы шашны анхны цогцолбор Эрдэнэзуут үзэж нүдээ хужирлахаар зорин ирдэг.

# 2016.11.14-15

Улаанбаатар хот. Blue Sky Hotel

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөрийн дэмжлэгтэй хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулсан төслийн хаалтын нэгдсэн уулзалт боллоо.

November 14-15, 2016

A training was held to mark the end of the second year of the LNN project.

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН ХААЛТЫН **НЭГДСЭН УУЛЗАЛТ** 2016 ОН

Өнгөрсөн хугацаанд төслийн хүрээнд өөр өөрийн онцлог, үе шаттай зургаан удаагийн цуврал сургалтыг 15 аймгийн 70 орчим сэтгүүлчийг хамруулан зохион байгуулжээ. Эдгээр сургалтад идэвхтэй оролцсон 35 сэтгүүлч төгсгөлийн сургалт семинарт хамрагдсан юм.

Өмнөх өдрүүдэд нь хот, хөдөөгүй цасаар шуурч, цаг агаар огцом хүйтэрсэн ч орон нутгийн сэтгүүлчид хүндрэл бэрхшээлийг үл ажран зорьсон газартаа, товлосон цагтаа цугларсан юм.

"Орон нутгийн сэтгүүлчид гэж хэн бэ?" Хэдийгээр алслагдмал хөдөө, орон нутагт ажилладгаар нь ингэж нэрлэж байгаа ч төвийн сэтгүүлчдээс ялгаагүй мэдээллийн орон зайд амьдарч, олон нийтийг мэдээ мэдээллээр хангадаг зарчим нь адил.

Орон нутгийн сэтгүүлчдийн уул уурхай, эдийн засгийн мэдлэг чадварыг дээшлүүлж, энэ чиглэлээр мэдээ, мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх сэдэл төрүүлэх, үйл ажиллагаа нь идэвхжүүлэх зорилгоор төслийг эхлүүлсэн билээ. Эрдэс баялгийн салбарын талаарх сэтгүүлчдийн боловсрол, хандлага, мэдлэг, ёс зүйг төлөвшүүлснээр нийгэмд зөв ойлголт, хандлага төлөвшиж чадна. Тиймээс сэтгүүлчдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөрөө уул уурхайн салбарын мэдлэг ойлголтоор хязгаарлалгүйгээр сэтгүүл зүйн салбарын хөгжлийн чиг хандлага, өөрчлөлтийн талаарх мэдээллийг ч хүргэхийг эрмэлздэг.

Төгсгөлийн семинарт ХБНГУ-ын Мюнхен мужийн харьяат, сэтгүүлч Бернд Освальд цахим сэтгүүл зүйн чиг хандлага, түүний зөв зохистой хэрэглээний талаарх туршлагаа хуваалцсан юм.

"Бернд Освальд багшийн хувьд цахим сэтгүүл зүйгээр мэргэшиж, энэ чиглэлээр олон удаагийн сургалт зохион байгуулсан туршлагатай нэгэн. Сүүлийн үед олон нийт нийгмийн сүлжээг идэвхтэй ашиглаж, мэдээ мэдээлэл түгээж байна. Тэднийг мэргэжлийн сэтгүүл зүйгээс ялгаж салгаж ойлгоход Бернд Освальд багшийн хичээл туслах байх" хэмээн ЭТИС хөтөлбөрийн Дэд захирал О.Батболд сургалтыг нээж хэлсэн үгэндээ онцолсон.

Сэтгүүл зүйн сургагч багш Бернд Освальд нь 2001-2009 онд www.sueddeutsche.de мэдээллийн сайтад улс төрийн нийтлэлийн эрхлэгч, мэдээний хэлтсийн даргаар ажиллаж байжээ.

Энэ удаагийн сургалтаар тэрээр "Интернэтийн сүлжээний хайлтын үр дүнг сайжруулах нь", "Time-line, инфографик хийх аргачлал", "Нийгмийн сүлжээг сэтгүүл зүйд ашиглах нь" гэсэн сэдвүүдээр хичээл заасан юм. "Юуны өмнө, сэтгүүлчид цахим ертөнцөд хэрхэн эрэл хайгуул хийх талаар суралцах болно. Google болон хайлтын бусад системийг илүү дэвшилттэй аргаар ашиглаж, нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээллийг яаж авах, баримтыг шалган баталгаажуулахад юуг анхаарах ёстой талаар тодорхой ойлголт өгөхийг хичээлээ" хэмээн сургагч багш хичээлээ эхлүүлэв.

Түүний хичээлтэй уялдуулан The Mongolian Mining Journal-ын сэтгүүлч Э.Оджаргал интернэт болон хайлтын системүүдийг сэтгүүлчийн хувиар хэрхэн ашигладаг өөрийн туршлагаа хуваалцсан.

ХБНГУ-ын сэтгүүлч Бернд Освальд

Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт

Кадастрын хэлтсийн дарга Д.Мөнхтамир:

Геологи хайгуулын хэлтсийн дарга Д.Алтанхуяг:

Орон нутгийн сэтгүүлчдийн хувьд нийслэл хотод байгаа эх сурвалжуудаас бодит мэдээлэл авах боломж хомс. Тиймээс хаалтын семинарын үеэр тэднийг уул уурхайн салбарын гол төлөөллүүдтэй холбож, ярилцлага, мэдээлэл авах бололцоог ММЈ сэтгүүлийн зүгээс олгохыг хичээдэг. Энэ удаад Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт, Кадастрын хэлтсийн дарга Д.Мөнхтамир, Геологи хайгуулын хэлтсийн дарга Д.Алтанхуяг нар мэдээлэл хийж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулсан юм.

Мөн сургалтын хүрээнд уул уурхайн салбарын туршлагатай мэргэжилтнүүдийг урьж, чөлөөт ярилцлага өрнүүлдэг уламжлалтай. Энэ удаад Монголын уул уурхайн салбарын хууль эрх зүйн шинэчлэл, хөрөнгө оруулалтын орчны чиглэлээр олон жил ажилласан туршлагатай МУУҮА-ийн ерөнхийлөгч Н.Алгаа, "Эрдэнэт" үйлдвэрийн 30 гаруй жилийн бүтээн байгуулалтад оролцсон туршлагатай мэргэжилтэн, Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуулийн Хөгжлийн асуудал эрхэлсэн Орлогч захирал, профессор С.Давааням нарыг урьсан юм.

*"Хэвлэл мэдээллийн салбарын 80-90% нь нийгмийн чиглэлийн, үлдсэн нь бизнесийн үйл ажиллагаа явуулдаг бол уул уурхайн 80-90% нь бизнесийн, харин үлдсэн нь нийгмийн чиглэлийнх байдаг. Уул уурхайн компаниуд эхлээд ашгаа олохгүй бол нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж чадахгүй. Тэгвэл хэвлэл мэдээлэл нийгмийн чиглэлийн үүргээ илүү сайн гүйцэтгэж чадвал олон уншигчтай болж, тэр хэрээрээ ашгаа хүртдэг. Мэргэшихийн цаад талд мэдлэг байх ёстой. Мэдээллийн урсгалыг шүүгээд, дүн шинжилгээ хийснээр мэдлэг бий болдог"* хэмээн **МУУҮА-ийн ерөнхийлөгч Н.Алгаа** хэлсэн юм.

**Профессор С.Давааням** уул уурхайн салбарын талаарх болохгүй бүтэхгүй бүхнийг түүж бичихийн зэрэгцээ болж бүтэж байгааг олж харж бичээсэй хэмээн хүсдэгээ хэлсэн. Тэрээр хүн төвтэй тогтвортой хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, мэдээлэл бүхий иргэд ба олон нийтийн ойлголт хяналт зэрэг цогц ойлголтын талаар сэтгүүлчдэд тодорхой мэдээлэл өгсөн.

Сургалтын дараагийн хэсэгт **МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн дэд профессор, доктор Б.Наранбаатар** "Мэдээллийн тренд VS үзэл бодлын сэтгүүл зүй" сэдвээр илтгэлээ. Орчин үеийн сэтгүүл зүйн шинэ үзэгдлийг тэрээр баялаг жишээ баримтаар тайлбарлаж, олон нийтийн мэдээллийн эмх замбараагүй орчинд иргэд төөрөх, өөрөө мэдээлэл бүтээгч байхыг эрмэлзэх, ашиггүй, ач холбогдолгүй мэдээллийг залгигч болон хувирч байгааг онцлон ярилаа.

Д.Мөнхбүрэн

С.Давааням

Сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэж явахдаа таамаглаагүй эрсдэлд орох тохиолдол их бий. Ийм эрсдэлээс хэрхэн сэргийлэх талаар "Глоб интернэшнл төв" ТББ-ын хуульч Д.Мөнхбүрэнгийн өгсөн зөвлөгөө үр өгөөжтэй байлаа.

*"Шүүмжлэлтэй, хурц нийтлэл хэвлэгдэхэд ашиг сонирхол нь хөндөгдсөн тодорхой хүмүүс, байгууллага нэхэмжлэл гаргана. Тиймээс сэтгүүлч өөрийн бичсэн нийтлэлтэй холбогдох бүх баримт, нотолгоог бүрдүүлж гаргаж тавих ёстой. Сэтгүүлч мэдээлэл цуглуулахдаа мэдээлэл өгсөн хүнээсээ ярилцлагыг диктафон, гар бичмэл болон аль ч хэлбэрээр авсан тэр хүнээрээ гарын үсэг зуруулж, баталгаажуулах хэрэгтэй"* хэмээн **Д.Мөнхбүрэн хуульч** сэтгүүлчдэд зөвлөсөн.

Орон нутгийн сэтгүүлчдийн уул уурхай, эдийн засгийн мэдлэгийг тэлэх, ур чадварыг нь хөгжүүлэх хөшүүрэг болохын зэрэгцээ сургалтын үр дүнгээ үнэлэхийн тулд сэтгүүлчдэд гэрийн даалгавар болгож, нийтлэл, нэвтрүүлгийн уралдаан зарладаг билээ. Бүтэн жилийн сургалтын дараа сэтгүүлчид уул уурхай, эдийн засгийн чиглэлээр нийтэлж, нэвтрүүлсэн бүтээлээ ирүүлж, түүнд Шүүгчдийн зөвлөл анализ хийн, үнэлж дүгнэдэг уламжлалтай.

Энэ удаагийн сургалтад **“Боржигон” FM радиогийн сэтгүүлч Т.Болдбаатарын** “Таамаглал хийгээд андуурал”, **Дорноговь аймгийн “Д медиа” агентлагийн сэтгүүлч З.Энхзулын** “Дорноговийн уул уурхайн татвар ба зарцуулалт”, **“Алтайн мэдээ” сонины сэтгүүлч Э.Нарангэрэлийн** “Замын амлалт завсарлах болсон нь хэн гуайн гавьяа вэ?”, **“Өвөрхангайн мэдээ” сонины сэтгүүлч Б.Мөнгөнцэцэгийн** “Бөөрөлжүүтийн энэлэн” гэсэн дөрвөн нийтлэл уралдаанд ирсэн юм. Харин нэвтрүүлгийн төрөлд **Ховд аймгийн “Жаргалант” телевизийн сэтгүүлч С.Жавзандуламын** “Цаанаа учиртай цагаан эрэг”, **Баянхонгор аймгийн “Хонгор” телевизийн сэтгүүлч Т.Тамжидмаа, Ч.Мягмарсүрэн** нарын “Хогийн цэгийн асуудал”, **Сэлэнгэ аймгийн “Мандал” телевизийн сэтгүүлч Ц.Ундармаагийн** “Хуулийг хэн хэрэгжүүлэх вэ?”, **Баянхонгор телевиз”-ийн сэтгүүлч Д.Дэлгэрсайханы** “Хонгорын хүдэр ХХК-тай Элчин сайд танилцав” нэвтрүүлгүүд өрсөлдөв.

Шүүгчдийн зөвлөлийн гишүүнээр МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн дэд профессор, доктор Б.Наранбаатар, ЭТИС хөтөлбөрийн Дэд захирал О.Батболд, Сэтгүүл зүйн ухааны доктор (Ph.D) С.Энхцэцэг, The Mongolian Mining Journal сэтгүүлийн Орлогч эрхлэгч Н.Ариунтуяа, сэтгүүлч Г.Идэрхангай, С.Болд-Эрдэнэ нар ажиллаж, уралдаанд ирүүлсэн найман бүтээл дээр өөр өөрийн үнэлэлт дүгнэлтээ өгч, шалгаруулалтыг хийсэн юм. Шалгаруулалтыг сэтгүүл зүйн шилдэг бүтээлийн таван үндсэн шалгуураар үнэлж, онооны системээр дүгнэв.

Орон нутагт тулгамдсан асуудлуудыг сэтгүүлчид зоригтой хөндөж, баримт эх сурвалжийг сайн ашиглаж байгаа ч нийтлэлийн бүтэц, зохиомж, хэл найруулга болон гарчгийн алдаа нийтлэг байгаа бол нэвтрүүлгийн хувьд зохиолгүй, шинэлэг санаа багатай, нэг талыг барьсан эх сурвалжуудыг түлхүү ашигласан дутагдал түгээмэл байв. Эдгээр бүтээл голдуу уул уурхайг өөрөгөөр харсан, орон нутагт өрнөж байгаа бүтээн байгуулалтын талаарх газар дээрээс хийсэн амьд сурвалжлага гэдгээрээ онцлог байлаа.

Нэгдсэн сургалт уулзалт семинарын төгсгөлд нийтлэл, нэвтрүүлгийн шилдгүүдийг зарласан юм. Уралдаанд ирсэн бүтээлүүдээс онооны нэгдсэн дүнгээр хамгийн өндөр оноог “Хуулийг хэн хэрэгжүүлэх вэ” нэвтрүүлгээрээ Сэлэнгэ аймгийн “Мандал” телевизийн сэтгүүлч Ц.Ундармаа, “Замын амлалт завсарлах болсон нь хэн гуайн гавьяа вэ?” нийтлэлээрээ “Алтайн мэдээ” сонины сэтгүүлч Э.Нарангэрэл нар авч, Австрали улсад 14 хоног суралцах эрхийн эзэд болов. **ЭТИС хөтөлбөрийн захирал Ш.Ханселманн, Дэд захирал О.Батболд** нар нийтлэл, нэвтрүүлгийн тэргүүн байранд шалгарсан сэтгүүлчдэд эрхийн бичгийг гардуулан өгсөн юм.

**ЭТИС хөтөлбөрийн захирал Ш.Ханселманн** *“Уралдаанд идэвхтэй оролцож, бүтээлээ ирүүлсэн сэтгүүлчдэд талархал илэрхийлье. Та бүхэн сургалтдаа олноороо ирж оролцож байна. Монгол гэлтгүй, дэлхий нийтэд сэтгүүл зүйн чиг хандлага интернэтийн хурдацтай хөгжлөөс шалтгаалж өөрчлөгдөн хувирч байна. Иргэд энэ их мэдээлэл дунд төөрөх, үүнээс болж нэг талыг барьсан өрөөсгөл мэдээлэл олж авч, улмаар буруу шийдвэр гаргах зэрэг асуудал тулгардаг. Сэтгүүлч та бүхний үүрэг бол эдгээр мэдээллийг судалж, үнэлж, бодитой үнэн зөвийг нь иргэдэд хүргэх билээ. Энэ үйлстээ нэг баг болж ажиллаж байгаад баяртай байна”* гэлээ. ■

Сэлэнгэ аймгийн “Мандал” телевизийн сэтгүүлч Ц.Ундармаа

“Алтайн мэдээ” сонины сэтгүүлч Э.Нарангэрэл

Өмнөговь аймаг

| | |
|---|---|
| Ханбогд | 2017.06-28-29 |
| Цогтцэций | 2017.06.30 |
| Даланзадгад | 2017.07.1-2 |

Монгол орны 21 аймгаас ирсэн сэтгүүлчид нийслэл хотын хөл хөдөлгөөн эхлэхээс урьтан өмнийн говийн уул уурхайн үйл ажиллагаатай танилцахаар аян замдаа гарлаа. “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл энэ жил хүрээгээ тэлж, 21 аймгийн сэтгүүлчид сургалтад хамрагдаж байгаа юм.

June 28-July 2, 2017

Three trainings were held for journalists from all 21 provinces of Mongolia, now covered by the LNN project. All were organized in Umnugoviaimag so that trips could be made to big and modern mines. The first was in Khanbogd soum on June 28-29, the second in Tsogttsetsii soum on June 30, and the third in Dalanzadgad on July 1-2.

Mining Journal · германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT · Хэрэгжүүлэгч: giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **ТАНИЛЦАХ АЯЛАЛ**

# 2017 ОН

2017 оны сургалтад 21 аймгийн 39 сэтгүүлч хамрагдсанаар Монгол улсын өнцөг булан бүрт хүрсэн сүлжээ бий болж байна.

21 аймгийн сэтгүүлчдийг өмнийн говийн уул уурхайн үйлдвэрлэлтэй танилцуулах аяллыг дэмжиж, уурхай, үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагаатай танилцах боломжийг олгосон “Оюутолгой” ХХК, “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон Өмнөговь аймгийн нутгийн захиргааны байгууллага, Ханбогд сумын ИТХ, Засаг даргын Тамгын газарт сургалт зохион байгуулсан Хөгжлийн төлөө сэтгүүл зүй, The Mongolian Mining Journal сэтгүүлийн редакциас гүн талархал илэрхийлье.

Оюу Толгой

**Өмнөговь аймаг.** Ханбогд-Цогтцэций-Даланзадгад. **“Оюутолгой”-н ил уурхай**

Сургалтын үе шат бүхэнд орон нутгийн сэтгүүлчид чадавхжиж, уул уурхайн талаарх мэдлэг, ойлголт гүнзгийрч буй нь нийтлэл, нэвтрүүлгээс нь тодорхой харагддаг билээ. Үүний цаана орон нутгийн ард иргэд эрдэс баялгийн салбарын олон талт сэдвээр бодитой мэдээлэл олж авах ач тус оршиж байгаа юм. 2017 онд орон нутгийн сэтгүүлчдийн хүсэлтээр сургалтын агуулгыг тэлж, уул уурхайн үйлдвэрлэл хамгийн эрчимтэй өрнөж буй өмнөд бүс нутгийг зорьсон билээ.

Улаанбаатар хотоос Өмнөговь аймгийн Цогтцэций сум хүртэл 530 орчим километр зайтай. Шороон замаар хоёр хоног тоос татуулан давхидаг хуучин цаг алсарч, хатуу хучилттай шинэхэн зам биднийг говь нутаг руу хөтлөв. Говь нутагт ган нүүрлэв үү гэлтэй, хурц нар шарж, хуурай бүгчим агаар ноёрхоно. “Манай нутагт бэлтгэлтэй ирээрэй, 50 хэм хүрч байгаа шүү” хэмээн Өмнөговь аймгийн сэтгүүлч нөхөд хэд хоногийн өмнөөс сануулсан.

Урт замын бүтэн өдрийн нэгэн хэвийн аялал Цогтцэций сумаар дайрч, Тавантолгой-Гашуунсухайтын нүүрс тээврийн зам руу орж ирэх үеэс эрс өөрчлөгдөв. Өмнийн говийн уул уурхайн үйл ажиллагааны хамгийн сэтгэл эмзэглэм дүр зургийг эндээс 21 аймгийн сэтгүүлчид олж харсан юм.

Нүүрс тээврийн том оврын машинууд зогсоо зайгүй зөрөлдөн хурдлан давхих энхэл донхол замаар зорчино гэдэг үнэхээр “экстрим” аялал байлаа. Нүсэр том тэрэг замын хажуу руу унаж осолдсон тохиолдол дөрвөн ч газарт тааралдсан нь нүд хальтрам харагдана.

"Энержи Ресурс" компани Гашуунсухайт боомт хүртэлх 267 км нүүрс тээврийн шил шиг толийх авто замыг нээн тууз хайчилж байсан нь хэдхэн жилийн өмнөх үйл явдал.

Гашуунсухайтын автозамаар зуу гаруй километр давхисны эцэст бид Оюутолгойн сайжруулсан шороон замаар салж, Ханбогд сумаас 11 километрийн зайд орших алдарт Галбын гурван хийдийн нэг Дэмчогийн хийдийн дэргэдэх "Бурхан заяа" жуулчны баазад ирлээ. Энд ер бусын амгалан орших ажээ.

Сургалтын хөтөлбөрийн дагуу сэтгүүлчид өглөө эртлэн Монголын зэс, алтны томоохон төсөл болох Оюутолгойн уурхайтай танилцахаар зорилоо.

## ОЮУТОЛГОЙ БА ТҮҮНИЙГ ДАГАСАН ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛ

Мянга сонсохоор нэг үз гэдэг. Монгол улсад хэрэгжиж байгаа уул уурхайн хамгийн том төслийн талаар олон нийтэд янз бүрийн мэдээлэл очдог ч мэдээ мэдээллийг хүргэх гүүр болдог сэтгүүлчид газар дээр нь ирж, энэхүү аварга бүтээн байгуулалтыг бодитоор харах нь чухал билээ.

Уурхайн ажилтан, албан хаагчдад тулгарах эрсдэл, болзошгүй хор хохирлыг тус төвийн сургалтын танхимд хамтын оролцоотойгоор, сонирхолтой байдлаар үзүүлдэг. Аюулгүй ажиллагааг дагаж мөрдөөгүй, анзааргагүй, хэнэггүй байдлаас болж ямар аюултай нөхцөл байдалд орж болохыг ойлгуулсан богино хэмжээний, өгөөжтэй сургалтыг Оюутолгойн ажилтнууд сэтгүүлчдийн дунд зохион байгууллаа. Мэдээж хэрэг Оюутолгойн уурхайд ирсэнийх сэтгүүлчид гүний уурхайн бүтээн байгуулалтыг илүүтэй сонирхож байлаа.

Гүний уурхайн бүтээн байгуулалт зургаан жил үргэлжилнэ. Одоогоор 15 километрийн урт хонгил байгуулаад байгаа бөгөөд ирэх таван жилд 200 км хонгил барьж, хүдрээ олборлох тооцоотой байгаа аж. Анхны хүдрээ гаргаж авахын тулд 60 орчим километр хонгил ухах шаардлагатай юм байна.

Оюутолгойн гурван ордын нэг болох Өмнөд Оюу ил уурхайтай танилцлаа. Тусгайлан бэлдсэн тавцан дээрээс ил уурхайн олборлолтын явц бүхэлдээ харагдах ба хүдэр ачсан том оврын техникүүд тэртээ алсад зав чөлөөгүй давхилдана.

2011 оны наймдугаар сард ил уурхайн хөрс хуулалтыг эхлүүлсэнээс хойш өдгөө хоногт 300 орчим мянган тонн уулын цул олборлон, 100 гаруй мянган тонн хүдрийг Баяжуулах үйлдвэрт нийлүүлж байна. Аюулгүй ажиллагааны үүднээс сэтгүүлчид Оюутолгойн бүтээн байгуулалтыг автобусны цонхоор ажиглаж, дуран авайдаа буулгаж байлаа. Шахуу төлөвлөгөөтэй аялалын нэг хэсэг нь Оюутолгойн "Цэвэр усан хангамжийн цогцолбор"-ын танилцуулга байв.

Аяллын дараагийн хэсэг Ханбогд уулынхаа нэрээр нэрлэгдсэн, 93 жилийн түүхтэй Ханбогд суманд өрнөлөө. Оюутолгойн уурхайгаас 30 гаруй километр газар сайжруулсан замаар давхиад л Ханбогд сум хүрдэг аж. 2016 оны есдүгээр сараас Оюутолгой-Ханбогд чиглэлийн хатуу хучилттай автозамын ажил эхэлсэн бөгөөд 2018 оны сүүлээр уг замыг барьж дуусгахаар төлөвлөж.

ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

**Өмнөговь аймаг.**
Ханбогд-Цогтцэций-
Даланзадгад.
**"Энержи Ресурс"-ийн Ухаахудагийн нүүрсний уурхай**

Дэргэдээ "Ханбумбат" хэмээх олон улсын стандартын нисэх буудалтай, Галбын улаан тэмээ, гавилууд омгийн илүү нугаламт хониороо алдартай Ханбогд сумын өнгө төрх өдрөөс өдөрт өөрчлөгдөж байна. Том төслийн нийгмийн хариуцлагын хүрээнд тус суманд хийж хэрэгжүүлсэн олон бүтээн байгуулалтын нэг нь Иргэдийн хөгжлийн төв.

Энэ төвийн хурлын танхимд Ханбогд сумын Засаг дарга Б.Дэндэвсамба, ИТХ-ын дарга И.Эрдэнэжаргал нар сэтгүүлчидтэй уулзаж, сум орон нутагт өрнөж буй сүүлийн үеийн үйл явдлуудын талаар мэдээлэл өгсөн юм.

Засаг дарга Б.Дэндэвсамба "Манай нутаг бол Монгол орны цаг уурын хамгийн халуун цэг. Өнөөдөр гэхэд, агаарын хэм 39, хөрсний температур 70 орчим хувьтай байна. Түүнчлэн 32 километрийн тойрог үүсгэсэн шүлтлэг боржингийн массивын сүүдэр зүйн хойд талд Ханбогд сум оршдог учраас халуун, хүйтний хямралаас үүддэг жин цохих гэж өвчин бий. "Оюутолгой" компани аюулгүй ажиллагаар эрхэмлэдэг тул та бүхэнд хамгийн түрүүнд энэ тухайгаа дуулгаж байгаа юм шүү" гээд яриагаа эхлүүллээ.

## "ЭНЕРЖИ РЕСУРС" ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСЭЭ ЭКСПОРТОЛЖ ЭХЭЛЖЭЭ

"Бурхан заяа" жуулчны баазаас эртлэн хөдөлсөн сэтгүүлчид аяллын хөтөлбөр ёсоор Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж буй "Энержи Ресурс" компанийн Ухаахудагийн уурхайг зорилоо. Биднийг очиход тус компани шинэхэн мэдээлэлтэй угтаж авсан юм. Учир нь, "Энержи Ресурс"-ийнхэн Өмнөговь аймагтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж, аймаг, орон нутагтай харилцах харилцаа, хамтын ажиллагаагаа илүү өргөн түвшинд баталгаажуулаад удаагүй байв.

Сэтгүүлчид Ухаахудаг уурхайн бүтээн байгуулалт, тэр дундаа жилдээ 15 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадалтай Нүүрс баяжуулах үйлдвэр, дөрвөн аймгийг цахилгаанаар хангахуйц эрчим хүч үйлдвэрлэх, байгальд ээлтэй Цахилгаан станц, 600 хүүхдийн "Мөрөөдөл" сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр, Цэций хороололтой танилцлаа.

"Оюутолгой", "Энержи Ресурс" гээд томоохон компаниуд орон нутагтай хамтран ажиллах тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байгаа нь бусад аймгийн сэтгүүлчдийн сонирхлыг татаж байсан юм.

Ухаахудагийн Нүүрс баяжуулах үйлдвэр 40 сая дахь тонн нүүрсээ хүлээн авч, нүүрс олборлолт, боловсруулалтын хэмжээ далайцаараа Монголын уул уурхайн салбарын түүхэнд шинэ амжилт тогтоосон нь 2016 он. Тэгвэл биднийг Ухаахудаг цогцолбор дээр очиход уурхайн удирдлагууд олборлолт анх эхэлснээс хойш нийт 230 сая гаруй куб метр хөрс хуулж, 44 дэх сая тонн нүүрсээ олборлоод байгааг дуулгасан юм.

Орон нутгийн сэтгүүлчдийн танилцах аялал Тавантолгойн Цанхийн Баруун, Зүүн уурхайд олборлолт явуулж буй төрийн өмчит Эрдэнэс Тавантолгойн уурхайтай танилцсанаар үргэлжлэв.

## ӨРИЙН ДАРАМТААС ГАРСАН ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙНХОН ӨӨДРӨГ БАЙНА

**Өмнөговь аймаг.** Ханбогд-Цогтцэций-Даланзадгад. **“Эрдэнэс Тавантолгой” компанийн Баруун Цанхи, Зүүн Цанхийн нүүрсний уурхай**

“Чалко” компанид коксжих нүүрс нийлүүлэх 350 сая ам долларын гэрээг 2011 онд байгуулсныг та бүхэн мэдэж байгаа. Энэ өрөө бид 2017 оны дөрөвдүгээр сарын 1-нд бүрэн барагдуулсан” хэмээн Эрдэнэс Тавантолгой уурхайн менежер Р.Нацагдаш сэтгүүлчдэд итгэл дүүрэн хэлэв.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн нуруун дээр хэдэн жилийн турш том ачаа болж ирсэн уг асуудал шийдэгдсэнд жирийн уурхайчдын магнай тэнийж буй нь илт. Сэтгүүлчдийн хувьд Гашуунсухайтын автозамтай холбоотой асуултыг уурхайн удирдлагуудад түлхүү тавьж байлаа.

Тавантолгой ордод Цанхийн Зүүн уурхай 1.2 тэрбум, Цанхийн Баруун уурхай 1.7 тэрбум тонн, Бортээг 2 тэрбум, Оорцог 578 сая тонн, Бортолгой 226 сая тонн, Онч хараат 1.4 тэрбум тонн гээд нийт 7 тэрбум 382.5 сая тонн нүүрсний нөөц бүртгэгджээ.

Өмнө нь 6.4 тэрбум тонн нөөцтэй гэгдэж байсан тус ордын нөөцийг “Норвест“ компани JORC ангиллаар шинэчлэн тогтоож 7.4 тэрбум тонн болгосон. Учир нь хуучин Зөвлөлтийн геологиор хоёр метр гүн хүртэлх нөөцийг тогтоогдоггүй байсан бол JORC ангиллаар 20 сантиметр хүртэлх нүүрсний зузааныг тооцсоноор ийм хэмжээний нөөц гарч ирсэн гэдгийг “Эрдэнэс Тавантолгой” компанийн уурхайн удирдлагууд орон нутгийн сэтгүүлчдэд тайлбарласан юм. ■

## СЭТГҮҮЛЧИД УУРХАЙН ТЭМДЭГЛЭЛИЙН ЭХНИЙ ЗАГВАРУУДАА ТАНИЛЦУУЛАВ

**Долдугаар сарын 1.** Өмнийн говийн уурхайтай бүтэн хоёр өдөр танилцсан сэтгүүлчдийн баг энэ өдөр Даланзадгад хотын Нутгийн захиргааны ордны хурлын танхимд сургалт семинарын албан ёсны нээлтээ хийлээ. Сургалтын нээлтэд аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай эрхэлсэн орлогч С.Мөнхбаяр, Даланзадгад сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч Т.Алтансүх нар оролцож товч мэдээлэл хийсэн юм.

Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн Дэд захирал О.Батболд “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал” сэдвээр илтгэл тавьсан юм.

Дараа нь сургалтын үр дүнг бататгах семинар үргэлжилж, сэтгүүлчдийг багуудад хуваан, нийтлэл нэвтрүүлгийн загвар төлөвлөгөө боловсруулсан юм. Эцэст нь тэдэнд сургагч багш нар товч зөвлөгөө өгсөн билээ. Уул уурхайн бодит үйл ажиллагаатай танилцсан сэтгүүлчдийн бичсэн нийтлэл, нэвтрүүлгийг “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас зарласан удирдамжийн дагуу мэргэжлийн баг шалгаруулж, ирэх аравдугаар сард Улаанбаатар хотноо болох уулзалтаар танилцуулах юм. ■

# 2017.10.9-10

Улаанбаатар хот. “Туушин” зочид буудал “Сүлд” танхим

“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн 2017 оны хаалтын сургалт “Туушин зочид буудлын “Сүлд” танхимд эхэллээ.

October 9-10, 2017

The final training of 2017 was held in Ulaanbaatar.

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **ХААЛТЫН СУРГАЛТ** 2017 ОН

“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийг 2015, 2016 онд амжилттай хэрэгжүүлж, 6 удаагийн цуврал сургалтыг Сэлэнгэ, Баянхонгор, Өвөрхангай аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулсан билээ. Сургалтад хоёр жилийн хугацаанд 16 аймгийн 80 сэтгүүлч хамрагджээ.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол дахь зохицуулагч Н.Дорждарь

Монголын олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон,

Монголын олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн харилцааны менежер Б.Дэлгэрмаа

Орон нутгийн сэтгүүлчид уул уурхайн үйлдвэрлэл өрнөсөн халуун цэгүүдэд ойрхон ажиллаж амьдарч, орон нутагт үүсээд байгаа асуудлын дунд нь байж биеэр мэдэрдгээрээ төвийн сэтгүүлчдээс ялгаатай. Тиймээс ч байгаль орчинд үзүүлж буй уул уурхайн сөрөг нөлөөлөл, гол усны бохирдол, нөхөн сэргээлт хийх нэрийдлээр олборлолт явуулж буй хууль бус үйл ажиллагаа, бичил уурхайчдын балаг, уул уурхай ба орон нутгийн харилцаа, орон нутгийн удирдлагуудын “хөшиг”-ний арын хуйвалдаан, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах явдал зэрэг болж бүтэхгүй бүхнийг сурвалжилж, олон нийтэд хүргэх хүндхэн ачааг орон нутгийн сэтгүүлчид л нуруун дээрээ үүрдэг. Тэр хэрээр төрөл бүрийн дарамт шахалтад өртөхөөс гадна уул уурхайн салбарын мэдлэг мэдээлэл, бодит эх сурвалж дутмагаас үүдэн мэдээллээ бүрэн дүүрэн, мэргэжлийн түвшинд хүргэж чадахгүй байх тохиолдол олон.

Монгол улсын эдийн засгийн тулгуур салбар болох уул уурхайн үйл ажиллагаа нь орон нутагт өрнөдөг. Тиймээс орон нутгийн сэтгүүлчдийн хувьд уул уурхай, эдийн засгийн мэдээллийг түгээх, ашигт малтмалын салбарын мэдээллийг нарийн ойлгож задлан шинжлэх нь чухал юм.

Өнгөрсөн жилийн өдийд сэтгүүлчид цасан шуурга, байгалийн онц аюултай үзэгдлийг туулан Улаанбаатар хотноо ирж байсан нь энэ удаад ч давтагдав. Хүчтэй цасан шуурганы улмаас орон нутагт тээврийн хөдөлгөөн саатсан ч шөнөжин довтолгосоор өглөө сургалтдаа амжиж ирсэн сэтгүүлчид олон байлаа. Эхний өдрийн сургалт-семинар уул уурхайн мэдээллийн ил тод байдал, байгаль орчны нөхөн сэргээлт, уул уурхайн салбарын цаг үеийн мэдээлэл, асуулт хариултын хүрээнд болж өнгөрсөн юм.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол дахь зохицуулагч Н.Дорждарийн илтгэлээр сургалт эхэлсэн бөгөөд уул уурхайн салбарын ил тод байдал яагаад чухал болох, түүнчлэн Монгол улсад ил тод байдлын өнөөгийн нөхцөл байдал ямар түвшинд байгаа талаар тодорхой ойлголт өглөө.



Өмнөговь аймгийн “Алтанговь” телевизийн сэтгүүлч Н.Энхцэцэг

Улс төрийн коммуникацийн хүрээлэнгийн захирал Ц.Мөнхцэцэг

“Ийгл” телевизийн Ерөнхий продюссер Ж.Хулан

МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор Б.Наранбаатар

Үргэлжлүүлээд Монголын олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны менежер Б.Дэлгэрмаа нар Эрдэс баялгийн салбарт ил тод болж буй мэдээлэл, Компаниудын ашиг хүртэгч эздийг ил зарласнаар нийгэмд үүсэх эерэг үр нөлөө, Орон нутагт байгуулагдаж буй хамтран ажиллах гэрээний ил тод байдал ба тулгамдаж буй асуудлууд, Эрдэс баялгийн салбарт ил тод болж буй мэдээллийг ашиглах арга зүйн талаар танилцуулга хийж, бүлгийн ажил зохион байгуулсан нь сэтгүүлчдийн хувьд ихээхэн өгөөжтэй болж чадсан. “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн энэ удаагийн сургалтыг зохион байгуулахад нь Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын алба дэмжин оролцсон юм.

“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн энэ удаагийн сургалтад **Монголын Байгаль орчны мэргэжилтнүүдийн холбооны Гүйцэтгэх захирал Д.Өлзийбаяр, Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо ТББ-ын Гүйцэтгэх захирал Б. Ихбаяр** нар уригдан оролцож, уул уурхайн нөхөн сэргээлт, байгаль орчны менежмент, байгаль орчны хохирол тооцох аргачлал, үнэлгээний талаар танилцуулга хийсэн юм.

Үүний дараа “Мэдээллийн цаг” хөтөлбөрт **Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Ц.Баатарцогт** болон тус агентлагийн хэлтсийн дарга нар оролцож, эрдэс баялгийн салбарын цаг үеийн мэдээллийг өгч, орон нутгийн сэтгүүлчдийн асуултад хариуллаа. Мэдээллийн цагийг орон нутгийн сэтгүүлчдийн хүсэлтээр зохион байгуулдаг бөгөөд тэд орон нутаг дахь уул уурхайтай холбоотой бүхий л асуудлаар тодруулга авах, анхдагч эх сурвалжаас мэдээлэл хүргэх боломж энд бүрддэг юм. Ашигт малтмал, газрын тосны газрынхны хувьд энэхүү арга хэмжээнд гурав дахь жилдээ оролцож, орон нутагт тулгамдаж, хурцаар яригдаж буй уул уурхайн асуудал, шийдвэрүүдийн талаар хэлтсийн дарга нар чиглэл чиглэлээр хариулт өглөө.

Семинарын эхний өдөр ийнхүү уул уурхайн салбарын талаар мэдлэг мэдээлэл хүргэхэд чиглэсэн бол хоёр дахь өдрөө сэтгүүл зүйн салбарын асуудалд төвлөрсөн юм. Сэтгүүлчдийн нийтлэг гаргадаг алдаа, түүнээс зайлсхийх тухай, Цахим популизм буюу сонгууль дахь сошиал сүлжээний нөлөө, Медиа зах зээлд гарч буй өөрчлөлт хандлага зэрэг чухал бөгөөд шинэлэг сэдвүүдээр **МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн дэд профессор, доктор Б.Наранбаатар, Улс төрийн коммуникацийн хүрээлэнгийн захирал Ц.Мөнхцэцэг, “Ийгл” телевизийн Ерөнхий продюссер Ж.Хулан** нар илтгэл тавьсан нь сэтгүүлчдийн сонирхолд ихэд нийцсэн.

Б.Наранбаатар доктор сэтгүүлчдийн нийтлэг гаргадаг алдаар ёс зүй, хэл найруулга, баримт эх сурвалжтай харьцах байдал, үйл явцын хяналт, хариуцлага гэсэн дөрвөн хэсэгт ангилж, тус бүрээр нь нарийвчлан тайлбарлаж зөвлөгөө өгсөн. “Сэтгүүлч бол судлаач юм. Олон нийтийн нэрийн өмнөөс нийгэм, улс оронд болж буй үйл явдал үзэгдлийн талаар өөрт байгаа давуу талаа ашиглан бодит мэдээллийг бэлтгэн хүргэдэг. Иймд боловсруулалт дутуу байх, зөвхөн өөрийн таамагт нийцэх баримт цуглуулах, ээн холбогдогчгүй буруутгал оруулах зэрэг алдааг гаргаж үл болно” хэмээн Б.Наранбаатар доктор сэтгүүлчдэд зөвлөлөө.

“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн хүрээнд “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь сургалтад хамрагдсан орон нутгийн сэтгүүлчдийн оролцоог илүү үр дүнтэй болгож, сургалтаар олгосон мэдлэгийг бататгахын тулд нийтлэл нэвтрүүлгийн уралдаан зарлаж, дүгнэдэг уламжлалтай.

Энэ жилийн уралдааныг уул уурхай ба орон нутгийн харилцаа, байгаль орчны сэдвийн хүрээнд зарласан бөгөөд сэтгүүлчдээс таван нийтлэл, найман нэвтрүүлэг ирсэн юм. Орон нутгийн сэтгүүлчдийн бүтээлүүд нь асуудлыг газар дээрээс нь сурвалжилж, багагүй хүч хөдөлмөр гаргаж хийсэн бүтээлүүд гэдгээрээ онцлог.

Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн Дэд захирал О.Батболд, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор Б.Наранбаатар, Сэтгүүл зүйн ухааны доктор С.Энхцэцэг, The Mongolian Mining Journal сэтгүүл хариуцсан Орлогч эрхлэгч Н.Ариунтуяа, сэтгүүлч Г.Идэрхангай нарын бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж, уралдаанд ирсэн бүтээл бүртэй танилцсан юм. Дүгнэх журмын дагуу сэтгүүлчдийн бүтээлийг шинэлэг санаа, зохиомж, хэл найруулга, баримт, эх сурвалж ашигласан байдал, бичлэгийн үр чадварын үзүүлэлтээр 1-5 оноогоор дүгнэсэн.

Энэ удаагийн уралдааны Тэргүүн байрын эзнээр **Өмнөговь аймгийн “Алтанговь” телевизийн сэтгүүлч Н.Энхцэцэгийн “Золиослогдсон амьдрал” асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг** 105 оноогоор шалгарсан.

Нэвтрүүлгийн төрөлд хоёрдугаар байрт **Ховд аймгийн “Ховд” телевизийн сэтгүүлч, редактор С.Жавзандулам “Цаанаа учиртай Цагаан эрэг” цуврал эрэн сурвалжилсан нэвтрүүлэг** 98 оноогоор, нийтлэлийн төрлийн хоёрдугаар байрт **Дорноговь аймгийн МОНЦАМЭ агентлагийн сэтгүүлч Х.Эрдэнэбулганы “Нөхөн сэргээлтэд “МУУ” дүн тавихын учир” асуудал дэвшүүлсэн нийтлэл** 98 оноогоор тус тус шалгарсан юм.

Харин нийтлэлийн гуравдугаар байрыг **Дорнод аймгийн “Дорнод медиа” группын сэтгүүлч Э.Отгонтуяагийн “Хар алтны хар балаг” асуудал дэвшүүлсэн нийтлэл** 95 оноогоор, нэвтрүүлгийн төрөлд гуравдугаар байрыг **Төв аймгийн TBS телевизийн Ж.Хонгорбаатар, Ц.Ууганбаатар нарын “Юуг онцлов” асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг** 95 оноогоор эзэллээ.

Уралдаанд тэргүүлсэн сэтгүүлч Н.Энхцэцэгийг Герман улсад сургалтын аялалд оролцох эрхийн бичгээр шагнаж буйгаа Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөрийн захирал Др.Штефан Ханселманн зарласан юм. Хоёр, гуравдугаар байрт шалгарсан сэтгүүлчдийг өдөр тутмын ажил хэрэгт нь чухал хэрэгцээтэй таблет, нөутбүүкээр, уралдаанд бүтээлээ ирүүлсэн бусад сэтгүүлчдийг “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын зүгээс урамшууллаа. ■

“Оюутолгой” ХХК-ийн Олон нийттэй харилцах албаны дарга Ц.Ганзориг

# 2018.05.28-29

Төв аймаг. Монгол-Кувейтын Байгаль хамгаалах төв

Төслийн хүрээнд энэ онд нийт гурван удаагийн цуврал сургалт хийгдэх ба эхний сургалт тавдугаар сарын 28-29-ний өдрүүдэд Төв аймаг дахь Монгол Кувейтын байгаль хамгаалах төвд зохиогдлоо.

May 28-29, 2018

The first of the planned three trainings for this year was held in Tuv aimag.

Зохион байгуулагч:

Дэмжигч байгууллага:

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН 21 АЙМГИЙН НЭГДСЭН **СУРГАЛТ** 2018 ОН

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ төслийг 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд нийт 8 удаагийн цуврал сургалтад 21 аймгийн давхардсан тоогоор 100 гаруй сэтгүүлч хамрагдав.

Энэхүү төсөл 2018 онд “Оюутолгой” ХХК болон GIZ-ийн ЭТИС хөтөлбөр, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхмийн дэмжлэгтэй хэрэгжиж байна. Сургалтын эхний өдөр уул уурхай, эдийн засгийн сэдэвт чиглэсэн бол хоёр дахь өдөр сэтгүүл зүйн салбарын чиг хандлагын асуудалд төвлөрсөн юм.



"Уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө" сэдвээр **доктор Б.Түвшинтөгс** эдийн засаг дахь уул уурхайн салбарын дам нөлөө, эрдсийн түүхий эдийн ханшийн тандалт, таамгийг улсын төсөв болоод судалгаануудад хэрхэн тусгадаг талаар ерөнхий ойлголт өгсөн юм. Тэрээр дэлхийн зах зээл дэх түүхий эдийн ханшийн өсөлт, бууралтаас Монгол улсын эдийн засаг идэвхжиж, суларддаг онцлогийг индексээр харуулан тайлбарласан. Зах зээл дээр түүхий эдийн ханш унахад орлого биелэхгүй улсын төсөв хүндрэлд орох тохиолдолд эдийн засгийг тэлэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу улсын өр, төсвийн алдагдал, Засгийн газрын зарлагыг таазанд тулгаснаар эдийн засгийн хямрал нүүрлэдэг. Энэ байдлаас сэргийлж эдийн засаг идэвхжсэн мөчлөгийн үед Төв банк, Сангийн яамнаас мөнгөний зөв бодлого, зохицуулалт хийх боломж бий.

Улсын төсвийн тухайн жилийн онцлог, уул уурхайн салбарын орлого, үнэ ханшийн таамаглал, тооцоололд дүн шинжилгээ хийж уншигчдад хэрхэн ойлгомжтойгоор мэдээлэх, нийтлэл бичих талаар **ММЈ-ийн сэтгүүлч Б.Төгсбилэгт** "Төсөв бичих нь" сэдвээр илтгэж, өөрийн туршлагаас хуваалцав. ММЈ-ийн голлох уншигчид уул уурхайн салбарынхан тул төсвийн талаар бичихдээ уул уурхайн орлогод төвлөрч бичдэг бөгөөд төсвийг бичсэнээр улсын эдийн засгийг "том зураг"-аар нь харж чаддаг хэмээн сэтгүүлч Б.Төгбилэгт туршлагаасаа хуваалцав.

Тавантолгой ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэлхийн хөрөнгийн бирж дээр IPO гаргах, Монгол улсын иргэн бүрт хувьцаа хуваарилах асуудал ид яригдаж байгаа энэ цаг үетэй уялдуулан **MICC компанийн Ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ** "Хөрөнгийн зах зээл ба хувьцааны тухай анхан шатны ойлголтууд" илтгэлдээ хувьцаа, хөрөнгийн бирж, хувьцааны ногдол ашгийн талаарх анхдагч мэдээллийг өгөв. Монголд хөрөнгийн захыг хөгжүүлэх талаар ярьж, Mongolian Mining Corporation компани анх удаа олон улсын хөрөнгийн бирж дээр IPO босгож байсан 2010 онд ММЈ сэтгүүлийнхэн "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ-ыг байгуулж уул уурхай, эдийн засгийн чиглэлээр сэтгүүлчдийг мэргэшүүлэх анхны сургалтуудыг зохион байгуулахад Д.Ачит-Эрдэнэ багшаар уригдаж хувьцаа, хөрөнгийн зах зээлийн талаар хичээл зааж байсан юм.

Америкийн уул уурхайн инженерүүдийн нийгэмлэгийн захиалгаар Канадын Бритиш Колумбын Их сургуулийн Уул уурхайн тэнхимийн эрхлэгч Скот Дамбер олон нийтэд зориулан "Уул уурхай гэж юу вэ?" ном бичжээ. Бестселлер болсон тус номын агуулгад тулгуурлан **QMC компанийн Ерөнхий захирал М.Дагва** уул уурхайн салбарын тухай мэдвэл зохистой ерөнхий цогц ойлголтын талаар сэтгүүлчдэд илтгэл тавьсан юм. Гариг ертөнц дээр химийн элемент, ашигт малтмал хэрхэн бүрэлдэж тогтсоноос эхлээд уул уурхайн боловсруулах үйлдвэрлэл, уурхайн хаалт хүртэлх бүхий л шат, тэр бүгдэд мэргэжилтнүүдийн ажлын онцлогийг танин мэдэхүйн талаас нь тайлбарласан түүний хичээл сэтгүүлчдэд маш сонирхолтой байсан.

Б.Болд-Эрдэнэ

Д.Идэржаргал

Б.Төгсбилэгт

Энэ жил “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн дэмжигч байгууллагаар “Оюутолгой” компани оролцож байгаа юм. Тус компанийг орон нутагтай харилцах туршлагаасаа орон нутгийн сэтгүүлчдэд танилцуулна уу гэсэн хүсэлтийг зохион байгуулагчдаас тавьсан юм.

Тус компанийн **Хэвлэл мэдээлэл хариуцсан ахлах зөвлөх Ц.Ганзориг** “Хүмүүс бидний эдэлж хэрэглэж буй компьютер, ухаалаг утас, машин, барилга байшин гээд бүгдийг уул уурхайн үйл ажиллагааны үр дүнд үйлдвэрлэж бүтээдэг. Гурван жил амжилттай хэрэгжсэн “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөлд хамрагдсан сэтгүүлчид уул уурхайн чиглэлээр тодорхой мэдлэг мэдээлэл хуримтлуулж, уурхай үйлдвэрлэлтэй газар дээр нь танилцсан туршлагатай. Тиймээс хариуцлагатай уул уурхайн талаарх үнэн бодит тэнцвэртэй мэдээллийг мэргэжлийн түвшинд олон нийтэд түгээж чадна гэсэн итгэл үнэмшлээр “Оюутолгой” компани “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийг 2018 онд дэмжин ажиллаж байна” гэдгийг онцлов.

Сургалтын хоёр дахь өдөр сэтгүүл зүйн салбар болоод өнөөгийн чиг хандлагын талаар МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбар хариуцсан дэд захирал, доктор, дэд профессор Б.Болд-Эрдэнэ, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор, дэд профессор Б.Наранбаатар, тус тэнхимийн багш, докторант Д.Идэржаргал нар хичээл заав.

МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбар хариуцсан дэд захирал, доктор, дэд профессор Б.Болд-Эрдэнэ “Интернет орчин, сэтгүүл зүй, боломж” илтгэлээрээ мэргэжлийн сэтгүүл зүй, нийгмийн сүлжээний хоорондын ялгааны асуудлыг хөндсөн.

Сэтгүүл зүй нь нийгмийн дэг журам, хэм хэмжээ, үнэлэмжтэй холбоотойгоор анх бий болсон. Мэргэжлийн сэтгүүл зүй бол нийгмийн дэг журам, хэм хэмжээний эрх мэдэл, засаглалын түвшний байр суурь нь байх ёстой. Интернет, нийгмийн сүлжээ нь хувь хүн хоорондын харилцаа бөгөөд технологийн хувьсал, өөрчлөлтөөр мэдээллийн орон зайд орж ирсэн зүйл юм.

Нийгмийн сүлжээний мэдээлэл бол хүний сэтгэгдэл, нийгэмд илэрхийлэх, хуваалцах үзэл бодол болохоос биш цогц утгаар нь харвал бодитой баримтыг зорилготойгоор нийгмийн дэг журам, хэм хэмжээнд нөлөөлөхүйц түвшинд хүргэж чадахгүй.

Сэтгүүл зүй баримтад түшиглэх ёстой. Баримт бол сэтгүүлчдийн гол түүхий эд. Түүхий эдийг хэрхэн боловсруулах нь мэргэжлийн стандарт, чадвараар харагдана. Өнөөдөр баримт, тооны цаадах утга учир хамгийн үнэт капитал гэдгийг дэлхийн дахинд хүлээн зөвшөөрч байна. Хурдацтай хөгжлийг дагаад цаг зааваас хамаарч олон нийтийн хэрэглээнд мэргэжлийн сэтгүүл зүй хэвээр үлдэж, нийгмийн сүлжээний мэдээллийн эрэлт буурах нь ойлгомжтой хэмээн **Б.Болд-Эрдэнэ** багш үзэл бодлоо хуваалцав.

Тэгвэл интернет орчин, нийгмийн сүлжээнд мэдээллийн боловсрол, мэргэжлийн сэтгүүл зүй яагаад чухал болохыг **Д.Идэржаргал багш** "Сошиал медиа ба цахим мэдээллийн боловсрол" илтгэлдээ тайлбарласан.

2017 оны байдлаар улсын хэмжээнд 434 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 2000 гаруй сэтгүүлч ажиллаж байна. Сонин, сэтгүүл, радиогийн тоо сүүлийн жилүүдэд буурч байгаа бол телевизийнх тогтмол, мэдээллийн сайтынх хэлбэлзэлтэй байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр хэрэгжиж буй 665 хууль байгаагаас 14 нь сэтгүүл зүйн салбартай тодорхой хэмжээгээр холбоотойг "Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин ба сэтгүүлч" илтгэлдээ **Б.Наранбаатар багш** хөндөв.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төр, төрийн байгууллага, нийгэмд үйлчилж байгаа байгууллагууд иргэн хүнд хүссэн мэдээллийг тодорхой загвар хэлбэрээр, аргачлалаар өгөх ёстой. Төрийн байгууллагуудад үйл ажиллагаа төсөв санхүү, хүний нөөц, бараа үйлчилгээ, худалдан авалтын мэдээллээ нээлттэй байлгах үүрэг ногдуулсан. Энэ хуулиар иргэн бүр мэдээлэл авах эрхийг хангасан ч тэр бүр ийм хэрэгцээ, шаардлага иргэдэд байхгүй.

Гэхдээ хуулийг хэрэгжүүлж иргэдэд мэдэх үүрэгт нь үйлчлэх хүмүүс сэтгүүлчид юм. Энэ хууль сэтгүүлчдэд маш их мэдээллийн баазыг нээж өгсөн ч тэр мэдээллийг авч, ашиглаж, боловсруулж байгаа сэтгүүлчид ховор.

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2009 оноос хойш 4 хувилбар яригдаж ирсэн. Энэхүү хуулийг шинэчлэх болсон шалтгаан, ямар учраас өнөөг хүртэл батлагдахгүй байгаа нь сэтгүүлч мэдээллийн нууц эх сурвалжтай байж, шүүх дээр нууц эх сурвалжийг мэдээлэхгүй байх эрхийг хуульчлахаар оролдож буйд байгаа юм. Гэтэл нийгэм бэлэн биш, сэтгүүлчид сайн мэргэшээгүй, ёс зүй төлөвшөөгүй тохиолдолд сөрөг үр дүн гарахаас хууль боловсруулагчид болгоомжилж байна. Сэтгүүлч нууц эх сурвалжтай гээд хуурамч мэдээлэл зохионо гэсэн хардлага дагуулж байгаа. Монгол улсад мэдээллийн нууц эх сурвалжийг илчлэхийг заасан хуулийн зохицуулалт одоогоор байхгүй тэрээр хөндөн ярьсан билээ. ▪

2018 оны ес дэх удаагийн сургалтад 21 аймгийн хэвлэл мэдээллийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг редакциудын төлөөлөл 35 сэтгүүлч оролцсон юм.

**2018.10.**13-14

Өмнөговь аймаг. Цогтцэций, Ханбогд сум. Оюутолгойн уурхай

Сэтгүүлчид "Оюутолгой"-н Оюут ил уурхай, Баяжуулах үйлдвэр, Эрсдэлийг үзүүлэх төв болон гүний уурхайн бүтээн байгуулалттай бодитоор танилцав.

October 13-14, 2018

A team of journalists went on a study trip to the Oyu Tolgoi project, seeing operations at both the open pit and the underground mines, as also in the processing plant.

Зохион байгуулагч:

Дэмжигч байгууллага:

# "ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ" ТӨСЛИЙН 21 АЙМГИЙН **НЭГДСЭН СУРГАЛТ** 2018 ОН

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх "Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" ТББ орон нутгийн сэтгүүлчдийн уул уурхай, эдийн засгийн мэдлэг, ойлголтыг тэлэх үе шаттай сургалтуудын 2018 оны ээлжит сургалтыг "Оюутолгой" ХХК болон МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхим, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж байгаа бөгөөд 21 аймгийн нийт 35 сэтгүүлчид хамрагдаж байна.

2018 оны сургалт гурван үе шаттай үргэлжлэх юм. Өнгөрсөн тавдугаар сард сэтгүүлчид Улаанбаатар хотноо онолын семинарт хамрагдсан бол тэрхүү мэдлэг ойлголтоо бататган уул уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах үүднээс "Оюутолгой" компанийн уурхайн талбайд зочилсон юм.

Оюут ил уурхай 24 цагаар ажилладаг бөгөөд нэг ээлжиндээ 12 цагаар 560 орчим хүн ажиллаж байна. Өдгөө тус уурхай төлөвлөсөн хэмжээнээс давуулж буюу өдөрт 100 мянган тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 20.8 сая тонн зэс, 23,5 сая унц алтны нөөц бүхий Оюутолгой уурхай нь дэлхийд томоохонд тооцогдох зэс-алтны нөөцтэй ордын нэгд зүй ёсоор ордог.

Сэтгүүлчдийн хувьд энэ удаагийн аяллаас хамгийн сонирхолтой хэсэг нь Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт байлаа. Ил уурхайтай харьцуулахад эрдсийн өндөр агуулгатай гүний бүлэг орд нь Оюутолгойн ашиг орлогын гол цөм юм. Гүний уурхайн бүтээн байгуулалт таван жил үргэлжилнэ. Аравдугаар сарын байдлаар 20 км нэвтрэлт хийгдээд байна. Өдөрт ойролцоогоор 30-40 метр буюу сард 1000 метрийн нэвтрэлт хийж байгааг далд уурхайн инженерүүд хэлж байв.

Сэтгүүлчдийг Оюутолгойн үйл ажиллагаатай танилцах үеэр Эрсдэлийг үзүүлэх төвдөө аюулгүй ажиллагааг дагаж мөрдөөгүй, анзааргагүй, хэнэггүй байдлаас болж ямар аюултай нөхцөл байдалд орж болохыг ойлгуулсан богино хугацааны өгөөжтэй сургалтыг зохион байгуулсан юм.

Түүнчлэн сэтгүүлчид Ханбогд суман дахь "Малын эрүүл мэндийн төв", "Цэвэр усны байгууламж", "Мод үржүүлгийн төв", "Мэргэжил сургалтын төв", "Үлэмжийн чанар" соёлын төвийн үйл ажиллагаатай танилцлаа. ■

Ийнхүү 21 аймгийн 35 сэтгүүлч "Оюутолгой" компанийн төслийн талбайд зочилж, өмнийн говьд өрнөж буй их бүтээн байгуулалтын эрчмийг мэдрээд нутаг нутгийн зүг хүлгийн жолоо заллаа. ■

# 2018.04.10

Улаанбаатар хот. Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн оффис

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас сэтгүүлчдийг чадавхжуулах 2018 оны ээлжит ШИНЭ ХӨТӨЛБӨР эхлүүлж байна.

April 10, 2018

A new programme is started by Journalism for Development NGO with support from GIZ IMRI, under which selected UB or central journalists would act as individual mentors for local journalists chosen for skill enhancement.

## СЭТГҮҮЛЧДИЙГ УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭШҮҮЛЭХ МЕНТОРШИП ХӨТӨЛБӨР ЭХЭЛЖ БАЙНА

Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөр нь “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөлд хамтран ажиллахын зэрэгцээ 2016-2017 онд эдийн засаг, бизнесийн чиглэлээр мэргэшиж буй төвийн сэтгүүлчдэд зориулан онол, дадлагын сургалтын төслийг Австралийн Квийнсландын их сургуультай хамтран хэрэгжүүлсэн билээ. GIZ-ийн ЭТИС хөтөлбөр, Хөгжлийн төлөө сэтгүүл зүй ТББ хамтран энэхүү хоёр төслийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулан өргөжүүлж, 2018 онд төвийн сэтгүүлчид орон нутгийн сэтгүүлчдэд туршлага, ур чадвараа ээзмшүүлэх Менторшип хөтөлбөрийг зохион байгуулан ажиллаж байна.

Менторшип програм нь төвийн сэтгүүлчид орон нутгийн сэтгүүлчдэд ажлын бодит туршлага өгч, халамжлан сургах байдлаар медиа салбарын орчин цагийн чиг хандлагатай нийцэн ажиллахыг практикаар заах зорилготой.

Менторшип хөтөлбөрт дээрх хоёр төсөлд хамрагдсан сэтгүүлчдээс нийт 16 сэтгүүлч сонгогдсон. Дагалдан суралцах ментий буюу 8 сэтгүүлчийг “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөлд хамрагдсан GIZ-ийн ЭТИС хөтөлбөр хэрэгжүүлэгч Баянхонгор, Сэлэнгэ, Увс болон Өмнөговь, Дорнод аймгаас нийт 8 сэтгүүлч сонгогдон суралцаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд 6 сарын хугацаанд 3 удаа нийтийг хамарсан суралцах, туршлага солилцох арга хэмжээ зохион явуулахаар төлөвлөсөн. ■

# 2018.04.23-24

Улаанбаатар хот. The Mongolian Mining Journal сэтгүүлийн редакц

Ментор болон Ментийгээ сонгох, танилцах, хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнг танилцуулах, хамтын ажиллагаагаа ярилцах уулзалт Улаанбаатар хотноо 2018 оны 4 дүгээр сар 23-24-ний өдөр зохиогдов.

Сэтгүүлчид эхний өдөр танилцаж, зорилгоо тодорхойлон, хөтөлбөрийн хугацаанд хамтран ажиллах арга барил, хийх ажлуудаа төлөвлөв.

Хоёр дахь өдөр Орон нутгийн сэтгүүлчид төвийн хэвлэлийн редакци буюу Ментор нарын ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай танилцаж, ажлын арга туршлагаас суралцсан. Мөн Ментор сэтгүүлчийнхээ санал болгосон арга хэмжээнд оролцож, байгууллага, хүмүүстэй уулзалт хийв. ■

# 2018.07-10

Ментор сэтгүүлч Ментий сэтгүүлчийн Орон нутаг дахь хэвлэлийн редакцид томилолтоор ажиллаж, туршлага ур чадвараа солилцох ажлыг 7-10 дугаар сарын хооронд Сэлэнгэ, Баянхонгор, Увс, Өмнөговь, Дорнод аймгуудад зохион байгууллаа.

Сэтгүүлчид энэхүү томилолтын үеэр орон нутгийн хэвлэлийн редакцид хоёр өдөр ажиллаж, чухал мэдлэг туршлагаа хуваалцан, амжилттай байх аргыг санал болгож, тодорхой арга туршлага зааж сурган ажилласан болно. Мөн дадлагын хугацаанд хамтран хийх нийтлэл, нэвтрүүлэг дээр ажиллаж, эх сурвалжуудтай уулзах ажлыг зохион байгуулав.

Ментор Б.Ариунзаяа Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын “Мандал” ТВ-д ажиллав.

The Mongolian Mining Journal-ийн сэтгүүлч, ментор Г.Идэрхангай “Говийн наран” ТВ-ийн үйл ажиллагаатай танилцан, ментий Д.Мишигсүрэн, С.Сумъяа болон ТВ-ийн бусад сэтгүүлчдийг хамруулсан “Хөгжлийн сэтгүүлч” сэдэвт уулзалт хийж, сэтгүүлчдэд зөвлөмж өглөө.

Ментор Д.Идэржаргал Дорнод аймгийн “Дорнод медиа” групптэй танилцав

Ментор Г.Сонинбаяр 2018 оны наймдугаар сард “Өнөөгийн Баянхонгор” сонины редакцитай танилцав.

Ментор О.Ариунбилэг Өмнөговь аймгийн “Алтан говь” ТВ-д ажиллав.



Ментор С.Насанжаргал Сэлэнгэ аймгийн “Миний Монгол” ТВ-тэй танилцав.

# 2018.10.30-31

Улаанбаатар хот. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн байр

Менторшип хөтөлбөр зургаан сарын хугацаанд амжилттай хэрэгжиж, үр дүнг хэлэлцэх, хамтын бүтээлийг тайлагнах хаалтын арга хэмжээ болов.

October 30-31, 2018

The Mentorship programme is concluded after six months, and a ceremony to mark its success discusses the experience, with some reports/programmes offered to attendees.

Хөтөлбөрийн хүрээнд ментий *(орон нутгийн сэтгүүлчид)* нар ментороор *(төвийн сэтгүүлчид)* сонгосон 2 хүний бүрэлдэхүүнтэй нийт 8 багт хуваагдан гурван удаагийн арга хэмжээний дагуу редакцдаа харилцан зочилж, туршлага солилцон суралцаж, хамтын бүтээл дээр ажиллалаа. Менторшип хөтөлбөр зургаан сарын хугацаанд амжилттай хэрэгжиж, үр дүнг хэлэлцэх, хамтын бүтээлийг тайлагнах хаалтын арга хэмжээ аравдугаар сарын 30-31-ний өдрүүдэд болов.

Хаалтын арга хэмжээнд Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөрийн захирал, хатагтай Karin Reinprecht, дэд захирал О.Батболд, The Mongolian Mining Journal-ын сэтгүүл хариуцсан орлогч эрхлэгч Н.Ариунтуяа нар оролцсон юм. Мөн энэ үеэр "Шилдэг Менторшип", "Шилдэг Ментор", Шилдэг Ментий"-ийг 1-10 онооны эрэмбээр шалгарууллаа.

Орон зайнаас үл хамааран ментор, ментий харилцан санал солилцох, хамтын байнгын ажиллагааны онлайн платформыг ашигласнаараа МУИС-ийн Сэтгүүл зүй, Олон нийтийн харилцааны тэнхимийн багш, www.ubn.mn сайтын редактор, сэтгүүлч Д.Идэржаргал (ментор), Дорнод аймгийн "Дорнод медиа" группын сэтгүүлч Э.Отгонтуяа нарын баг "Шилдэг Менторшип"-ээр тодров. Багийн хамтын ажиллагааны онлайн платформыг хөндлөнгөөс хөтөлбөрийн зохион байгуулагчид ажиглах нээлттэй байдал нь давуу тал болсон юм.

"Шилдэг Ментор"-оор шалгарсан gogo.mn сайтын Ерөнхий редактор О.Ариунбилэг менторын хувьд Өмнөговь аймгийн "Алтанговь" телевизийн сэтгүүлч С.Сумьяатай (ментий) хамтран багаар ажилласан. Тэрээр төв, орон нутгийн телевизүүдийн оргил цагийг харьцуулсан судалгааг танилцуулсан нь цаг үеийн шинэ мэдээлэл байсан бөгөөд орон нутгийн телевиз үзэгчдийн судалгаанд суурилан оргил цагтай уялдуулан мэдээгээ цацах, нэвтрүүлгээ төрөлжүүлэх зөвлөмжөөрөө бусад менторуудаас тэргүүллээ.

"Ардын эрх" сонины Хариуцлагатай нарийн бичгийн дарга, сэтгүүлч Г.Сонинбаяр ментортой багийн Баянхонгор аймгийн "Өнөөгийн Баянхонгор" сонины сэтгүүлч, khongor.mn сайтын Эрхлэгч Б.Чинбат "Шилдэг Ментий"-гээр тодорлоо. Түүний гол үзүүлэлт нь суралцах эрмэлзлээр өөрийн саналаар хөтөлбөрт хамрагдсан ба хөтөлбөрийн хүрээнд аймгийнхаа аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл санаачлан, тэрхүү төслийн санхүүжилтийг босгож чадсан байна. ■

(GIZ)-ийн ЭТИС хөтөлбөрийн захирал Karin Reinprecht

# 2018.09.26

Австралийн Квийнсланд мужийн төв Брисбэн хот, Виктория мужийн төв Мелбурн хот

Уул уурхай, эдийн засгийн сэтгүүлчдийн сургалт Австралид боллоо

September 26, 2018

Members of Journalism for Development NGO were in a group of journalists specializing in mining and economic issues invited to Australia to see how automation and other such innovation were changing the mining sector and to get acquainted with several areas of research.

Mining Journal · Оюу Толгой · германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT · Хэрэгжүүлэгч: giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

## “УУЛ УУРХАЙ, ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР СЭТГҮҮЛЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ” ХӨТӨЛБӨР

“Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр сэтгүүлчийг чадавхжуулах” хөтөлбөр нь төвийн хэвлэл мэдээллийн байгууллагууд телевиз, сонин, сэтгүүл болон сайтын эдийн засаг, уул уурхайн чиглэлээр дагнасан сэтгүүлчдийг мэргэшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор Монгол улсын эрдэс баялгийн салбар дахь гадаад хамгийн их хөрөнгө оруулалттай төслийн хэрэгжилт, дэлхийн томоохон төслүүдтэй харьцуулах болоод өндөр хөгжилтэй орны уул уурхайн салбар эдийн засагт нөлөөлөх байдалтай бодитоор танилцах боломжийг олгох юм.

Сургалтад сэтгүүлээс Mongolian Mining Journal, Asia Mining Magazine, Mongolian Economy, “Тойм”, сониноос “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Засгийн газрын мэдээ”, телевизээс МҮОНРТ, “Bloomberg Mongolia”, “Ийгл ТВ”, сайтаас gogo.mn, ikon.mn, eagle.mn, UB.life.mn болон МОНЦАМЭ агентлагийн төлөөлөл нийт 14 сэтгүүлч хамрагдаж байна. Сэтгүүлчдээс зарим нь “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй”-ээс зохион байгуулдаг бусад сургалтуудад мөн хамрагдаж байгаа.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эхний шатанд сэтгүүлчдэд онолын мэдлэг олгож, Монголын уул уурхайн салбарын өнөөгийн байдлын талаарх олон талт дэлгэрэнгүй мэдээллийг хүргэсэн байна. Үүн дээрээ үндэслэн сургалтад хамрагдсан сэтгүүлчид өөрсдийн сонгож авсан сэдвүүдийн дагуу нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн олны хүртээл болгожээ.

Хөтөлбөрийн дараагийн шатны онол, практикийн сургалтыг есдүгээр сарын 26-наас аравдугаар сарын 1-ний хооронд Австрали улсад зохион байгуулсан байна. Энэхүү сургалтын хүрээнд Монголын төвийн хэвлэл мэдээллийн эдийн засаг, уул уурхайн мэргэшсэн сэтгүүлчид Австралийн Квийнсланд мужийн төв Брисбэн хот, Викториа мужийн төв Мелбурн хотуудад ажиллажээ. Тухайлбал, Брисбэн, Мелбурн хотууд дахь “Рио Тинто” группийн оффис болон Мелбурн хотын Бандура дахь тус группийн судалгааны төв, Австралийн хэвлэл мэдээллийн салбарын хоёр том группийн нэг "Fair fax" медиа агентлагийн үйл ажиллагаатай танилцсан аж. Мөн Квийнсландын их сургуулийн сэтгүүл зүйн тэнхим болон тус сургуулийн Тогтвортой хөгжил, эрдэс баялгийн хүрээлэнгийн багш, профессорууд уул уурхайн ба сэтгүүл зүй, Австралийн сэтгүүл зүйн өнөөгийн төлөв байдал, тулгарч буй сорилт, бэрхшээл зэрэг сэдвээр сургалт явуулжээ.

Монгол, Австралид цувралаар зохион байгуулагдсан сургалтын үр дүнд эдийн засаг, уул уурхайн сэтгүүлчдийн бичсэн нийтлэл, сурвалжлагуудаар эмхэтгэл гаргахаар төлөвлөжээ. “Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр сэтгүүлчийг чадавхжуулах” хөтөлбөр нь төвийн хэвлэл мэдээллийн байгууллагууд телевиз, сонин, сэтгүүл болон сайтын эдийн засаг, уул уурхайн чиглэлээр дагнасан сэтгүүлчдийг мэргэшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь гадаад хамгийн их хөрөнгө оруулалттай төслийн хэрэгжилт, дэлхийн томоохон төслүүдтэй харьцуулах болоод өндөр хөгжилтэй орны уул уурхайн салбар эдийн засагт нөлөөлөх байдалтай бодитоор танилцах боломжийг олгож байгаагаараа онцлог юм. ■

Рио Тинто-гийн Брисбэнд дэх оффис



Квийнслэндийн их сургуулийн Механик, уул уурхайн инженерингийн сургуулийн Виртуал лаборатор



"Fairfax Media" агентлагийн Australian Financial Review сонины редакц

THE JOURNALISM FOR DEVELOPMENT

2010-2018

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ СЭТГҮҮЛ ЗҮЙ

# СЭТГҮҮЛЧДИЙН БАГ

## Journalists` team

Уул уурхай, эдийн засгийн сэдвээр мэргэшсэн сэтгүүлчдийн баг ажилладаг. The Mongolian Mining Journal-ийн сэтгүүлчид сэтгүүл зүйн шагналыг байнга хүртдэг, мэргэжлийн туршлагатай баг юм.

The Mongolian Mining Journal is committed to independent journalism and is not affiliated with any company, political party or individual. An experienced team of journalists covers all facets of mining and relevant economic issues. Its members have won several awards in recognition of their journalism skills.

**2014.05.10**
Канад, Ванкувер

Канад байгалийн нөөцөөр баялаг орон. Туулсан туршлага, алдсан алдаа, авсан сургамж бүхнээ хуваалцахаар богино хугацааны сургалтын хөтөлбөрийг Монголын төлөөлөгчдөд тусгайлан зориулж гаргасан юм.
Канадын олборлох салбарын үйлдвэр болон хөгжлийн олон улсын хүрээлэн /CIIEID/-гийн урилгаар Канадын уул уурхайн салбарын туршлагатай танилцах багт төрийн болон төрийн бус байгууллага, их сургууль, судалгааны байгууллага, хэвлэл

мэдээллийн салбарын төлөөл-лийн хамт The Mongolian Mining Journal сэтгүүлийн Орлогч эрхлэгч Н.Ариунтуяа багтсан юм.

**2015.03.27**
Улаанбаатар

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь Монголоос хальж, дэлхий рүү хандсан ба үүний нэг гэрч нь Канадын Бритиш Колумбын их сургуулийн Норман Б.Кийвлийн нэрэмжит Уул уурхайн сургуулийн төлөөллүүд Mongolian Mining Journal-ын редакцид зочилсон уулзалт юм.Тус Институтийн дэлхийд нэр хүндтэй профессорууд MMJ-ийн Редакцийн байнгын зочин болдог.

## 2017.04.17
Гүрж. Тбилиси хот

Байгалийн баялгийн нөөцтэй, улсынх нь төсөв уул уурхайн орлогоос хамааралтай, улс дамнасан томоохон корпорациуд олборлох үйл ажиллагаа явуулдаг, эдийн засгийн хувьд дундаж хөгжилтэй орнуудын эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангахад сэтгүүлчдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилготой сургалт Тбилиси хотноо зохиогдсон юм.

Ийм төрлийн сургалтыг улс орнуудаар бүсчлэн зохиох бөгөөд энэ удаад Төв болоод Дунд Азийн бүс нутгийн Монгол, Киргиз, Азербайжан, Узбекистан, Украйн, Гүрж улсын сэтгүүлчдийг хамруулсан ба Монголоос The Mongolian Mining Journal-ын Э.Оджаргал оролцоод ирлээ.

## 2017.04.22
Австрали

MMJ-ийн сэтгүүлчид Австралийн Квийнсландын их сургуулийн эдийн засаг, бизнес, уул уурхайн сэтгүүл зүйн онол, практикийн мэргэжлийн сургалтад хамрагдан төгсөв.





Эдийн засаг, уул уурхайн сэтгүүлчдийг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилготой Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга төслийн хүрээнд Монголын арав гаруй сэтгүүлч Австралийн уул уурхайн хөгжил, дэвшилтэй танилцахаар Квийнсланд мужийн төв Брисбэнд хүрэлцэн очсон. Бүтэн жил үргэлжилсэн сэтгүүл зүй, уул уурхайн сэдэвт дөрвөн удаагийн онолын сургалт явуулсны сүүлийн шатны практик сургалтийнхүү Австрали оронд эхэлсэн юм.

Дөрвөн шатны сургалтыг Квийнсландын их сургуулийн сэтгүүл зүйн профессор Брюс Вүүлэй, тус сургуулийн Эрдэс баялгийн тогтвортой хөгжлийн институтын (ЭБТХИ) дэд захирал Робин Эванснар удирдан явуулсан билээ.

## 2018.06.11

ХБНГУ. Бонн

Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөр, The Mongolian Mining Journal-ийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ хамтран “Сэтгүүлчдийн менторшип хөтөлбөр”-ийг 2018 онд зохион байгууллаа.

“Менторшип” хөтөлбөрийн ментороор сонгогдсон сэтгүүлчид тавдугаар сард ХБНГУ-ын Бонн хотноо болсон Global Media Forum-д оролцон, Германы Дойче Вилле академи болон Хамбах болон Гразвейлерийн хүрэн нүүрсний уурхайн үйл ажиллагаатай танилцсан юм. The Mongolian Mining Journal-ийн редактор Г.Идэрхангай уг хөтөлбөрийн ментороор ажиллахдаа Дойче Виллед сэтгүүлчдээ төлөөлөн ярилцлага өглөө.

## 2018.09.26

Австрали. Мельбурн

Энэ удаагийн аялал уул уурхайн дижитал технологи буюу автоматжуулалт, инновацид илүүтэй чиглэснээрээ онцлог байлаа. Аяллаар сэтгүүлчид “Рио Тинто”-гийн Брисбэн хот дахь Өсөлт, инновацийн салбар болон Мельбурн хот дахь Технологи хөгжүүлэлтийн төв, Австралийн Квийнслэнд мужийн Уул уурхайн ассоциаци, Квийнслэндийн их сургуулийн харьяа Тогтвортой эрдэс баялгийн хүрээлэн (Sustainable Minerals Institute) болон голлох хэвлэл мэдээлэл болох Fairfax-ийн дэргэдэх Australian Financial Review сонины редакцийн үйл ажиллагаатай танилцлаа.

Монголын сэтгүүлчид дэлхийн шилдэг уул уурхайн орон болсон Австралийн уул уурхай, тэр дундаа “Рио Тинто” компанийн инноваци, ноу-хаутай танилцлаа.

Иймд уг ажлыг “Mongolian Mining Journal”-ийн дэргэдэх сэтгүүлчдийг чадавхжуулах зорилго бүхий “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь “Оюутолгой” компани болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр амжилттай хамтран зохион байгуулсан юм.

# THE MONGOLIAN MINING JOURNAL МСНЭ-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ХҮРТЭВ

The Mongolian Mining Journal нь Монголын сэтгүүлчдийн эвлэлийн 2008, 2012, 2013, 2016 оны Үндэсний шилдэг сэтгүүлээр тус тус шалгарчээ.

Монголын сэтгүүлзүй, хэвлэл мэдээллийн салбарын Оны шилдгүүдийг шалгаруулах ёслолын ажиллагаа 2016 оны арванхоёрдугаар сарын 9-ний өдөр болов.

The Mongolian Mining Journal сэтгүүл Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналын эзнээр тодорсон юм. Тус сэтгүүлийн Редакциас 2016 онд орон нутгийн сэтгүүлчдийг давтан сургах, чадавхжуулах зорилгоор “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл хэрэгжүүлсэн бөгөөд уг төслийг онцлон МСНЭ-ээс мэргэжлийн сэтгүүлзүйг төлөвшүүлэхийн төлөөх оны шилдэг үйл ажиллагаа хэмээн үнэлж ийн шагнасан байна.

The Mongolian Mining Journal сэтгүүлийн Редакц нь эдийн засаг, уул уурхай сэдвээр нийтлэл бэлтгэн олон нийтэд хүртээмжтэй түгээхээс гадна эдийн засаг, уул уурхайн сэдвээр бичих сонирхолтой сэтгүүлчдэд мэргэшин, суралцах хэрэгцээ шаардлага зайлшгүй байгааг харгалзан Эрхлэгч Л.Болормаагийн санаачилгаар “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” төрийн бус байгууллагыг 2010 онд байгуулан ажиллуулж ирсэн билээ. Монголын сэтгүүлчид тодорхой сэдвээр мэргэшин, шинжээчийн түвшинд бичих, нэвтрүүлэх чадвартай, бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэх, бие биедээ харилцан тусалж, мэдлэг туршлагаа солилцох, орчин цагийн дэлхийн сэтгүүл зүйн өндөр стандартыг нутагшуулахын тулд өөрсдөө бие даан холбоо харилцаа тогтоон ажиллаж чадахыг The Mongolian Mining Journal сэтгүүлийн Редакц бүхий л үйл ажиллагаагаараа харуулахыг чармайн ажиллаж ирсний илрэл нь “Хөгжлийн төлөө сэтгүүлзүй” юм.

Сэтгүүлчдийн туршлага, мэдлэг, боловсрол адилгүй ч сэтгүүл зүйн салбарын онцлог, хариуцлага, олон нийтийн өмнө хүлээсэн үүргийн талаарх байр суурь ижил байх ёстой. Тиймээс 2015 онд орон нутгийн сэтгүүлчдийн эдийн засаг, эрдэс баялгийн салбарын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэхийн тулд тодорхой төсөл хэрэгжүүлэх зорилт тавьсан юм. Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийг 2015 онд амжилттай эхлүүлж, 2016 онд ахьсан түвшинд үргэлжлүүлэн нийт 6 удаагийн цуврал сургалт Сэлэнгэ, Баянхонгор, Өвөрхангай аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлэв. Сургалтад хоёр жилийн хугацаанд 16 аймгийн 70 орчим сэтгүүлч хамрагдсанаас 35 нь тогтмол оролцсон байна.

Орон нутгийн сэтгүүлчдийг давтан сургах энэхүү үйл ажиллагаа нь хэвлэл мэдээллийн байгууллага зөвхөн мэдээлэх, мэдээллийг түгээснээр ажил үүргээ хязгаарлах биш мэргэжлийнхээ, салбарынхаа эрх ашиг, хөгжил, төлөвшлийн төлөө оруулж буй хувь нэмэр юм. ■

Хэвлэл мэдээлийн гадаад, дотоодын цөөнгүй мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Тэдний нэг нь МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхим ба Хөгжлийн төлөө сэтгүүл зүйн сургалтаар мэргэжлийн багш нар тогтмол хүрэлцэн ирж илтгэл тавьдаг.

# М.ЗУЛЬКАФИЛЬ:
## СЭТГҮҮЛ ЗҮЙН ОЮУТНУУДАД ММJ-ГЭЭС СУРАЛЦАХ ЗҮЙЛ ИХ БИЙ

"Mongolian Mining Journal"-ийн хамт олон анхны дугаараасаа эхлээд дөрвөн жилийн хугацаанд хэвлэн гаргасан сэтгүүлүүдээсээ МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд бэлэглэлээ. ММJ нь сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын бие даалт, дипломын ажлын судалгааны материал болдог учир ирээдүйн сэтгүүлчдэд оюуны хөрөнгө оруулалт хийж, 150 ширхэг сэтгүүлийг Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч М.Зулькафиль багшид гардуулалаа.

Тэрбээр, Уул уурхай, эдийн засгийн чиглэлийн мэргэжлийн сэтгүүлийн дөрвөн жилийн дугааруудаар манай номын сан баяжиж байгаад сэтгэл өндөр байна. Сүүлийн жилүүдэд тогтмол хэвлэлийн хөгжилд гарч байгаа томоохон өөрчлөлт нь сэтгүүл эрс нэмэгдэж байгаа явдал юм. Бүрэн бус тоогоор 130 гаруй сэтгүүл зах зээлд гарч байгаа гэсэн тоо бий. Ялангуяа сүүлийн 2-3 жилд өнгөт, рекламын шинжтэй зузаан сэтгүүлийн тоо нэлээд нэмэгдсэн. Харин тодорхой нэг чиглэлийг бариад, нарийн судлан гүнзгийрүүлж бичихийн хажуугаар англи, монгол хоёр хэл дээр гардаг сэтгүүл ховор.

ММJ нийтлэлийн бодлогоороо бусдаас ихээхэн ялгардаг. Өдөр тутмын мэдээллээс гадна анализ хийсэн, асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт материалууд ихээхэн гардаг нь анзаарагддаг. Түүнээс гадна тойм маягийн шинжлэлт бүтээлүүд нийтэлдгийг нь ур чадварын хувьд сайн байгаагийн илрэл гэж дүгнэдэг.

Бичлэг, бичлэгийн төрөл зүйл, ур чадвар, дизайн, өнгө үзэмж, гээд олон талаас нь суралцах боломжтой. Шинээр олон сэтгүүл гарч байгаа энэ үед манай оюутнуудын тодорхой хувь нь төгсөөд сэтгүүлд ажиллах болно. Оюутны ширээнд байхаасаа сэтгүүлийн талаар гүнзгий мэдлэгтэй байх нь өнөөгийн цаг үеийн шаардлага боллоо. Тиймээс та бүхний бидэнд бэлэглэсэн оюуны дэмжлэг маш өндөр ач холбогдолтой юм" гэлээ.

Эдийн засгийн сэдэвтэй сэтгүүл зүйн бүтээлд
нэр нь хамгийн олон удаа дурдагдсан эдийн засагч,
шинжээч, нийгмийн зүтгэлтнийг тодруулах

СУДАЛГАА

Улаанбаатар хот
2010 он

The Mongolian Mining Journal нь судалгааны мэргэжлийн байгууллагуудтай хамтран уул уурхай, эдийн засгийн чиглэлээр судалгаа, санал асуулга тогтмол явуулдаг.

"Эдийн засгийн сэдэвтэй сэтгүүл зүйн бүтээлд нэр нь хамгийн олон удаа дурдагдсан эдийн засагч, шинжээч, нийгмийн зүтгэлтнийг тодруулах судалгаа"-г Монголын Хэвлэлийн х□рээлэнтэй хамтран 2010 оны эхний хагасын хэвлэлүүдэд түшиглэн MMJ хийсэн бөгөөд олон нийтийн зүгээс тавьж буй "Яагаад, яаж" хэмээх асуултуудын хариуг өгөхийг чармайсан нэр бүхий Эрхмүүд энд тодорчээ. Хөгжлийн зөв гарцын тухай хамгийн ихээр маргаж буй цаг үед олон нийт эдгээр хүмүүсийн байр суурийг сонсох, харьцуулан дүгнэхийг оролдсон байх аж.

ММJ судалгааны ажлаа цаашид тогтмолжуулан, уул уурхайн чиглэлээр т□лх□□ анализ хийнэ.

Судалгааны хугацаанд нийт 105 хүний 153 ярилцлага нийтлэгдсэн бөгөөд үүнээс Сангийн сайд С.Баярцогт 12 удаа (7.8%) ярилцлага өгч энэ төрөлд тэргүүлэв.

Удаах байрт эдийн засагч Д.Жаргалсайхан 6 удаа (3.9%), МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар 5 удаагийн (3.3%) ярилцлага өгснөөрөө жагсаж байна.

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль онцгой цаг үед мэндэлж байх цагт The Mongolian Mining Journal-ын Үүсгэн байгуулагч Л.Болормаа Хөгжлийн төлөө сэтгүүл зүй ТББ-ыг төлөөлөн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн хэлэлцүүлэг, Монголын Хэвлэлийн зөвлөлийг байгуулахад идэвхтэй оролцсон байна.

Ýäèéí çàñãèéí ñýäâýýð 2010 îíû ýõíèé õàãàñò õàìãèéí îëîí óäàà áàéð ñóóðèà èëýðõèéëñýí; áîäëîãî íºëººëæ ÷àäñàí; îëîí íèéò ¿ãèéã íü ñîíñîõûã õ¿ññýí íîìèíàöèóäààð øàëãàðñàí Íàéìàí Ýðõýìä MMJ øàãíàëûã íü ãàðäóóëëàà.

2010 îíû äîëäóãààð ñàð

# WWW.JOURNALISM.MN

WWW.JOURNALISM.MN

WWW.JOURNALISM.MN

www.journalism.mn

Энэхүү сайт нь сэтгүүлзүйн мэргэжлийн стандартыг өргөх, ажил үүргээ гүйцэтгэж яваа жирийн сурвалжлагчдыг дэмжин, хөгжүүлэх зорилготой.




“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас сэтгүүлчдэд зориулсан сайтыг (journalism.mn) үүсгэн байгуулж, нэгдсэн цогц мэдээллийг авах чөлөөт платформ болгохыг зорьсон. Баялаг архив, цогц бүтцийн хувьд сэтгүүл зүйн салбарт анхдагч сайт болсноороо онцлог юм.

www.journalism.mn сайт нь мэдээллийн хэрэгслийн шинэ менежмент, технологийн шинэчлэлтэй танилцах, дэлхийн сэтгүүлчдийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх, сургалтын зар, сэтгүүлчдийн ном товхимол танилцуулах, чанартай уран бүтээлийг ивээн тэтгэх үйл ажиллагаа болон санал асуулга, электрон сэтгүүл зүй, гэрэл зураг, шог зураг, комиксийн төрлийг хүчтэй дэмжин хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж, залуу сэтгүүлчдийн байр сууриа илэрхийлэх нээлттэй талбар, дэмжигчдийн фэн клубүүдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх индэр байх юм.

## www.journalism.mn англи хэл дээр

Шинэ Монголын үзэгч, уншигчдын эрэлтэд нийцсэн сэтгүүл зүйн бүтээгдэхүүнийг залуу сэтгүүлч Та бэлтгэн цацаж байгаад талархал илэрхийлье. Өргөн том дэлхийн энтэй сэтгэж, цараатай ажиллах болсон шинэ үеийн сурвалжлагчдад www.journalism.mn сайт мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг ямагт зорьдог. Сурвалжлагч Та тус сайтын англи хэл дээрх хувилбарыг хүлээн авч байна.

Эндээс Та сэтгүүл зүйн Олон улсын давтан сургалтууд, Мастерын сургалтын зарлал, Олон улсын уралдаан шалгаруулалт, хурал уулзалтад оролцох, хэвлэлийн редакциудад дадлага хийх, эрхээ хамгаалуулах, дуу хоолойгоо ертөнцийн сэтгүүлчидтэй нэгтгэх өргөн боломжийг өөртөө нээнэ.

Залуу сэтгүүлч Танд мэдлэг, эр зориг, урамшил гурав ус агаар лугаа хэрэгтэй байгаа гэдэгт үл эргэлзэнэ.






# ХӨГЖИЛ СТУДИ

## телевизийн хөтөлбөр

The Mongolian Mining Journal дэргэдээ телевизийн хөтөлбөр бэлтгэх баг шинээр байгуулж, 2011 оны гуравдугаар сард студийн танхимаа тохижуулж эхэлсэн. Тэр өдрөөс хойш “Хөгжил” студийн 80 гаруй уран бүтээлийн нэвтрүүлэг төрж, телевизийн олон сувгаар үзэгч олонд хүрчээ.

2011 оны дөрөвдүгээр сард “Хөгжил” студийн уран бүтээлчид анхны зураг авалтдаа гарсан билээ. Хаврын хавсарга нүдсэн бүүдгэр өдрүүдэд манай уран бүтээлчид гэгээлэг нэвтрүүлэг хийхээр өмнийн говийг зорьсон...

Танин мэдэхүйн нэвтрүүлгээс гадна уул уурхайн үйлдвэрлэл дэх технологийн дэвшлийг харуулсан төрөл бүрийн нэвтрүүлгийг Монголын телевизийн урлагт анх удаа мэргэжлийн түвшинд хийж байна. “Хөгжил” студийн бэлтгэсэн нэвтрүүлгүүдийн архивыг **www.mongolianminingjournal.com** сайтын “Видео” хэсгээс үзэх боломжтой.



Найруулагч
Х.ГАНБААТАР



Зураглаач
М.ЭНХ-АМГАЛАН

Монгол орны эрдсийн салбарын эрх зүй, хөрөнгө оруулалтын орчны талаарх анализ, мэтгэлцээн зэрэг асуудлыг олон талаас нь харуулсан нэвтрүүлгийг “Хөгжил” цацдаг. Уран бүтээлийн хөтөлбөрөөс гадна телевизийн шторк, баримтат кино зэргийг уул уурхайн салбарын тухай баялаг статистик, дуу, дүрсний архивтаа үндэслэн манай хамт олон бэлтгэдэг.

Өнгөрсөн жилүүдэд Монголын уул уурхайн салбарт өрнөсөн томоохон бүхий л үйл явдлын баялаг архив “Хөгжил” студид хадгалагдаж байна.

www.journalism.mn
info@journailsm.mn

976-7722-0200,
976-7722-0900,
976-7722-2400